



# ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗҮЙ





Санхүүжүүлэгч Европын Холбоо



# ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗҮЙ

Цагдаагийн байгууллагын мөрдөгч, хүүхдийн  
асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд  
зориулсан гарын авлага

УЛААНБААТАР  
2022 ОН



## **МОНГОЛ УЛСАД ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ**

Европын холбооны санхүүжилтээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын хэрэгжүүлж буй “Монгол Улсад хүүхдийн хууль зүйн тусалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулах төсөл”-ийн хүрээнд уг гарын авлагыг бүтээв.

Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулан, ялангуяа Ковид-19 цар тахлын үед хууль зөрчсөн, сэжигтэн, гэрч, хохирогч болон эрсдэлт бүлгийн хүүхдэд хүрч үйлчлэх хууль эрх зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

### **ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:**

Х. БААВГАЙ, Доктор(Ph.D), дэд профессор  
Г. ОЮУНБОЛД, Хууль зүйн магистр

### **ГАРЫН АВЛАГА ХЯНАСАН:**

- |                  |                                                                                                                                             |
|------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Э. БАЯРБАЯСГАЛАН | Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч                    |
| П.ЭРДЭНЭБИЛЭГ    | Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа |
| Г.ЗОЛЖАРГАЛ      | Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч        |

Зохиогчийн эрх@2022. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)

Энэ гарын авлагын агуулга, үзэл бодлыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, түүний гишүүдийн үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

Зохиогчийн эрхийн дагуу хамгаалагдсан. Энэхүү гарын авлагыг сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглаж болно. Үүнээс өөр шалтгаанаар олшруулах, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно. Дахин хэвлэх бол Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авна.

@Хавтасны зургийг Цагдаагийн Ерөнхий Газрын зөвшөөрлөөр хэвлэн нийтлэв.

[www.idlo.int](http://www.idlo.int)

Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж,  
Бодь цамхаг, 603 тоот  
Улаанбаатар 15160, Монгол Улс

# ГАРЧИГ

|                                                                                                                      |            |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| <b>ӨМНӨХ ҮГ .....</b>                                                                                                | <b>5</b>   |
| <b>НЭГ. ХҮҮХДИЙН ЭРХ БА ШИНЭ ҮЕИЙН ОХИД, ХӨВГҮҮДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ, ХЭВ МАЯГ .....</b>                     | <b>6</b>   |
| 1.1. ХҮҮХДИЙН ЭРХ БОЛОН ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ .....                                                     | 7          |
| 1.2. ЖЕНДЭР БА ОХИД, ХӨВГҮҮДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ .....                                                       | 11         |
| 1.3. ШИНЭ ЗУУНЫ БУЮУ “Z” ҮЕИЙН ӨСВӨР НАСНЫХНЫ ОНЦЛОГ, ХЭВ МАЯГ .....                                                 | 22         |
| <b>ХОЁР. ХҮҮХДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ЗҮЙ .....</b>            | <b>30</b>  |
| 2.1. ХҮҮХЭД ОРОЛЦСОН, ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ .....          | 33         |
| 2.2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА .....                                                  | 40         |
| 2.3. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ НЬ .....                                     | 55         |
| 2.4. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН АРГА ЗҮЙ .....                                                   | 93         |
| <b>ГУРАВ. СУРГАГЧ БАГШИЙН УР ЧАДВАР, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....</b>                                                    | <b>107</b> |
| 3.1. АНДРАГОГ СУРГАЛТ ГЭЖ ЮУ? .....                                                                                  | 107        |
| 3.1. СУРГАГЧ БАГШ НАРТ ЗАЙЛШГҮЙ БАЙХ УР ЧАДВАР .....                                                                 | 110        |
| 3.2. СУРГАГЧ БАГШИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, НАСАНД ХҮРЭГЧДИЙГ СУРГАХ АРГА ЗҮЙ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ТАЙЛАГНАХ ..... | 113        |
| <b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .....</b>                                                                        | <b>123</b> |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---

|                  |                                                                        |
|------------------|------------------------------------------------------------------------|
| <b>ГБХЗХГ</b>    | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар                              |
| <b>ГБХЗХХ</b>    | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс                             |
| <b>ГХУСАЗЗАА</b> | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба |
| <b>ОУЭЗХБ</b>    | Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага                               |
| <b>ХХҮГ</b>      | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар                                     |
| <b>ХНХЯ</b>      | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам                                       |
| <b>ХЗДХЯ</b>     | Хууль зүй дотоод хэргийн яам                                           |
| <b>ХЭХЗХ</b>     | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо                                       |
| <b>ЦЕГ</b>       | Цагдаагийн ерөнхий газар                                               |
| <b>ХЭССХ</b>     | Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн                           |
| <b>ТББ</b>       | Төрийн бус байгууллага                                                 |
| <b>ҮСХ</b>       | Үндэсний статистикийн хороо                                            |
| <b>СХД</b>       | Сонгинохайрхан дүүрэг                                                  |
| <b>ХЧААХАХ</b>   | Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэд             |
| <b>МУЗГ</b>      | Монгол Улсын Засгийн Газар                                             |
| <b>НҮБХЭХ</b>    | НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо                                           |
| <b>БЗД</b>       | Баянзүрх дүүрэг                                                        |
| <b>ЦГ</b>        | Цагдаагийн газар                                                       |
| <b>ХЭК</b>       | Хүүхдийн Эрхийн тухай Конвенц                                          |
| <b>НҮБ</b>       | Нэгдсэн Үндэстний Байгууллага                                          |
| <b>ХХША</b>      | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа                                       |
| <b>ХЁТ</b>       | Хууль ёсны төлөөлөгч                                                   |
| <b>АХХД</b>      | Асран хамгаалагч харгалзан дэмжигч                                     |
| <b>СХТБ</b>      | Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага                                  |
| <b>ЭХХШТХ</b>    | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль                            |

## ӨМНӨХ ҮГ

---

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага нь энх тайван, шударга ёс, тогтвортой хөгжлийг дэмжин, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хууль эрх зүйн салбарт шинэчлэл хийх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд улс орнуудын засгийн газар болон ард иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэн ажилладаг байгууллага юм. 2012 оноос Монгол Улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд болон олон улсын хамтын нийгэмлэгтэй үр бүтээлтэй хамтран ажиллаж байна.

Европын холбооны санхүүжилтээр “Монгол Улсад хүүхдийн хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулах төсөл”-ийг ОУЭЗХБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулан, ялангуяа Ковид-19 цар тахлын үед хууль зөрчсөн, гэрч, хохирогч болон эрсдэлт бүлгийн хүүхдэд хүрч үйлчлэх хууль эрх зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино. Хууль зүйн тусламж үйлчилгээг үзүүлж буй цагдаагийн алба хаагч, мэргэжилтний хүүхдийн эрх, хамгааллын талаарх мэдлэг ойлголт, хандлага, ур чадварыг бэхжүүлэх нь нэн тэргүүний хэрэгцээ юм.

Уг төслийн III дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд цагдаагийн байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан алба хаагчид болон хүүхэд хохирсон, хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг шалгах мөрдөгч нарт зориулсан сургагч багшийн сургалтын гарын авлагыг боловсрууллаа. Гарын авлагаар хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, шинэ үеийн охид хөвгүүдийн сэтгэл зүйн онцлог, хэв маяг, жендэрийн тэгш байдлыг хангах, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг ялган зүйлчлэх, мөрдөн шалгах арга зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх явцад хүүхдийн эрхийг ханган, хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, сургагч багшид тавигдах шаардлага, насанд хүрэгчдийг сургах арга зүй, сургалтын үр дүнг үнэлэх, тайлагнах арга зүйд суралцах юм. Хүүхдийн асуудал хариуцсан цагдаагийн алба хаагчдыг сургагч багшаар бэлтгэснээр хүүхэд холбогдсон гэмт хэрэг, зөрчлийг шалгах, мөрдөх явцад хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлд ахиц дэвшил гарна гэдэгт найдаж байна.

Гарын авлагыг боловсруулсан зохиогчид болон хамтран ажилласан Цагдаагийн ерөнхий газрын хамт олонд талархал илэрхийлье. Түүнчлэн төслийн санхүүжүүлэгч Европын холбоо болон Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье.

**Монгол Улс дахь Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын  
суурин төлөөлөгчийн газар**



## СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА:

Нийгмийн хамгааллын салбарын бодлого болон эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2012-2016 онд хүүхэд хамгааллын бодлогыг шинээр тодорхойлж, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг УИХ-аас батлан гаргаж, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Хүүхэд эрх, хүүхэд хамгаалал нь зөвхөн дээрх хоёр хуулиас гадна эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан эрүүгийн багц хууль тогтоомжтой уялдан боловсруулагдсан билээ. Хууль сахиулагчдаас орчин үеийн хүүхдийн хөгжлийн болон сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэгийг эзэмших хэрэгтэй гэж үздэг болсон. Иймд энэхүү сургалтаар Хүүхдийн эрхийг хангахад тулгарч буй зөрчил, бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлж, хүүхдийн эрх ашгийг дээдлэх үзэл хандлагыг эзэмшүүлэхийг зорьсон болно.

## СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ:

Энэхүү сургалтын зорилго нь Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийг дээдлэх/хүндэтгэх/ талаар сургалтад оролцогчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд оршино.

Үүний тулд дараах асуудлыг нарийвчлан судалсан байх нь зүйтэй бөгөөд эдгээр асуудал тус бүрийг судалж шинжлэхэд энэ сургалтын зорилт тодорхойлогдоно:

- Хүүхдийн эрхийн талаарх ойлголт.
- Хүүхэд хамгаалалд оролцох нь
- Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт хийх, үйл ажиллагаа явуулах
- Орчин үеийн хүүхдийн онцлог, харилцаа

## Сургалтын хөтөлбөрийн цаг, сэдвийн хуваарилалт (жишиг байдлаар)

| №  | Цагдаа                                                    | Цаг |
|----|-----------------------------------------------------------|-----|
| 1. | ХҮҮХДИЙН ЭРХ БОЛОН ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ     | 1   |
| 2. | ЖЕНДЭР БА ОХИД, ХӨВГҮҮДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ       | 1   |
| 3. | ШИНЭ ЗУУНЫ БУЮУ “Z” ҮЕИЙН ӨСВӨР НАСНЫХНЫ ОНЦЛОГ, ХЭВ МАЯГ | 1   |
|    | НИЙТ ЦАГ                                                  | 3   |

## 1.1. ХҮҮХДИЙН ЭРХ БОЛОН ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

| Хичээлийн нэр                       | Хүүхдийн эрх болон хамгааллын талаарх ерөнхий ойлголт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|-------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн гол зорилго               | Хүүхдийн эрхийн үндсэн 4 ангиллыг тодорхойлж, хүүхдийн эрх, хүүхдийн хэрэгцээний ялгааг таньж мэдсэнээр хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд авч үздэг итгэл үнэмшлийг нэмэгдүүлнэ.                                                                                                                                                                                                                                                   |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийг дээдлэх/хүндэтгэх/                                                                                                                                                                                                                                                          |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | <div>5 мин Мэндчилгээ ба нүүр хагарах дасгал</div> <div>15 мин Танилцуулга (лекц): Хүүхдийн эрх, хамгааллын талаарх ойлголт РР (Powerpoint) ашиглан тайлбарлана</div> <div>15 мин Нийтээр ажиллах дасгал: Хүүхдийн эрх, хамгааллын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох</div> <div>20 мин Бүлгийн ажил: Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломж</div> <div>5 мин Сорил ба үнэлгээ</div> |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.<br>www.legalinfo.mn<br>Х.Баавгай, Хүүхдийн эрх хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь 2018 он                                                                                                                                                                                                                  |

### НҮҮР ХАГАРАХ ДАСГАЛ:

Оролцогчид өөрсдийгөө хүүхэд хэмээн бодож ямар нэг хүүхдийн дүрд тоглоно. Сонгож буй дүр чинь өөрийн болон бусад хүүхдийн эсхүл хиймэл нэр, дүр байж болно. Оролцогч намайг ..... гэдэг гэж сонгосон хүүхдийнхээ нэрийг хэлээд, “би ... эрхтэй” гээд сууна. Дараагийн оролцогч мөн адил хэлнэ. Аль болох хурдан хийвэл сайн. Энэ үед ямар эрх илүү давтагдаж байгааг чиглүүлэгч анхаарах ёстой. Оролцогч бүр өөр өөр эрх хэлбэл сайн. Гэхдээ оролцогчийн хэлсэн зүйл эрх мөн эсэхийг нягтлаарай.

### ХИЧЭЭЛД АШИГЛАХ СУУРЬ МЭДЭЭЛЭЛ:

Хүүхдийн эрх бол хүний эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Хүүхэд бол эрх эдлэгч субъект. Хүүхдийн эрхийг эсэн мэнд амьдрах эрх, хөгжих эрх, оролцох эрх, хамгаалуулах эрх гэсэн 4 ангилалд хуваадаг.





## Хүүхэд гэж хэн бэ вэ? Хүүхдийн эрх гэж юу вэ?

18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. Хүүхэд бол нас, бие, сэтгэхүй нь хөгжиж, ухамсар нь төлөвшиж буй хувь хүн.

Хүүхэд бол жам ёсны болон хууль ёсны эрх эдлэгч онцгой субъект.

Хүүхэд бол иргэн хүн мөн.

Хүүхдийн эрх бол хүний эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Хүүхдийн эрх бол баталгаатай эрх чөлөө юм

Хүүхдийн эрх бол хүн бүр ижил тэгш хөгжих, оролцох боломж юм.

Хүүхдийн эрх бол өөрт нь заяагдсан буюу хуулиар зөвшөөрөгдсөн эрх чөлөө юм.

Хүүхдийн эрх бол хуульчлагдан баталгаажсан хэрэгцээ юм.

Хүүхдийн эрх бол хүн болж төрсний хувьд жам ёсны болон хууль ёсны эдэлвэл зохих эрх чөлөө юм.

Эрх чөлөө бол хараат бус, хязгаарлагдмал бус байдлаар өөрийгөө, өөрийнхөө нөхцөл байдлыг илэрхийлэх эрх юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Хүүхдийн эрхийн тухай конвенцыг 1989 онд баталж, манай улс 1990 онд хуульчлан баталгаажуулсан билээ. Конвенцын хамт гурван Нэмэлт протоколыг улс орнууд соёрхон батлаад байна. Эхний хоёр буюу Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг болон Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколд хүүхдийн зарим эрхийг илүү нарийвчлан тогтоож, 2000 онд НҮБ, 2002 онд манай улс соёрхон баталжээ. Мэдээлэл хүргүүлэх журмын тухай гурав дахь Нэмэлт Протокол 2011 онд батлагдсан бөгөөд Монгол Улс 2015 онд соёрхон баталсан. Энэ нь хүний эрхийн зөрчлийг НҮБ-ын анхааралд авчрах боломжийг хүүхдүүдэд олгодог билээ.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод дараах дөрвөн эрхэд тусгайлан анхаарал хандуулж, конвенцын суурь зарчмууд гэж нэрлэх болжээ. Үүнд: ялгаварлан гадуурхахгүй байх (Зүйл 2), хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах (Зүйл 3), хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих (Зүйл 6) болон оролцох (Зүйл 12) зэрэг болно.



## Эрхийн талаар мэдэхийн ач холбогдол:

- Эрхээ бүрэн дүүрэн эдлэх **боломжийг** олж авна. Эрхээ зөрчигдөж байна гэдгийг мэдэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга хэмжээ авна. Үүгээр ч зогсохгүй эрхээ зөрчигдөхөөс хамгаалж, түүнд нийцсэн баталгаа бүрдүүлэхийг төрөөс шаарддаг болно.
- Эрхээ бүрэн дүүрэн эдэлнэ гэдэг нийгмийн бүхий л амьдралд идэвхтэй **оролцоно** гэсэн үг. Хүүхдийн оролцоо, хяналт нь үүрэг хүлээгчдийг хариуцлагатай болгож, хууль, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл, нийгмийг бүтээх боломжийг бий болгоно.
- Бусдын эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахын учир зүйг мэдэрнэ.
- **Хүүхдийн эрхийг хүндэтгэх**- Хүүхдийн эрхийг хүндэтгэх гэдэг нь ямар ч нөхцөлд хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд авч үзэх хандлага, соёл юм. Өөрөөр хэлбэл хүүхэд аливаа эрхээ эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байхыг хэлнэ.
- **Хүүхдийн эрхийг хамгаалах** Хүүхдийн эрхийг хамгаалах гэдэг нь хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах механизмыг бий болгох, боловсронгуй болгох шийдвэр, санаачилга, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үйлийн тогтолцоо юм.
- **Хүүхдийн эрхийг хангах** Хүүхдийн эрхийг хангах гэдэг нь хүүхдэд эрхээ эдлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагаа юм.

## АНХААРАХ ЗҮЙЛ:

Хүүхдийн эрхийн зөрчлийг таньж мэдэх нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон хүүхдийг гэмт үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх боломжийг олгоно.

## ХИЧЭЭЛД АШИГЛАХ ЗУРАГ ДҮРСЛЭЛ:

Хичээлийн агуулгад нийцэлтэй зураг, график, харьцуулсан хүснэгт, видео бичлэг ашиглан оруулж болно.

## НИЙТЭЭР ХИЙХ ДАСГАЛ:

Нийт оролцогчдод нээлттэйгээр хийлгэх дасгал ажил, санал асуумжийн хэсэг юм. Жишээ нь: Хүүхдийн хүсэлт бүр эрхээ шаардаж буй явдал мөн үү? Хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн эрхийг хамгаалах нь ялгаатай асуудал мөн үү? Хүүхэд хамгаалал гэж юу вэ? гэсэн асуултад хариулт авч ярилцана.

## БҮЛГИЙН АЖИЛ:

Хэсэг, баг болж ажиллана. Баг бүрд тодорхой даалгавар өгч, багууд хийсэн ажлаа бусдад танилцуулах. Жишээ нь: Хүүхдийн эрхийг хүндэтгэх үүрэг, Хүүхдийн эрхийг хангах үүрэг, Хүүхдийн эрхийг хамгаалах үүргийн талаар 3 баг болж, үүргүүдийг жагсаан бичээд танилцуулна.

- Сорил:** 1. Хүүхдийн эрхийн хамгаалал, хүүхэд хамгаалал хоёр ялгаатай асуудал мөн.  
а/ үнэн б/ худал
2. Хүүхдийн суурь хэрэгцээ хангагдахгүй байх нь хүүхдийн эрхийн зөрчил мөн.  
а/ үнэн б/ худал
3. Хүүхэд эрх эдлэхээ шаардах эрхтэй.  
а/ үнэн б/ худал
4. Хүүхэд 4 үндсэн эрхтэй.  
а/ үнэн б/худал
5. Ямар ч үед ямар ч нөхцөлд хүүхдийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх нь хүн бүрийн эрхэмлэх зүйл байх ёстой.  
а/ үнэн б/ худал

## 1.2. ЖЕНДЭР БА ОХИД, ХӨВГҮҮДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ

| Хичээлийн нэр                       | Жендер ба охид, хөвгүүдийн сэтгэл зүйн зарим онцлог                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                  |
|-------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн гол зорилго               | Жендер ба хүйсийн ялгааг мэдсэнээр жендерийн хэвшмэл ойлголтын талаар мэдлэгтэй болно. Жендерийн хэрэгцээ, жендерийн тэгш байдлын талаарх ойлголтоо нэмэгдүүлнэ.                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | Жендер, жендерийн тэгш эрх, жендерийн тэгш байдал, жендерийн хэрэгцээ, жендерийн статистик, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт, жендэрт суурилсан хүчирхийлэл                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | 5 мин<br>15 мин<br>15 мин<br>20 мин<br>5 мин                                                                                                                                                                                                               | Мэндчилгээ ба нүүр хагарах дасгал<br>Танилцуулга (лекц): Жендерийн талаар болон охид хөвгүүдийн сэтгэл зүйн зарим онцлогийн талаар PP (Powerpoint) ашиглан тайлбарлана<br>Нийтээр ажиллах дасгал: “Зөгийн дүнгэнэлдээн”<br>Бүлгийн ажил: Жендерийн мэдрэмжийг сорих<br>Дүгнэлт ба бататгал хэсэг |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | - Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.<br><a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a><br>- Х.Баавгай, Хүүхдийн эрх хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь 2018 он |                                                                                                                                                                                                                                                                                                  |

### НҮҮР ХАГАРАХ ДАСГАЛ:

Чиглүүлэгч самбарыг эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхэд гэж 2 хуваана. Оролцогчдод 2 өнгийн цаас өгч, эрэгтэй ба эмэгтэй хүүхдийн нэн чухал хэрэгцээнүүдийг жагсаан бичихийг хүснэ. Бичсэн зүйлээ уншаад өнгийн дагуу самбарт байрлуулна. Төгсгөлд нь ялгаатай онцлог хэрэгцээ байгаа эсэхийг оролцогчдоос асууна.

### ХИЧЭЭЛД АШИГЛАХ СУУРЬ МЭДЭЭЛЭЛ:

Нийгэм дэх эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хоорондын харилцааны асуудлыг жендер гэж ойлгох бөгөөд энэ нь шинжлэх ухааны шинэ салбар юм. Жендер гэдэг нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм, улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог нэр томьёо. Жендер гэдэг нь эмэгтэй ба эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа, нийгмийн үүргийг салгаж ойлгох арга зам юм.

Жендер нь байгалиас заяасан, үл өөрчлөгдөх хүйсийн буюу биологийн ялгааг биш, цаг хугацаанд хувьсан өөрчлөгдөхөөс гадна соёл бүрд харилцан адилгүй байдаг эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг илэрхийлнэ. Нийгэм өөрөө тэгш бус учраас эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг ялгадаг. Тэгш бус нөхцөлд тэгш хандах нь асуудлыг шийдэхгүйгээр үл барам ялгавартай байдлыг улам нэмэгдүүлдэг. Жендерийн шударга ёсыг тогтоохын тулд ялгавартай байдлыг тогтвортой хадгалахад нөлөөлж буй нийгмийн харилцаанд болон байгууллагуудын үйл ажиллагаанд өөрчлөлт хийх хэрэгтэй байдаг.

Энгийнээр жендэр гэдэг нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлага, нийгэмд эзлэх, байр суурийн тухай бүрэлдэн тогтсон үзэл бодол, ойлголт юм. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг дахь зохион байгуулалтын шинж байдлыг тодорхойлох дүн шинжилгээний хэрэгсэл мөн.

*Жендерийн үзэл баримтлал нь жендерийн тэгш байдал болон жендерийн шударга ёсыг бодит амьдралд хэвшүүлэхэд хүрэх хэтийн бодлого юм. Жендерийн үзэл баримтлалын туйлын зорилго бол жендерийн тэгш байдлыг хангахад оршино.*

**Жендерийн тэгш эрх:** Эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн адил тэгш эрхтэй байр суурийг бүрдүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш боломж олгох, тэднийг нийгмийн бүхий л хүрээнд бүрэн оролцуулах, оролцсоныхоо хэрээр тэнцүү ашиг хүртээх ойлголт юм.

**Жендерийн тэгш байдал:** Эрэгтэй, эмэгтэйчүүдэд шударга хандах, нийгмийн зүгээс адил дэмжлэг үзүүлэх явдал мөн. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэйчүүдийн ижил хөдөлмөрт адил цалин хөлс төлөх, сурч боловсрох, өмч эзэмших, орон сууц, ажлын байртай болох, эрүүл мэндээ хамгаалах адил нөхцөлөөр хангагдах, эрх мэдлийг тэнцвэржүүлэх нийгмийн баталгаа юм.

**Жендерийн хэрэгцээ:** Жендерийн хэрэгцээ нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хүйсийн ялгаатай байдлаас урган гарсан гол хэрэгцээнүүд юм. Нөөц баялаг дахь хэрэгцээ болон хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн зээл, эмэгтэйчүүдийн ачааллыг хөнгөвчлөх техник хэрэгсэл, эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх гэх мэт бүхий л үйл ажиллагаа бодит хэрэгцээнд хамаарна. Эмэгтэйчүүдийн бодит хэрэгцээ ба стратегийг таних нь эрэгтэйчүүдийнхээс өөр учраас оролцооны аргаар тус тусад нь судлах нь чухал.

**Жендерийн мэдрэмж:** Эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай хэрэгцээ шаардлага байдгийг хүлээн зөвшөөрч, мөн тэдэнд нийгмийн үйлчилгээг адил тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх эрмэлзэл сэдэл бүхий хандлага юм.

**Жендерийн статистик:** Жендерийн холбоотой тоо баримт, мэдээллийг цуглуулах, шинжлэх, түгээхдээ жендэрээ бүрэн ангилан нас, оршин суугаа газар, орлого зэрэг бусад үзүүлэлтүүдээр ялгах үйл ажиллагаа юм. Тэдгээр нь чанар, хамрах хүрээг тэгш авч үзэх, тоо мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэгдэнэ.

Жендерийн тэгш байдал, жендерийн тэгш эрхийн тухай онол, үзэл баримтлалын учир утга нь эрэгтэй, эмэгтэй хүний байгаль эхээс ялгаатай төрдөг байдлыг ашиглан тэднийг нийгмийн хүрээнд ялгаатай гэж үзэн улмаар ялгаварлагдаж байгааг арилгах зорилготой.

Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, боловсролын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёл, боловсролын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чадах юм.

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүнд хүйсээс нь шалтгаалан нийгмээс оноосон, хуваарилсан үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурийн талаарх хүлээлт, шахалтад үндэслэн үйлдэгдэж, бусдад зовуурь, шаналал учруулдаг санаатай үйлдэл юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хэл амаар доромжлох, дээрэлхэх, дорд үзэх, бэлгийн дарамт үзүүлэх, хүчиндэх, хүн худалдаалах, хулгайлах зэрэг бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийллийн олон хэлбэрээр илэрдэг. Сургуулийн орчинд охид сэтгэл санааны болоод бэлгийн хүчирхийлэл, цахим хүчирхийлэл, дарамтад өртдөг бол хөвгүүд бие махбодын эсрэг хүчирхийлэлд илүүтэй өртдөг байна.

Сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл нь тухайн байгууллагын бүхий л гишүүд болох багш, ажилтан, удирдах ажилтан, суралцагчдад хамаарах ба эдгээр гишүүд нь нэг талаас үйлдэгч, нөгөө талаас хохирогч болох хоёр талтай байдаг. Орон зайн хувьд сургуулиас-гэр, дотуур байр хүртэлх орон зай, хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа, биет болон цахим хэлбэрийн үйл ажиллагаа явагдаж буй бүхий л газруудад хүчирхийлэл үйлдэгддэг. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил бөгөөд хүйсээр ялгаварлан гадуурхаж буй нэгэн хэлбэр юм. Хүүхэд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөнөөр сэтгэл санаа, бие махбодын хохирол амсаж, өөртөө итгэх итгэл, аз жаргал, амар тайван байх мэдрэмжээ алдаж, амжилттай сурч хөгжих боломжоо алддаг.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд хүргэж буй эрсдэлийн хүчин зүйлсийг ЮНЕСКО экологийн загварт тулгуурлан дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

#### **Хувь хүн:**

- Хувь хүний болон хамтын эрхийн талаарх ойлголт дутмаг
- Хүйс, нас, угсаатны шинж, хөгжлийн бэрхшээлтэй
- Бэлгийн чиг хандлага
- Боловсрол \боловсролгүй, бага боловсролтой байх\
- Эдийн засаг, амьжиргаа \ядуу, эмзэг байх\
- Газар зүйн байршил
- Иргэний бүртгэлгүй байх
- Дох, ХДХВ-тэй байх
- Хүчирхийлэлд өртөж байсан эсвэл үйлдэж байсан намтартай байх

#### **Гэр бүл:**

- Гэр бүлд нь хүүхдийг дутуу үнэлдэг байдал
- Эцэг, эхийн хараа, халамж анхаарал сул
- Архинаас хамааралтай гэр бүлд өсөж буй
- Байнгын дарамт хүчирхийлэлд амьдардаг
- Гэр бүлийн гишүүдийн жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний эрх, хүүхдийн эрхийн талаарх ойлголт дутмаг



**Сургууль:**

- Талуудын жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт дутмаг
- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах чадамж сул
- Аюулгүй хамгаалагдсан материаллаг орчныг бүрдүүлээгүй
- Сургууль-гэр хоорондын орон зайнд хамгаалагдсан орчин бүрдээгүй
- Багш нарын сургалтын арга барилд хүч хэрэглэсэн шинжтэй
- Сургалтын хөтөлбөр, сурах бичиг нь охид, хөвгүүдийн хоорондын эрүүл, хүндэтгэсэн хүчирхийлэлгүй харилцааны ур чадварыг тусгаагүй

**Орон нутаг**

- Жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдлийн талаар мэдээлэх, хариу арга хэмжээ авдаг соёл төлөвшөөгүй
- Бие махбол, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийллийг үл хайхардаг, мэдээлдэггүй, нуудаг
- Жендэрийн тэгш бус байдлыг дэмждэг, эцгийн эрхт ёсны зарим үнэт зүйлс хүчин төгөлдөр хэвээрээ байгаа
- Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар гомдол гаргахад ил болон далд хэлбэрээр дургүйлхдэг, татгалздаг, шийтгэл хариуцлага тооцохоос татгалздаг
- Охид, хөвгүүдийн боловсрол эзэмшихийг адил дэмждэггүй

**Нийгэм:**

- Жендэрт суурилсан хүчирхийлэл хуульчлагдан зохицуулагдаагүй
- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлогын орчин хангалттай бүрдээгүй
- Салбар дундын зохицуулалт хангалтгүй
- Жендэрийн тэгш бус байдал, жендэрийн хэвшмэл ойлголт хандлагыг дэмждэг
- Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ЕБС, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаагүй
- Хууль зөрчихөд ял шийтгэлгүй өнгөрөөдөг хандлага хэвээр байгаа
- Тэгш бус байдал буурахгүй байгаа
- Төрийн засаглал дахь авлигал өндөртэй зэрэг хүчин зүйлс нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлдөг байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээг авах боломжтой. Үүнд:

1. Багш нар хичээлийн хөтөлбөр болон агуулгад жендэрийн эрх тэгш байдал, бусдыгаа хүндэтгэж, хайрлаж, хүнлэг харилцах ёс суртахууны үнэт зүйлийн тухай үзэл санааг тусгаж өгөх;

2. Сургуулиас гадуурх соёл хүмүүжлийн үйл ажиллагаанд жендэрт суурилсан хүчирхийллийн сөрөг үр дагавар, хор уршиг, муу талыг сайн ойлгуулах үйл явцыг тусгаж өгөх;
3. Жендэрт суурилсан хүчирхийллийг мэдээлэх, илрүүлэх талаар нээлттэй байх боломжийг бүрдүүлэх, сурагчдыг сонсох;
4. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар сургалт, сурталчилгаа мэдээллийг явуулах;
5. Багш, нийгмийн ажилтан, мэргэжилтнийг чадавхжуулах;
6. Хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг багш, сурагчдад таниулах;
7. Охид, хөвгүүдэд сургууль бол адил тэгш сурч хөгжих боломж олгодог хамгийн таатай орчин бөгөөд нэгнээ эрсдэлд оруулж сэтгэл зүй, бие махбодод нь хор хохирол учруулж ирээдүйн амьдралд нь сөргөөр нөлөөлж болохгүй гэдгийг сурталчлан таниулах;
8. Сурагчдын дунд жендэрт суурилсан хүчирхийллийг таньж, үйлдэхгүй байх талаар эссэ бичлэг, зураг, жүжгийн уралдаан зохион байгуулах;

Сургалтын явцад жендэрийн ялгаа ажиглагддаг байна. Жишээ нь багш нар охидоос дуулгавартай эвлэрэнгүй байхыг шаардана, хүлээнэ. Харин хөвгүүдийн дуулгаваргүй, дүрсгүй, бие даасан байдлыг зохих хэмжээнд хүлээн зөвшөөрдөг. Охидоос бэлэн үнэн зөв хариулт нэхдэг бол хөвгүүдийг хүлээх, өнгөрөөх зэргээр ханддаг байна. Эмэгтэй багш нар сурагчдын хоорондын харилцаа, зан чанарыг чухалчилдаг бол эрэгтэй багш нар заасан зүйлийнхээ үр дүнд ач холбогдол өгдөг. Иймээс багш тэдэнд ялгаатай хандахгүй байх нь чухал юм.

Багшийн жендэрийн мэдрэмжгүй хандлага:

- Эрэгтэй сурагчдыг илүү олон дууддаг;
- Эрэгтэй сурагчдыг асуултад хариулахад илүү удаан хүлээдэг;
- Асуулт асуухдаа эрэгтэй сурагчдыг илүү удаан тогтоож хардаг;
- Эрэгтэй сурагчдын хэлсэн зүйлийг илүү жишээ болгож ярьдаг, урамшуулдаг;
- Эмэгтэй сурагчийн яриаг тасалдаг;
- Эрэгтэй сурагчдаас шүүмжлэлт сэтгэлгээ шаардсан асуулт асуудаг бол эмэгтэй сурагчдаас баримт шаардсан асуулт асуудаг;

Жендэрийн мэдрэмжтэй сургалтын орчныг бүрдүүлэхэд дараах зүйлийг анхаарах;

- Ангид охид хөвгүүд холимог байх;
- Ангийн үйл ажиллагаанд охид хөвгүүдийн оролцоог жигд дэмжих;
- Ширээний байрлал нь охид хөвгүүдийн нээлттэй байхад дэмжихүйц байх;

- Ханан дахь үзүүлэн материал нь жендэрийн тэгш эрхийн байдлыг илэрхийлсэн байх;
- Багш охид, хөвгүүдтэй адил тэгш харилцах;
- Нуруу намхан, сонсгол болон хараа сул охид хөвгүүдийг урдуур суулгах
- Охид хөвгүүдийн бие засах газар тусгаарлагдсан, түгжээ, хаалт сайтай, цэвэрхэн байх

### ҮР ДҮН:

Сургахуйн үйл явцад охид хөвгүүдийн сэтгэл зүйн ялгааг сайтар мэдэж байх нь чухал бөгөөд тэдэнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг ойлголтыг өгөхөд анхаарах хэрэгтэй. Тэдний ялгаатай байдлыг ойлгох, тэдэнтэй харилцах харилцаанаас жендэрийн нийгэмшил ихээхэн шалтгаалдаг. Хүү төрсөн үү, охин төрсөн үү гэдгээс шууд хамаараад өлгий, өхөөрдөлт, энхрийлэл, дүрслэл, тоглоом, зан үйлийн хүлээлт зэрэг нь ялгаатай байх ба охид хөвгүүд нэг замаар бус салаа замаар төлөвшдөг. Өөрөөр хэлбэл нийгмийн орчны хүчин зүйлс тэдний ялгаатай байдлыг улам бүр нэмэгдүүлж байдаг. Нийгмийн суралцахуйн онолд жендэрийн дүр үүрэг, жендэрийн нийгэмшлийг нийгмийн хүчин зүйлсээс хамаардаг гэдэгт гол анхаарлаа хандуулдаг. Хүүхдийн жендэрийн дүр үүргийн хөгжилд түүний эцэг, эхийн зан үйлийн загвар, цаашлаад нийгмийн бусад хүчин зүйлс нөлөөлнө гэж үздэг. Багш охид, хөвгүүдийн хэрэгцээ, сонирхол, сэтгэл зүйн ялгааг харгалзан үзэж, сургалтын үйл ажиллагаанд адил, тэгш оролцох боломжийг бүрдүүлэн, улмаар адил тэгш хөгжихөд хувь нэмэр оруулах нь чухал юм.

**Охидын сэтгэл зүй:** Охидын хувьд өөрийн гадаад үзэмждээ хэт их анхаарал тавих, зарим үед өөртэйгөө эвлэрэхгүй, сэтгэл дундуур байх тохиолдол гардаг учраас түүнд сэтгэл хангалуун байхад нь тусалж хөөрхөн охин болохыг хэлж өгч байгаарай. Тэр өөрийгөө дахин давтагдашгүй цор ганц хувилбар гэдгээ ойлгохгүй хэн нэгэнтэй адил байх, эсвэл төсөөллийн төрхөө өөртөө бий болгох гэснээс энэ бүхэн үүсдэг. Өсвөр насанд гарах сэтгэл зүйн хямрал өөрчлөлтийг хэрхэн даван туулснаар хүүхдийн хувийн зан чанар бүрэлдэх суурь тавигддаг. Охид зөрүүдлэх үгэнд орохгүй, өөрийнхөөрөө байх гэж зоргоороо аашлах, үг сонсохгүй байх, хэн ч намайг ойлгохгүй байна гэж гомдоллох, шалтгаангүй уурлаж бухимдах, түгших, сэтгэл санаа тогтворгүйтэх асуудлуудтай тулгардаг.

Учир нь өсвөр насанд дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагаа эрчимтэй явагддаг учраас үүний үр дүнд мэдрэлийн тогтолцоо цочромтгой болдог. Тэд үе үе цочир уурлах, хэт гомдох, цухалдах, огцом зан авир гаргах нь олонтоо тохиолддог. Иймд ойр дотны хүмүүсээ гомдоохгүй байх, мөн өөрөө сэтгэл санааны энэ тогтворгүй байдлаасаа болж буруу зүйл хийхгүй байхыг хичээх хэрэгтэйг сануулаарай. Хэрэв өөрийгөө тайвшруулж чадахгүй бие махбодоос ирж байгаа дохиог тэр чигт нь гадагшлуулаад байвал магадгүй тэр таагүй хандлага зан чанар болон төлөвших магадлалтай юм.

Охид эцэг эхээсээ хараат байх нь багасаж өөрийн ажил хэрэг, нууц зүйлээ найздаа итгэж ярьдаг. Иймээс багш тэдний нөхөрлөлд хүндэтгэлтэй хандах нь чухал. Үе тэнгийнхэн болон тэдэнтэй харилцах харилцаа онцгой ач холбогдолтой болж, “Найз нөхөд” гэдгийг хамгийн чухалд авч үзэж найзуудынхаа нөлөөнд ордог. Тэд өөрсдөө адил өөрчлөгдөж байгаа учир үе тэнгийнхэн нь тэднийг хялбархан ойлгож дэмждэгээрээ бас нэгэн онцлог байдаг. Үе тэнгийнхэнтэйгээ харилцах нь тэдэнд хоорондоо харилцах чадварыг төлөвшүүлж, сургууль нийгмийн харилцааг хөгжүүлдэг.

Өсвөр насны зарим охид өөрийн айдас, гомдол, сэтгэл догдлол болон хардалт зэрэг сэтгэл зүйгээ нуухын тулд бүрэг болж сэтгэл зүйн хувьд эрс өөр байдалд орох тохиолдол бий. Нэг талаар охид ганцаараа байхыг хүсдэг боловч нөгөө талаасаа найз нөхөдтэйгөө байхыг эрмэлздэг.

Өсвөр насны охидод сэтгэл зүйн асар их өөрчлөлт явагддаг учир тэдэнд гэр бүлийн гишүүд, найз нөхөд, сургууль, эсрэг хүйстний харилцаа ихээхэн нөлөөлж тэднийг цаашид хэн болох вэ гэдгийг тодорхойлдог. Эцэг эхийн хайхрамжгүй байдал, буруу хүмүүжил, ширүүн үг, хатуу шийтгэл зэрэг нь энэ насны хүүхдийг гэрээс нь дайжих, бусдад уруу татагдах, эсрэг хүйстнээ хүчтэй сонирхох, гэмт хэрэгт холбогдох, хүчирхийлэлд өртөх тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртөх үндэс суурийг тавьж өгч байдаг. Өсвөр насанд бэлгийн дааврын нөлөөгөөр эсрэг хүйстнээ шохоорхох нь нэмэгддэг. Охидын хувьд ажил хэрэг, нууц зүйлээ эцэг эхдээ биш харин найздаа итгэж ярих нь түгээмэл. Гэрийнхэн нь ойлгохгүй байгаа юм шиг санагдах үед өөрийг нь ойлгох, хайрлах дотно хүнийг хүсэж эхэлдэг. Энэ үеэс л үерхэж эхэлнэ. Иймээс багшлахуйн харилцаанд тэдний сэтгэл зүйн онцлогийг харгалзаж, ажиглаж байх нь чухал бөгөөд энэ байдал нь сургалтын чанарт мөн хамааралтай юм.

**Хөвгүүдийн сэтгэл зүй:** Мэдрэлийн үйл ажиллагааны нэг болох хөөрөл, саатлын процесс давамгайлах учир хөвгүүд хөдөлгөөн ихтэй, түргэн хувирамтгай зан ааштай болж ялихгүй юманд уурлах, уцаарлах нь өсвөр насанд нэмэгддэг. Магадгүй тэд зөрүүдлэх үгэнд орохгүй, өөрийнхөөрөө байх гэж оролдох, эцэг эхийн үг дарамттай санагдах, хэн ч намайг ойлгохгүй байна гэж бодох, гомдох, огцом зан авир гаргаж шалтгаангүй уурлаж бухимдах, түгших, сэтгэл санаа тогтворгүйтэх асуудлуудтай тулгардаг. Гэрийнхэнтэйгээ ярилцахаас төвөгшөөж чимээгүйхэн хоолоо идээд бушуухан өрөөндөө орж өөрийнхөө ертөнцөд амьдрахыг хүсэх юм уу, эсвэл гадагшаа гарч дуртай газраараа явахыг хүсдэг.

Томчуудын дүр төрхийг дуурайж хориотой зүйлийг хийж үзэхийг ихэд хүсэж байж ч болох юм.

Зарим үед бусадтай бүдүүлэг харилцах, хараалын үг хэлэх, тоомжиргүй хандах, биеэ тоох, өөрийгөө том хүн болсон гэж бодох, хэн нэгэнд хүч чадлаа гайхуулж ноёрхлоо тогтоохыг эрмэлзэж байж магадгүй. Асуудлыг уураар, хүчээр шийдэх нь таалагдаж байж ч мэднэ. Гэвч энэ бүхнийг зохицуулах ёстой бөгөөд бие махбодоос өгч байгаа дохио мэдээллийг хяналтгүйгээр шууд гадагшлуулах нь эрсдэлтэй гэдгийг сануулаарай.

Орчин үеийн нийгэмд донтолтод автсан өсвөр насны хөвгүүд олширч байна. Хамгийн амархан автдаг зүйл нь зурагт, автомат тоглоом, компьютер, интернэт юм. Энэ нь сэтгэл зүйн шалтгаантай холбоотой юм. Хөвгүүдийн хувьд:

- Өөрийгөө захирах чадвар нь сул байдаг. Зовлонг тэвчих, тууштай хичээж чадахгүй амархан бууж өгөх, няцах, зугаа цэнгэлийг хүсэхтэй холбоотой. Мөн дэндүү их эрхэлж өссөн хүүхэд татгалзсан хариуг хүлээж авах чадваргүй, тэвчээргүй, амиа хичээсэн эсвэл өөртөө төвтэй, надаас чухал хүнгүй гэсэн бодолтой болсонтой холбоотой байдаг.
- Юунаас болж байгаа нь үл мэдэгдэх айдас түгшүүр, ганцаардал, амьдралын учир утгыг олж чадахгүй хоосон байдлыг мэдрэх.
- Гадуурхагдсан мэдрэмжээсээ салах гэж донтолтод автдаг.

Донтолт өнөөдрөөс маргааш хүрэх хугацаанд үүсэхгүй ээ!!! Үе шатаар хөгжиж, нэг мэдэхэд донтох өвчинд нэрвэгдсэн байдаг. Тухайн зүйлд зарцуулж буй цаг хугацаа, түүнд татагдах мэдрэмж алгуурхан өдөр өдрөөр нэмэгдсээр тэд түүнгүйгээр байж чадахгүй болсон байдаг. Улмаар бусад зүйлд анхаарлаа төвлөрүүлж чадахаа больдог.

Эцэг эхийн хоорондын харилцаа хөвгүүдийн хүмүүжил, төлөвшилд чухал үүрэгтэй. Гэр бүл зөрчил маргаангүй аль болох тайван амгалан байвал хүүхэд өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр, хүмүүстэй чөлөөтэй харилцаж, амжилттай ажиллаж амьдарч чаддаг.

Тааламжтай харилцаатай гэр бүлд өссөн хүүхдүүд өөрийн харилцааг урьдаас дүгнэж чаддаг, бусадтай зүй зохистой харилцдаг учраас нийгмийн зүгээс хүндэтгэл хүлээж байдаг. Харин санал бодлыг нь хайхрахгүй, үл ойшоох, хайрлаж хүндлэхгүй байх нь өсвөр насны хүүхдийг их эмзэглүүлдэг. Ийм тохиолдолд хүүхэд өөрийгөө үнэлэх үнэлэмжгүй болж, бусдад итгэхгүй асуудалд сөргөөр хандаж эхэлдэг. Ингэснээр хүүхэд өөрийн гэсэн нууцлаг амьдралаар амьдрахыг хүсдэг.

Хөвгүүд насанд хүрэгчидтэй харилцааны бүхий л хүрээнд шинэлэг хандлагаар харилцдаг. Хөвгүүдтэй нялх хүүхэд шиг хандаж бие даасан байдлыг нь эсэргүүцэж, сонирхол хандлага санал бодлыг нь харгалзаж үзэхгүйгээр гомдоож, эрс буруушаасан тохиолдолд тавьсан шаардлагыг эсэргүүцэх тохиолдол элбэг байдаг. Эцэг эхчүүд хөвгүүдээ хэт их хянаж, бүх асуудлыг өөрсдөө шийдвэрлэхээ болих үед тэдний хооронд үл ойлголцох байдал багасна.

Хөвгүүд өөрийн давуу талыг үнэлж насанд хүрсэн хүний түвшинд өөрийгөө тооцдог учраас түүнд дарамт шахалт үзүүлж, биеэ даах хүслийг нь ойшоохгүй байж болохгүй юм. Иймээс хүүхдийн бие даасан байдлыг дэмжиж, урамшуулж харилцах нь нэн чухал байдаг. Үүнд:

- Хүүхдийн санаа бодол танихаас эрс өөр байсан ч түүнийг үнэн сэтгэлээсээ хүндэтгэх
- Өөрийн үнэт зүйлсээ тодорхойлоход нь дэмжиж туслах

- Ямар ч үед түүнийг хүндэлдэг гэдгээ ойлгуулах
- Шийдвэр гаргах чадвар, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээж чадна гэдэгт нь итгэдгээ бодитоор харуулах
- Хүүхдийн мэдрэмжийг хүндэтгэх
- Алдаа гаргахад нь тайвшруулж, санаа сэтгэлээр дэмжих
- Алдаж, ялагдсан ч дахин оролдож үзэхийг нь дэмжих
- Түүнтэй холбоотой шийдвэр гаргахдаа түүний саналыг заавал харгалзан үзэх

Таны жендэрийн мэдрэмжтэй байх нь жендэрийн хэвшмэл бус, эерэг хандлагатай байхаас хамаарна.

Аливаа үйл ажиллагаанд охид хөвгүүд бие махбод болон сэтгэхүй, танин мэдэхүйн хувьд харилцан адилгүй өсөж хөгждөг, мөн жендэрийн үүрэг, харилцаа нь өөрчлөгддөгийг харгалзах учиртай. Тухайлбал хөвгүүд охидыг гоочлохоо больж охидод сайнаар хандах, охидыг хамгаалах ёстой баатар буюу охид сул дорой, ичимхий тул хөвгүүд халамжлагч, охид ичимхий болох гэх мэтээр тэдний жендэрийн үүрэг, жендэрийн харилцаанд гарч байгаа өөрчлөлтийг багш ажиглаж мэдрэх хэрэгтэй юм. Охид хөвгүүд харилцан адилгүй өсөж хөгжихийн хэрээр жендэрийн үүрэг, харилцаа ялгаатай, өөрчлөгдөн хөгжиж байгааг багш ажиглаж, хүндэтгэлтэй, боловсон харилцах, зөвшөөрөлгүйгээр охидын биед хүрэхгүй байх, хөвгүүд, эрэгтэй, эмэгтэй хүнтэй яаж харилцвал боловсон байхыг охид хөвгүүдтэй харилцахдаа зааж зөвлөх нь охид хөвгүүдэд сурах таатай орчныг бүрдүүлэхэд ач холбогдолтой.

Судалгаагаар, багш жендэрийн мэдрэмжтэй харилцан үйлдлийн тухай ойлголттой байснаар жендэрийн өрөөсгөл хандлагаас зайлсхийхийн зэрэгцээ жендэрийн мэдлэгтээ үндэслээд суралцагчдаа шударга, зөв залах боломжтой нь тогтоогджээ.

## ҮР ДҮН

Охид, хөвгүүдийн хэрэгцээ сонирхол, ялгааг харгалзан, тэднийг сургалтын үйл ажиллагаанд адил тэгш оролцох боломжийг бүрдүүлэн, улмаар адил тэгшээр хөгжихөд нь хувь нэмэр оруулах сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны чадвартай болно.

## АНХААРАХ ЗҮЙЛ:

Охид, хөвгүүдийн сэтгэл зүйн ялгаатай байдал болон жендэрт суурилсан хүчирхийллийн талаар хэвшмэл бус мэдлэг, ойлголттой болох нь зөрчил, гэмт үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх боломжийг олгоно.



**ХИЧЭЭЛД АШИГЛАХ ЗУРАГ ДҮРСЛЭЛ:**

Хичээлийн агуулгад нийцэлтэй зураг, график, харьцуулсан хүснэгт, видео бичлэг ашиглан оруулна.

**НИЙТЭЭР ХИЙХ ДАСГАЛ:**

Нийт оролцогчдод нээлттэйгээр хийлгэх дасгал ажил, санал асуумжийн хэсэг юм. Жишээ нь:

**ЗӨГИЙН ДҮНГЭНЭЛДЭЭНИЙ АРГА:**

Суралцагчдын анхаарлыг тодорхой нэг асуудал дээр төвлөрүүлж, өөр хоорондоо ярилцан оновчтой зөв шийдэлд хүрэх. Хоорондын дүнгэнэлдээнийг 15 минутаас хэтрүүлэхгүй байна. Үүний дараа багш суралцагчдын үйл ажиллагааг хөтлөн нэг шийдэлд хүрэхэд нь тусалж мэдээлэл өгч харилцан ярилцана. Ярилцлагад хүн нэг бүрийн оролцоог онцгой анхаарна.

Багш дараах асуудлуудыг самбарт харуулж хоорондоо мэдээлэл солилцох даалгавар өгнө.

Үүнд:

1. Жендэр гэж юу вэ? Та нар энэ асуудлыг хэрхэн ойлгодог вэ?
2. Жендэрийн тэгш эрх гэж юу вэ?
3. Эрэгтэй эмэгтэй хүмүүст ялгаатай хандах ёстой юу?
4. Та бүгд эрэгтэй эмэгтэй хүүхдүүддээ хэрхэн ханддаг вэ?
5. Бодит амьдрал дээр эрэгтэй, эмэгтэйчүүд ямар ялгаварлалд өртдөг вэ?
6. Ялгаварлах хандлагаас хэн ямар хохирол амсдаг вэ?

Суралцагчид хоорондоо ярилцсанаар мэдээлэл солилцохын зэрэгцээ асуудалд илүү анхаарлаа төвлөрүүлж цаашид сонирхох сэдэлтэй болно.

**БҮЛГИЙН АЖИЛ:**

Танай багийн жендэрийн мэдрэмж ямар түвшинд байгааг дараах шалгах хуудас ашиглан тодорхойлно уу.

| Шалгуур                                   | Тийм | Үгүй |
|-------------------------------------------|------|------|
| Багш хөвгүүдийг ихэвчлэн самбарт гаргадаг |      |      |
| Багш охидыг ихэвчлэн самбарт гаргадаг     |      |      |
| Багш охидоос ихэвчлэн асуулт асуудаг      |      |      |
| Багш хөвгүүдээс ихэвчлэн асуулт асуудаг   |      |      |
| Багш охидод илүү очиж зөвлөдөг            |      |      |

|                                                               |  |  |
|---------------------------------------------------------------|--|--|
| Багш хөвгүүдэд илүү очиж зөвлөдөг                             |  |  |
| Багш оролцохгүй байгаа суралцагч нэг бүрд анхаарал хандуулдаг |  |  |
| Багш оролцохгүй байгаа суралцагч нэг бүрд анхаарал хандуулдаг |  |  |
| Багш ангид сахилга бат тогтоох эерэг арга хэрэглэдэг          |  |  |
| Багш охидыг нэрээр нь дуудаг                                  |  |  |
| Багш хөвгүүдийг нэрээр нь дууддаг                             |  |  |
| Охидод илүүтэй нэмэлт, хүндрүүлсэн дасгал даалгавар өгдөг     |  |  |
| Хөвгүүдэд илүүтэй нэмэлт, хүндрүүлсэн дасгал даалгавар өгдөг  |  |  |
| Багш охидыг хариулж дуусаагүй байхад нь тасалдуулж ярьдаг     |  |  |
| Багш хөвгүүдийг хариулж дуусаагүй байхад тасалдуулдаг         |  |  |
| Хөвгүүдэд олонтаа сануулга өгдөг                              |  |  |
| Охидод олонтаа сануулга өгдөг                                 |  |  |
| Охидыг илүү магтаж урамшуулдаг                                |  |  |
| Хөвгүүдийг илүү магтаж урамшуулдаг                            |  |  |
| Охидыг илүү анхааралтай сонсдог                               |  |  |
| Хөвгүүдийг илүү анхааралтай сонсдог                           |  |  |
| Хөвгүүдэд ихэвчлэн бие махбодын шийтгэл үзүүлдэг              |  |  |
| Охидыг ихэвчлэн загнадаг                                      |  |  |

### ДҮГНЭЛТ БА БАТАТГАЛ ХЭСЭГ

Багш оролцогчдод ардаа цавуутай өнгө өнгийн цаас тарааж өгнө. Ингээд жендэрийн мэдрэмжтэй орчныг бүрдүүлэхэд юу чухал байх талаар бид бүхний хэрэгжүүлэх ёстой үйлдлүүд юу байх вэ?. Хүн бүр 2 зүйлийг бичиж самбарт наахыг хүснэ. Үүний дараа хэн нэгэн нь гарч ирж тэдгээр бичсэн зүйлүүдийг уншихыг санал болгоно. Уншсаны дараа хамгийн олон давтагдсан үгнүүдийг хамтдаа тодорхойлох бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлж чаддаг эсэх талаар ярилцана.

Ингэж хамтдаа тодорхойлсон чухал зүйлүүд нь мартагдахааргүй тогтоогддог. Үүний дараагаар жендэрийн мэдрэмж гэж яг чухам юу вэ? гэдэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлнэ. Ирээдүйд зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөхийн тулд өнөөдөр юуг анхаарах, хэн ямар оролцоотой байх талаар ярилцаж төлөвлөх.

Жендэрийн мэдрэмжгүй хэвшмэл хэлц үгний уралдаан зарлана. Жишээ нь оргүйгээс охинтой нь дээр, эр хүн уйлдаггүй, майлан майлан мал болдог, уйлан уйлан хүн болдог гэх мэт... Хүн тус бүрийн хэлсэн үгнүүдийг самбарт жагсаан бичнэ. Энэ арга нь суралцагчдыг идэвхжүүлэх, сургалтын уур амьсгал, сэтгэл зүйн бэлтгэл болох сайн талтай.

### 1.3. ШИНЭ ЗУУНЫ БУЮУ “Z” ҮЕИЙН ӨСВӨР НАСНЫХНЫ ОНЦЛОГ, ХЭВ МАЯГ

| Хичээлийн нэр                       | “Z” үеийн өсвөр насныхны онцлог, хэв маяг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн гол зорилго               | Бидний гол харилцагч субъект болох өсвөр насныхан буюу шинэ зууны шинэ үеийнхэн хэмээгдэх “Z” үеийнхний онцлог шинж байдал, хэв маягийн талаарх мэдлэг ойлголтыг бататгах                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | Generation-Z буюу “Z” үе, аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал, Энтрепренер, цахим мэдээллийн технологи, “Солонгон хүүхдүүд”                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | <div>5 мин Мэндчилгээ ба нүүр хагарах дасгал</div> <div>15 мин Танилцуулга (лекц): “Z” үеийнхний онцлог шинж байдал, хэв маягийн талаарх ойлголт PP (Powerpoint) ашиглан тайлбарлана</div> <div>15 мин Нийтээр ажиллах дасгал: “Z” үеийнхний талаарх бидний төсөөлөл ярилцлага. Оролцогч бүр саналаа хэлэх боломж олгох.</div> <div>20 мин Бүлгийн ажил: “Z” үеийнхний давуу болон сул талыг тодорхойлох. 5-6 баг болж энэ даалгаврыг гүйцэтгэнэ. Баг бүр 1-2 минут танилцуулга хийнэ.</div> <div>5 мин Асуулт хариулт</div> |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | <ul style="list-style-type: none"> <li>Х.Баавгай, Н.Нямдорж нар, Сургуульд суурилсан нийгмийн ажлын арга зүй. 2019 он</li> <li>Х. Баавгай. Хөгжлийг хөтлөхүй. УБ., 2014 он.<br/><a href="https://zerocater.com/blog/2018/06/04/workforce-newest-members-generation-z/">https://zerocater.com/blog/2018/06/04/workforce-newest-members-generation-z/</a></li> </ul>                                                                                                                                                           |

#### НҮҮР ХАГАРАХ ДАСГАЛ:

Оролцогчдыг дараах даалгавар гүйцэтгэхийг санал болгоно. Үүнд: Та бүхэн миний хэлсний дагуу үйл хөдлөл хийж үзүүлнэ. За хийгээрэй. Бүгд сурагч суудлаар сууцгаана уу? Гурвалжин хэлбэр үүсгэн сууцгаана уу? Хайраа илэрхийлэн сууцгаана уу? Энэ үед оролцогчид нэг хэсэг жаахан сандралд орж янз янзын хөдөлгөөн хийдэг. Чиглүүлэгч миний хэлсний дагуу “Сурагч суудлаар суухдаа баруун гарыг зүүн гарын бугуйн дээр зөрүүлэн тавих, гурвалжин хэлбэр үүсгэн суухдаа ширээн дээр хоёр тохойгоо тавьж, гарын хоёр шуугаа босгон баруун зүүн гарын хурууны үзүүрүүдийг нийлүүлэх, хайраа илэрхийлэн сууна уу гэхэд толгой дээрээ хоёр гараараа зүрх дүрслэн суух юм” гээд бүгдээрээ давтан нэг хийхийг санал болгож, бүгд зэрэг хийснээр анхаарал төвлөрөх болно.

## ХИЧЭЭЛД АШИГЛАХ СУУРЬ МЭДЭЭЛЭЛ:

### ШИНЭ ЭРИНИЙ ШИНЭ ҮЕИЙНХЭН БУЮУ “Z” –ҮҮДИЙГ ТАНИХ НЬ

Та хүүхэдтэй хамтран ажиллахын тулд эхлээд түүнийг сайтар судалж, тань.

*Х.Баавгай*

Өнөөдөр амьдарч байгаа бидний ихэнх нь 1965(60)-1976(80) онд төрсөн “Generation-X”, 1977(80)-1997(2000) онд төрсөн “Millennial Generation-Y” юм.

Харин бидний өмнө Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үед амьдарч байгаа “Z” үеийнхнийг аливаа асуудлыг олж хардаг, шийдвэрлэх арга замыг тодорхойлж чаддаг, түүнийгээ ажил, бүтээл болгон хэрэгжүүлдэг цогц чадварыг эзэмшсэн иргэн болгож бэлтгэх, хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

Шинэ зууны эхэнд төрөгчдийг нийтэд нь “Солонгон хүүхдүүд” гэж нэрлэдэг байна. Тэд XXI зуунд төрсөн(1997/2000-2010/2015 “Z” үе, 2015 оноос хойш Альфа үеийнхэн юм) “Z” үеийнхэн 1928-1945 оны хооронд төрсөн “Silent” /чимээгүй үе гэдэг/ үеийнхэнтэй төстэй нийтлэг зан чанартай. Тухайлбал, тэд гэр бүлийн дотно харилцааг үнэлдэг, эрсдэлд дургүй, хуримтлал үүсгэхийг эрхэмлэдэг байна.

Шинэ эрин үед төрж өссөн, сурч, амьдарч байгаа хүүхэд залуусаа сайтар таних нь хүүхэдтэй ажилладаг, хүүхдийн төлөө үүрэг хүлээгчдийн хувьд амин чухал асуудал болж байна. Тэднийг таньж мэдсэнээр л бид юу хийхээ, хэрхэн хамтарч ажиллахаа зөв тодорхойлж чадна.

### ШИНЭ ЭРИНИЙ ШИНЭ ҮЕИЙНХЭН БУЮУ “Z”-ҮҮД ГЭЖ ХЭН БЭ?

Тэдний ерөнхий онцлог:

- Эрэг сэтгэхүйтэй, хөгжилтэй
- Техник технологийг сайн ашигладаг
- Сүсэг бишрэлтэй
- Байгаль болон амьтанд хайртай, цагаан хоолтон болох нь элбэг
- Эрх чөлөөг эрхэмлэдэг
- Энэ үеийнхэн бол ухаалаг хэрэглээ, интернэтийг төгс эзэмшигчид.
- “Z” үеийнхэн илүү даяаршиж, эх оронч ба үндсэрхэг үзлээс холдсон байдаг.
- Цахим ертөнцөд ямар нэгэн шинэ старт-ап компани нээхийг илүүд үздэг.
- Багаар ажиллах чадвартай
- Илүү их хамгаалагдсан

Тэд мэдээллийн ертөнцөд төрсөн учраас орчин үеийн, технологи хэрэглэгчид юм.

Тэдний хувьд хүссэн мэдээллээ авахын тулд хэдхэн товчлуур дарахад л болох билээ. Солонгон хүүхдүүд аз жаргалтай, цоглог. Баяр баясал, хөгжил цэнгэл авчрагчид л гэсэн үг. Өмнөх үеийнхний бүтээсэн бүхнийг хялбархан өөрчилж чадна. Тэдний ихэнх нь эрх чөлөөг хүсэмжилдэг, аялах дуртай бөгөөд ах, эгч, эцэг эхийнхээ дэргэд байх дургүй хүмүүс юм.

Тэд “Хүн төрөлхтний чадавхыг нэмэгдүүлэхийн тулд бий болсон бүхнийг баяжуулж, байгальтай зохицон амьдар” гэсэн уриатай.

**Generation-Z үеийнхний онцлог, чанарууд:** Тэд эдийн засгийн хямрал, бэрхшээлийг даван туулах чадвартай. Z үеийнхэн бол 2008 оны эдийн засгийн хямрал, түүний дараах эдийн засгийн удаан өсөлтийн үеийн гэрчүүд. Эдийн засгийн хямралын үед тэдний эцэг, эх хөрөнгөнийхөө 45 хувийг хэрхэн алдаж байсныг нүдээрээ харсан үе. Иймээс Z үеийнхэн мөнгөний талаар үргэлж боддог хэмээн судлаачид тодорхойлжээ. Тэд миллениалуудыг бодвол даруухан. Гэхдээ санхүүгийн тогтвортой байдалд хүрэхийн тул шаргуу ажиллахад бэлэн байдаг.

Судалгаанд оролцсон Z үеийнхний 77 хувь нь чөлөөт цагаараа ажил хийдэг гэжээ. Мөн 60 хувь нь хуримтлалтай байсан бол 57 хувь нь мөнгө үрэхээс илүү хэмнэхийг илүүд үздэг тухайгаа дурдсан байна. Үүнээс гадна Z үеийнхний талаар хийсэн өөр нэг судалгаанаас ажиглахад, тэд өрнөөс ямар ч хамаагүй аргаар зугтахыг хүсдэг гэжээ.

Зарим судлаачид Z үеийнхнийг Silent үеийнхэнтэй харьцуулах нь бий. Silent үе бол 1928-1945 оны хооронд төрсөн хүмүүсийг хэлнэ. Учир нь тэдэнд нийтлэг зан чанар бий. Тухайлбал, тэд гэр бүлийн дотно харилцааг үнэлдэг, эрсдэлд дургүй, хуримтлал үүсгэдэг мөн оптимист. Үүний зэрэгцээ, тэд эдийн засгийн том хямралын үед төрсөн хүмүүс. Иймээс тэд эдийн засгийн хямралыг даван туулах чадварыг илүүд эзэмшсэн байдаг байна.

**Тэд цахим эрин үеийг эзэгнэгчид:** Тэд цахим ертөнцөд төрсөн. Z үеийнхнийг цахим ертөнцийн хүүхдүүд гэж нэрлэж буй. Тэднийг төрөхөд л ухаалаг утас, Wi-Fi байсан. Өөрөөр хэлбэл, цахим ертөнцийн “уугуул” иргэд гэж хэлж болно. Тэд ухаалаг утасны ид хөгжлийн үед өсөж байна. Цахим орчин бол тэдний амьдралын салшгүй нэг хэсэг. Үүгээрээ тэд бусад үеийнхнээс ялгаатай. Тэдэнд өөрийгөө илэрхийлэх, мэдлэг боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэх маш өргөн боломжууд нээлттэй байна.

Миллениалууд (Generation-Y үеийнхэн) Facebook-ийг илүүд үзэж, мэдээллийн асар их ангал руу унаж, үнэн худал мэдээллийн дунд “живж” байна. Харин Z үеийнхэн бол дээрх мэдээллийг ялгах чадвартай бөгөөд Snapchat болон Instagram-ийг хамгийн дуртай сошиал сүлжээгээр нэрлэжээ.

Z үеийнхний сурлагын төвшнийг өмнөх үетэй харьцуулахад маш сайн гэж гарчээ. Харин тэдний талаар хийсэн өөр судалгаанаас ажиглахад, Z үеийнхний 85 хувь нь шинэ ур чадварыг эзэмшихийн тулд долоо хоногийн туршид онлайн-видео үзсэн гэжээ.

Дөрвөн хүүхэд тутмын гурав нь их дээд сургуулиас гадна сайн боловсрол эзэмших өөр арга байдаг гэв. Өөрөөр хэлбэл, тэд боловсролыг уламжлалт аргаар суралцах гэхээсээ илүүтэй бодит амьдралаас үнэлж баршгүй их туршлага хуримтлуулах боломжтой гэж үздэг ажээ.

**Тэд тэгш бус байдлыг үзэн ядагчид:** АНУ дээр жишээ авч үзье. Z үеийнхний ихэнх нь Обама ерөнхийлөгчийн үед өссөн тул тэд тэгш бус байдал бол хамгийн чухал асуудал гэж үздэг ажээ. Судалгаанаас харахад, Z үеийнхний 72 хувь нь арьс, өнгөөр ялгаварлан гадуурхах нь өнөөдрийн хамгийн чухал асуудал гэж үздэг бол 64 хувь нь жендерийн тэгш бус байдал, 48 хувь нь бэлгийн чиг хандлагын тэгш бус байдал чухал асуудал гэж үздэг юм байна.

Өөр судалгаанаас харвал, Z үеийнхний 36 хувь нь тэгш бус байдал бол хамгийн чухал шалтгаан бөгөөд ажил олгогчид тэднийг энэ асуудлыг дэмжээсэй гэж хүсдэг гэв. Харин 60 хувь нь ажил олгогчид нь хүний эрх, арьс өнгө болон бэлгийн чиг хандлагыг нь хүндэтгэхийг хүсдэг гэнэ.

**Тэд төвлөрөхдөө тааруу:** Generation Z-ийнхэн минут секундээр өөрчлөгдөн шинэчлэгдэж буй ертөнцөд амьдарч байна. Тиймдээ ч мэдээллийг боловсруулахдаа өмнөх үеийнхнээсээ хавьгүй хурдан бөгөөд төвлөрөх чадвар сул учраас аль болох богино, сонирхолтой контент тэднийг сонирхлыг татаж, хэрэгцээг нь хангадаг байна.

**Тэд олон ажлыг зэрэг амжуулдаг:** Үе бүрд өөрийн гэсэн онцлог давуу тал байдгийн хуулиар Generation Z-ийнхэнд олон зүйлийг зэрэг амжуулах давуу тал заяажээ. Gen Z-ийн хувьд компьютер дээр юм хийнгээ дуу эсвэл подкаст сонсоод, давхар утсаараа мэдэхгүй юмаа google-дээд, хажуугаар нь найзтайгаа чатлаад, за тэгээд эргэн тойрны хүмүүстэйгээ харилцаа үүсгэж, фэйсбүүк инстаграмдаа зураг авч Story оруулах нь энгийн л үзэгдэл. Тэд ажлаас ажлын хооронд маш хурдан шилждэг. “Multi-multi-tasking” гэж нэрлээд байгаа сүүлийн үеийнхний энэ хэвшил нь бидний эргэн тойрон дахь ажиллах орчин, арга барилыг нэлээд өөрчлөх төлөвтэй байна.

**Тэд илүү даяаршсан:** Сошиал медиагийн эрин үед өсөж буй тэдний 92 хувь нь аль нэг сошиал медиад бүртгэлтэй. Дэлхийн бүх л мэдээллийг авч буй учраас тэр хэрээр бодож сэтгэж, хийж үйлдэж байгаа нь илүү глобал шинжтэй байдаг. Нэгэн судалгаанд оролцсон насанд хүрэгчдийн 58 хувь нь “Орчин үеийн хүүхдүүд тухайн улсад буй насанд хүрэгчдээс илүү гадаадад байгаа үеийнхэнтэйгээ илүү адил” хэмээн хариулжээ. Интернэт хөгжиж эхлэх үед миллениалуудыг анхдагч глобал үе гэж нэрийдэж байв. Харин хүн төрөлхтний амьдарч буй ертөнц онлайн болохын хэрээр Generation Z-ийнхний бодож сэтгэж, харилцаж буй нь улам бүр глобал шинжтэй болж байна. 35-аас дээш насныхны 58 хувь нь “Өнөө үеийн хүүхдүүдийн хүсэл, сонирхол, хандлага нь улс орноороо ялгарахаас илүү дэлхий нийтийн хэмжээнд ижил төстэй болсон” гэдгийг хүлээн зөвшөөрдөг аж.

**Тэднийг дижитал хэрэгсэлгүйгээр төсөөлшгүй:** Gen Z технологийн дэвшлүүдтэй хамт өсөж торнисон учраас гар утас, компьютер зэрэг нь тэдний амьдралын салшгүй

хэсэг байдаг. Тэгэхээр ойрын ирээдүйд маркетинг, сурталчилгааны хэлбэр, хэв маягт томоохон өөрчлөлтүүд гарах болов уу. Эцэст нь дижитал төхөөрөмжийг Generation Z-ээс салгаж ойлгох боломжгүй юм. Тэд дижитал төхөөрөмжид донтох магадлал миллениалуудтай харьцуулахад 25 хувиар илүү байдаг аж.

**Generation-Z үеийнхний ерөнхий хэв шинж:** Тэд өөдрөг үзлийг биш, харин бодитоор хандахыг эрхэмлэдэг: Robert Half агентлагийн гаргасан инфографикаас харахад “Z” үеийнхний 77% нь шинэ мянганыхантай харьцуулахад өөрсдийгөө ажлын байран дээр илүү шаргуу хөдөлмөрлөх ёстой гэсэн хүлээлттэй байдаг гэнэ. Шинэ мянганыхны өөдрөг үзэл тэдний эцэг эхийн (baby boomers) бий болгож өгсөн жаргалтай хүүхэд наснаас шууд хамааралтай юм. Харин шинэ мянганы эцэг эхчүүдийн хувьд нөхцөл байдал тэс ондоо. Эдийн засгийн хямралын улмаас шинэ мянганы гэр бүлүүдийн хангалуун байдал 45% буурсан үзүүлэлт гарсан (Пью Рисерч компанийн мэдээгээр) бөгөөд тэдний хүүхдүүд буюу “Z” үеийнхэн энэхүү хүндхэн үед өсөж торнисон байдаг.

**Тэд дижитал ертөнцийн анхдагчид биш, харин байнгын оршин суугчид:** Интернэтийн хөгжилтэй зэрэгцэн өсөж дэвшсэн шинэ мянганыхныг “дэлхийн анхны дижитал үеийнхэн” гэж нэрлэдэг. Тэгвэл “Z” үеийнхнийг аль хэдийнээ хөгжин бий болсон орчин үеийн цахим ертөнцөд “мэндэлсэн” гэж хэлж болно. Шинэ мянганыхантай харьцуулбал “Z” үеийнхний дунд “Интернэт донтогчид”-ын тоо 25%-иар өндөр байдаг. Мөн тэдний 40% нь өөрсдийгөө дижитал төхөөрөмжгүйгээр төсөөлдөггүй бөгөөд аливаа газраас ариун цэврийн өрөө биш, харин Wi-Fi сүлжээ эрэлхийлдэг байна.

Нийт 50 оронд хийгдсэн судалгаанаас харахад дээр дурдсан бүхнээс хамааран “Z” үеийнхэн илүү даяарчлагдсан болж, эх оронч ба үндсэрхэг үзлээс холдсон байдаг байна. Мөн 35-аас дээш насны иргэдийн үзэж буйгаар “Z” үеийнхэн өөрийн орны иргэдээс илүү цахим ертөнцөд танилцсан найзтайгаа хялбар ойлголцож, нийтлэг сонирхолтой байдаг аж. Тиймээс бид 2020 он гэхэд нийтлэг үзэл суртал, нэгэн зорилготой жинхэнэ даяарчлагдсан онлайн нийгэмлэгийг олж харах магадлалтай юм.

Тэд минималист хэв маягийг эрхэмлэдэг. Амьдрах орчноо бага зардалтай, хэмнэлт бүхий аргаар санаандаа нийцсэн байдлаар бүрдүүлдэг. Их зүйл хурааж цуглуулахыг хүсдэггүй (X үеийнхний хураасан зүйлийг хараад инээд нь хүрдэг). Харин үүний оронд дурсамж бүтээх, туршлага хуримтлуулахад цаг, мөнгөө зарцуулдаг.

**Тэд тогтсон хэв маягийг биш, харин эрх чөлөөг эрхэмлэдэг:** “Z” үеийнхний шүтдэг загварын трендүүдээс харахад тэд гадаад төрхдөө төдийлөн анхаарал хандуулахаа больсон. Тэдний хувьд хүйсийн хоёрдмол байдлаар хувцасладаг Жейден Смит ба Лаки Блю Смит, диско-панк стильтэй Майли Сайрус, нормкор хэв маяг баримтлах дуртай Кендалл Женнер нарын загварын шүтээнүүд юм. Их Британийн Үндэсний иргэний төвийн өнгөрсөн жил хийсэн судалгаанд өсвөр насны европчуудын зөвхөн 63% нь л өөрсдийгөө эсрэг хүйсийн хүнд татагддаг гэжээ. Энэ дотроо өсвөр насны эрэгтэй хүүхдүүдийн 69% нь мөн эмэгтэй хүүхдүүдийн 56% нь өөрсдийгөө 100% гетеросексуал



гэж тодорхойлдог байна. Үүнээс харахад европын өсвөр насны хүүхдүүд өөрсдийгөө ямарваа нэгэн тодорхойлолтоор хязгаарлахыг хүсэхгүй байгаа бөгөөд, хоёрдмол хандлагатай байх нь ихэсжээ.

“Z” үеийнхний даяарчлагдсан үзэл бодол арьс өнгөний асуудал дээр ч бас ижил байдаг. Учир нь энэ үеийн төлөөлөгчид африк-америк ерөнхийлөгч мөрөөдөж байсан биш харин бодит байдал болсон үед төрсөн юм. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд (2000-2010) олон үндэстний гэр бүлд төрсөн хүүхдүүдийн тоо 13,4% өссөн байна. Мөн тэдгээр хүүхдүүд өсөж торниж байх хугацаанд ижил хүйстнүүдийн гэрлэлт үндсэн хуулиараа бүрэн зөвшөөрөгдсөн нь ирээдүйд багагүй нөлөө үзүүлэх биз ээ.

**Тэд ил тодыг биш, харин бие даасан байдлыг дээдэлдэг:** Өмнөх үеийнхэнтэй харьцуулбал “Z” үеийнхний хувьд зөвхөн ажиллаж буй газар нь биш, харин хэрхэн ажиллаж байгаа нь нэн чухал. Robert Half компанийн мэдээлснээр тэд хувийн мэдээллээ хуваалцах дургүй байдаг (Тиймээс л Snapchat, Instagram Stories гэх зэрэг дижитал контентыг цахим ертөнцөд хадгалан үлдээлгүй устгадаг тавцангууд тэдэнд таалагддаг). Түүнчлэн шинэ мянганыхан олон хүмүүстэй хамт ажиллахад зориулагдсан том, цэлгэр, оффисын орон зайг илүүд үздэг бол, “Z” үеийнхэн чимээгүй, хаалттай орчинд дуртай байдаг. Мөн тэд хэрэв ямар нэг зүйлийг сайн хийхийг хүсвэл өөр хүнд даатгалгүйгээр өөрөө гүйцэтгэсэн нь дээр гэж үздэг байна.

**Тэд өөрийн үеийнхнээ дагаж, дуурайдаг:** Өнгөрсөн үеийн баатрууд, түүхэн хүмүүсийг хүндэлдэг боловч ихэнх нь энэ цаг үедээ амьдарч буй хүмүүсийг даган дуурайж, адилхан болохыг эрмэлздэг. Технологийн компанийг үндэслэгчид, алдартай авхаалжтай удирдагч (энтерпренершип), олны итгэл хүндэтгэл хүлээсэн прагматик (ажил үйл нь бодит) хүмүүсийг илүүд үнэлдэг.

**Тэд сэтгэл хямралд илүү өртөмхий, эмзэг байдаг:** Тэгэхээр “Z” үеийнхэн хэр их аз жаргалтай байдаг вэ? Тэдний эрмэлзэл, найдвар биеллээ олдог болов уу? Харамсалтай нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 42 оронд хийсэн судалгаагаар Европ ба Америкт амьдардаг залуус өөрсдийнхөө амьдрал ба ирээдүйд хамгийн ихээр сэтгэл хангалуун бус байдаг аж. Мөн “Z” үеийнхний хамгийн гунигтай шинж тэмдгүүдийн нэг бол тэд сэтгэл мэдрэлийн өвчин, сэтгэл санааны гутралд өртөмтгий юм. Ингээд ч зогсохгүй тэд бусад үеийнхнээс илүү сэтгэл санааны өвчинд нэрвэгддэг байна. “Бид өнөөдөр аз жаргалгүй байгаагаа мөн хүрээлж буй ертөнцөөсөө айж буйгаа нээлттэй илэрхийлдэг хүүхдүүдийг харж байна. Z үеийнхний сэтгэлийг боловсрол, ирээдүй болон тэднийг 24 цаг хүрээлж буй онлайн ертөнц түгшээдэг. Тэд найзуудынхаа үдэшлэгт уригдаагүй болохоо онлайн ертөнцөөс олж харах бүрдээ өөрийгөө үнэлэх үнэлэмжээ бага багаар алддаг. Facebook ба Instagram энэ хүмүүсийн өөрийгөө үнэлэх сэтгэлтэй салшгүй холбоотой байх болно. Үүнтэй холбогдуулан амиа егүүтгэхийг хүссэн хүмүүсийн гуравны нэгийг өсвөр насныхан эзэлж байна” гэж Их Британийн амиа хорлолтын эсрэг үндэсний төвийн мэргэжилтэн Эмили Черри ярьсан байна.

Дани Улсад, Z үеийнхнийг “Кёрлинг үеийнхэн” гэдэг байна. Учир нь эцэг эхчүүд хүүхдийнхээ замд саад болох мөсийг маш шаргуу зүлгэж гөлгөр болгосноор хүүхдээ гэрэл гэгээтэй ирээдүйд бэлэглэж байна гэж боддог. Хаппен гэх инноваци судалгааны төвийн судалгаагаар, эцэг эхчүүд хүүхдээ “онцгой” гэж итгүүлэх бөгөөд ийнхүү хэт хамгаалалтад өссөн хүүхэд бөмбөлөгт өсөн “жинхэнэ амьдрал”-ын далайд хөл тавих айдастай болох магадлалтай. Эрсдэлтэй нүүр тулгарч үзээгүй, алдаа гаргаж үзээгүй тэд маань амжилтад хүрэх нь баталгаатай биш л бол туршихгүй, хийж үзэхгүй байх магадлалтай байна. Энэ тэднийг амьдрал дээр эмзэг, турьхан, өөрийн гэсэн үзэл бодолгүй болгох магадлалтай байна.

Энэбүхнөхцөлбайдлууд “Z” үеийнхэн болон нийгмийн хувьд хүндрэлтэй байж болзошгүй. Гэхдээ энэ үеийнхэн олон зүйл дээр маш хариуцлагатай, нухацтай ханддаг. Үүнээс гадна тэдний сонирхлыг улс төр, карьер татдаг бөгөөд хүйсийн ялгаа, нийгмийн тэгш бус байдал болон арьс өнгөний асуудалд тэд тэнцвэртэй хандаж чаддаг. Яг л энэ шинж тэмдгүүд ямар нэг байдлаар хөндөгдөх нь “Z” үеийнхнийг улам эмзэг болгодог байна. Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үед төрж өссөн хүүхдүүдийн нийтлэг онцлог, шинжүүдийг танин мэдэж, тэднийг Монгол эх орондоо Монгол хүн болгож төлөвшүүлэх Монгол ухаан бидэнд үгүйлэгдэж байна. Өөрөөр хэлбэл уламжлал, шинэчлэлийн гайхамшигт зохицлыг олох нь бидний судлах нэгэн зүйл болж байна. Үүний тулд юуны өмнө бид өөрсдөө дотоод сэтгэлийн хөгжлөө сайтар таньж, аминч үзлээсээ салж, хуучинсаг хандлагаа өөрчилж чадвал шинэ зууны шинэ үеийнхэн болох “Z” үеийнхэнтэй ойлголцон хамт хөгжих боломж бүрдэнэ. Bottom of Form

**АНХААРАХ ЗҮЙЛ:**

“Z” үеийнхэн сэтгэл хямралд илүү өртөмхий, эмзэг байдаг.

**ХИЧЭЭЛД АШИГЛАХ ЗУРАГ ДҮРСЛЭЛ:**

Хичээлийн агуулгад нийцэлтэй зураг, график, харьцуулсан хүснэгт, видео бичлэг ашиглан оруулна.

**НИЙТЭЭР ХИЙХ ДАСГАЛ:**

Нийт оролцогчдод нээлттэйгээр хийлгэх дасгал ажил, санал асуумжийн хэсэг юм. Жишээ нь: “Z” үеийнхний талаарх бидний төсөөлөл ярилцлага хийнэ. Аль болох олон оролцогч өөрийн санаа бодлоо хуваалцвал сайн.

**БҮЛГИЙН АЖИЛ:**

Оролцогчдыг тооноос нь хамаарч 5-6 баг болж ажиллана. Баг бүрд тодорхой даалгавар өгч, багууд хийсэн ажлаа бусдад танилцуулах. Жишээ нь: “Z” үеийнхний давуу болон сул талыг тодорхойлох.

- Сорил.** 1. Үе үеийн хүүхэд өсвөр үеийнхний амьдралын хэв маягт онцгой ялгаа байдаггүй.  
а/ үнэн      б/ худал
2. Байгаль болон амьтанд хайртай байдаг нь “Z” үеийн гол онцлог мөн.  
а/үнэн      б/худал
3. 1920-иод оны сүүл, 1940-өөд оны эхээр төрсөн хүүхдүүдийг “чимээгүй үеийнхэн” гэдэг байсан бөгөөд тэд “Z” үеийнхэнтэй ихэд төстэй.  
а/ үнэн      б/ худал
4. “Z” үеийнхэн сэтгэл хямралыг хялбархан даван туулах чадвартай байдаг.  
а/ үнэн      б/ худал

**СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА:**

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт “Өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлага”, түүнчлэн тус хуулийн тусгай ангийн 16 дугаар бүлэгт “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг”-ийг шинээр хуульчилж, зарим гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх шинж байхаар заасан. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг Хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг хуульчилж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар гэрч, хохирогчийг хүүхдийг хамгаалах, өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, хууль ёсны төлөөлөгч оролцуулах талаар зохицуулсан.

Өнөөгийн төвшинд хүүхэд үйлдсэн гэмт хэрэг, хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг шалгаж, нотлох ажиллагаа үндсэндээ “хүүхэд хамгаалал”-д тулгуурлан явагдахгүй байгаа тул тухайн хүүхдийн эрсдэл бүхий байдал шийдвэрлэгдэхгүй, ахин гэмт хэрэг үйлдэх, хохироход хүрч байна. Өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангах, тусламж үйлчилгээг үзүүлэх замаар хохирогч төвтэй арга барилыг хууль сахиулагчдаас шаардаж байна.

Орчин үед хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх тэдний аюулгүй байдлыг хамгаалах асуудал нэн чухалд тооцогддог. Иймд хүүхдийн чиглэлээр мэргэшин ажиллах хууль сахиулагчдад гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн мэдлэгийг эзэмших хэрэгтэй гэж үздэг болсон.

Энэхүү сургалтаар эрүүгийн болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хангах, туслалцаа үзүүлэх мөрдөн шалгах ажиллагаа үр дүнтэй явуулах, түүний эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг, чадварыг эзэмшүүлэхийг зорьсон болно.

**СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ:**

Энэхүү сургалтын зорилго нь Монгол Улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны турш хүүхдийн эрхийг үр дүнтэй хангах, хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар сургалтад оролцогчдын мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

Үүний тулд дараах асуудлыг нарийвчлан судалсан байх нь зүйтэй бөгөөд эдгээр асуудал тус бүрийг судалж шинжлэх нь энэ сургалтын зорилт тодорхойлогдоно:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрх, үүргийн талаарх ойлголт.
2. Гэмт хэрэг үйлдсэн болон гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийн онцлог
3. Тодорхой ажиллагаа явуулах арга зүй.
4. Процессын ажиллагаанд хүүхдэд хамааралтай бусад оролцогчийг оролцуулах хамтран ажиллах

### **СУРГАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ:**

Энэхүү сэдвийг судалснаар зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхдийн эрхийг хангах, туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлыг хамгаалахын тулд юунд анхаарах ёстой талаар мэдлэгтэй болно. Процессын ажиллагааны турш яллагагч, гэрч, хохирогч хүүхэд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч өмгөөлөгчийн хүсэлт гарахаас өмнөх харгалзан үзэх нөхцөл байдал, тусламж дэмжлэг, үйлчилгээ, аюулгүй байдлын хамгаалалтын үйл ажиллагааны үе шат, аргачилсан дарааллын талаар практик мэдлэг олгоно.

**СУРГАГЧ БАГШ:** Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс томилогдсон алба хаагч

**СУРГАЛТАД ОРОЛЦОГЧИД:** Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс томилогдсон алба хаагч.

**Сургалтын гарын авлага хэрэглэгчдэд:** Нийгмийн хамгааллын салбарын бодлого болон эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2012-2016 онд хүүхэд хамгааллын бодлогыг шинээр тодорхойлж, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг УИХ-аас батлан гаргаж, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Хүүхэд эрх, хүүхэд хамгаалал нь зөвхөн дээрх хоёр хуулиас гадна Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Иймд хууль сахиулагч хүүхэд хамгаалалд суурилсан арга зүйд суралцах шаардлагатай. Энэхүү сургалтын модуль нь зөрчил, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хангах талаар мөрдөгч нарт нэгдмэл ойлголт бий болгох зорилго бүхий сургалтыг эрхлэн явуулах сургагч багш нарт зориулсан сургалтын багц материал бөгөөд сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг нэг дор багтааснаараа онцлог болно.

**Сургалт зохион байгуулах арга зүйн зөвлөмж:** Насанд хүрэгчдийн сурах хэрэгцээ нь тухайн орны төр засгаас явуулж байгаа хүний хөгжлийг дэмжих бодлого, үзэл баримтлал, нөгөө талаас хувь хүний сайн сайхан аж төрөх амьдрал, ажил төрлийн хэрэгцээ шаардлагаас урган гарч байдаг. Насанд хүрсэн суралцагчид нь өөрийн гэсэн сурах арга барилтай байдаг төдийгүй бие биедээ зааж сургах, бусдад туслах амьдралын баялаг туршлагатай. Насанд хүрэгчдийн мэдлэг, туршлагыг чөлөөтэй солилцох замаар

сургалтыг удирдан зохион байгуулж чадвал сургалт илүү үр өгөөжтэй болдог тул энэхүү сургалтыг тэдний оролцоог хангасан, идэвхтэй арга зүйгээр удирдан явуулах нь зүйтэй.

### **СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ:**

Сургалтад насанд хүрэгчдийн сурах онцлог болон тэдний хэрэгцээг харгалзан оролцогчдын үйл ажиллагаанд тулгуурласан арга, аргачлалыг ашиглана. Сургалтыг явуулахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Мэдлэг эзэмших нь ямагт идэвхтэй сургалтад суурилсан байдаг.
- Мэдлэгийг эзэмшихийн тулд илүү идэвхтэй оролцоо шаардагддаг. Өөрөө оролцож, хийх замаар олж авсан мэдлэг илүү үлдэцтэй байдаг.
- Суралцагчдын идэвхтэй оролцооноос сургалтын үр дүн хамаарна. Зорилгод хүрэхийн тулд сургалтын зөвхөн агуулгад бус, сурах үйл явцад анхаарах нь чухал.

### **Сургалтын хөтөлбөрийн цаг, сэдвийн хуваарилалт [жишиг байдлаар]**

| №            | СЭДЭВ                                                                                                     | Цаг |
|--------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| 1            | Хүүхэд оролцсон, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааны онцлог          | 1   |
| 2            | Хүүхдийн эрхийн эсрэг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа                                                  | 1   |
| 3            | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангах нь                                     | 1   |
| 4.           | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил                                                             | 1   |
| 5.           | Сургагч багшид тавигдах шаардлага, насанд хүрэгчдийг сургах арга зүй, сургалтын үр дүнг үнэлэх, тайлагнах | 1   |
| Нийт цаг - 5 |                                                                                                           |     |

## 2.1. ХҮҮХЭД ОРОЛЦСОН, ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

|                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                          |
|-------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн нэр                       | “Хүүхэд оролцсон, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааны онцлог”                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                          |
| Хичээлийн гол зорилго               | Зөрчил, эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хүүхдийн эрхийг хангах талаар эрх зүйн гол баримт бичгүүд, хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг шалтгаан, нөхцөлийн талаар зөв ойлголт, мэдээлэл өгөхөд энэхүү сэдвийн зорилго оршино.                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                          |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | Хүүхэд хамгаалал нь тусдаа салбар биш бөгөөд зөрчил шалгах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хангаж, хамгаалах нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт хамаардаг. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчид хүүхдийн эсрэг болон хүүхэд оролцож үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг ул суурьтай ойлгож, хүүхэд хамгааллын талаар өөрийн гэсэн мэдлэг, ойлголтыг өргөжүүлж, гүнзгийрүүлэх шаардлагатай. |                                                                                                                                                          |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | 5 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Жишиг бодомж                                                                                                                                             |
|                                     | 15 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Танилцуулга (лекц): •Өсвөр насны хүн, гэмт хэрэг үйлдсэн хүүхэд; Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд хамгаалал;PP (Powerpoint) ашиглан тайлбарлана |
|                                     | 20 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Нийтээр ажиллах дасгал: Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийг шалгахад гардаг нийтлэг алдааны талаар ярилцах                               |
|                                     | 20 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Бүлгийн ажил: Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг тодорхой кэйс дээр ярилцана (Гарын авлагад байгаа 8 кейсээс ашиглана).      |
|                                     | 5 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Хяналтын асуулт хариулт                                                                                                                                  |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | Дараах ойлголт, ухагдахууныг ашиглаж, тайлбарлаж сурна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэд;</li> <li>• Хүүхдийн эрх;</li> <li>• Хүүхэд хамгаалал;</li> <li>• Өсвөр насны хүн;</li> <li>• Эрүүгийн хариуцлага;</li> <li>• Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ;</li> <li>• Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд;</li> <li>• Гэр бүлийн хүчирхийлэл;</li> <li>• Хүүхдийн эрхийн эсрэг зөрчил;</li> </ul>                                         |                                                                                                                                                          |

### Сургалтын өмнө авах бодомж:

Мэдлэгийн түвшин болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрхийн талаар оролцогчдын санаа бодлыг урьдчилсан байдлаар тогтоох, тандах: ярилцах, сорил авах гэх мэт аргаар. Дараах асуулгыг ашиглаж болох юм.



Дараах бодомжуудтай санал нийлэх үү? Тохирох хариултыг тэмдэглэнэ үү.<sup>1</sup>

| №  | Өгөгдөл                                                                                                                          | Санал бүрэн нийлнэ | Санал нийлнэ | Эргэлзж байна | Санал нийлэхгүй | Санал огт нийлэхгүй |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|--------------|---------------|-----------------|---------------------|
| 1. | Хүүхэд хамгаалал нь Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай огт хамааралгүй ойлголт юм. |                    |              |               |                 |                     |
| 2. | Гэмт хэрэгт хохирсон хүүхдийг насанд хүрсэн хүмүүсийн нэгэн адил хуульд заасны гэрч хохирогчийг хамгаалах тухай дагуу хамгаалдаг |                    |              |               |                 |                     |
| 3. | Эрүүгийн хэрэг болон зөрчил шалган шийдвэрлэх явцад хүүхдийн эрхийг хамгаалах нь цагдаагийн алба хаагчийн үүрэг мөн              |                    |              |               |                 |                     |
| 4. | Хүүхэд хохирсон хэрэгт тухайн хүүхдийн эсрэг ашиг сонирхолтой эцэг эхийг оролцуулж болно                                         |                    |              |               |                 |                     |
| 5. | Зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэхэд заавал хүүхдийн байгууллагатай харилцах, хамтран ажиллах шаардлагагүй                          |                    |              |               |                 |                     |

**Мэдээлэл өгөх:** Оролцогчдод зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл өгнө.

- Оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийн эрх зүйн зохицуулалтын талаар хэлэлцэнэ, мэдээлэл солилцоно.
- Нэмэлт тайлбарыг багшийн зүгээс өгч, нэгдсэн ойлголтыг бататгана.

**Хяналтын асуулт:**


1. Хүүхэд хамгаалал ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ямар хамааралтай вэ?
2. Мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулахад хүүхэд хамгааллын талаар судлах нь таны ажил мэргэжилтэй ямар холбоотой вэ? Та энэ талаарх мэдлэг, чадвараа ажилдаа хэрхэн ашиглах вэ?
3. Таны бодлоор хүүхэд оролцож үйлдэж байгаа болон хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн суурь шалтгаан нь юу вэ? Онцлог шинжийг дурдана уу

## СУРГАЛТАД АШИГЛАХ МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ

Эрх зүйт төр нь хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх төдийгүй, түүнийг хамгаалах, хэрэгжүүлэх, хангах механизмыг эрх зүйт хууль, ардчилсан аргаар бүрдүүлдэг. Хүний

<sup>1</sup> Д.Энхжаргалын “Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх” амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлагаас авав.

эрхийг хангах үндэсний механизмд шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, өмгөөлөх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд ордог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрх зүйн байдлыг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн Эрхийн Конвенц, Насанд хүрээгүй хүний хэргийг байцаан шийтгэх ажиллагаа явуулах НҮБ-ын жишиг дүрэм (Бээжингийн дүрэм), Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын удирдамж (Риадын удирдамж), НҮБ-ын 1997\30 тоот тогтоол- Насанд хүрээгүй хүний хэргийг байцаан шийтгэх ажиллагаа явуулах Вены удирдамж зэрэг насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх НҮБ-ын удирдамжуудад нийцүүлэн хүүхдийн хамгаалалд нөлөө үзүүлэхүйц хуулиудыг шинээр баталж, мөн холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн. Хууль зүйн салбар дахь хүүхэд хамгаалал нь дараах зорилготой.<sup>2</sup>



Иргэний хуульд “Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна” мөн иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийнэ гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцох чадамжийг тодорхойлсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1.1 (өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг)-д заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол

2 УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн судлаач, хяналтын прокурор Г.Оюунболд “Өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сорилт, бэрхшээл” 13 дахь тал

зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно” гэж заасан нь өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй байхыг тэнцвэржүүлж, эрх зүйн хувьд бүрэн бус чадамжийг бүрэн болгож, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангаж буй заалт болж чадсан юм.

НҮБ-ын 1985 оны “Өсвөр насны хүнд хэрэглэх шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм” буюу Бээжингийн дүрмийн 3.3 дугаар зүйлд гишүүн улс орнууд нь энэхүү дүрэмд заасан жишиг хэм хэмжээг өсвөр насны хүнд хэрэглэхээс гадна тухайн улсын хуулиар насанд хүрсэн гэж тооцогдсон залуу хүнд мөн адил хэрэглэх боломжийг дотоодын хууль тогтоомжид тусгахыг үүрэг болгосон. Иймд уг олон улсын хүний эрхийн стандартыг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад шинээр тусгасан байна. Энэхүү шинээр орсон зохицуулалттай холбогдуулан шүүх “арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүн”-д энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно. Өөрөөр хэлбэл шүүх энэ бүлгийн зохицуулалтыг хорин нэг хүртэл насны хүнд хэрэглэх боломжтой болсон байна. Насны доод хязгаарыг 14 насанд хүрсэн гэдгээр тогтоож өгсөн.

Хүүхдийн хамгаалалд нөлөө үзүүлэхүйц хуулиудад дараах хуулиуд хамаарна. Үүнд:

- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль,
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль (2016.02.05)
- Иргэний хууль

Дээр дурдсан бүх хуулиуд хүүхдийн асуудлыг хамаарах хууль зүйн үндэс болдог бөгөөд дараах 4 хууль насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх ажиллагаанд голлох үүргийг гүйцэтгэдэг. Үүнд: Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх

тухай хууль болон холбогдох бусад хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хамтаар 2017 оны 9 дүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлжээ.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуульд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн бүтцийг баталгаажуулсан байна.

Цагдаа, хууль хяналтын байгууллагын зүгээс хохирогч, гэрч хүүхдээс хохирол, нотолгоо шаардах, гомдол, нэхэмжлэлээ буцаах, хэрэгсэхгүй болгох, эвлэрүүлэх оролдлого хийх, гэр бүлээс тусгаарлах нөхцөлд оруулах зэрэг байдлууд практикт элбэг байдаг.

Эрүүгийн хэргийг хянан шалгах үйл ажиллагаанд хохирогч хамгааллын сэтгэлгээ хандлага сул, хүүхдийн эрхийн мэргэжилтэн, шинжээчдийг оролцуулдаггүйгээс хүүхдийн эрх ашиг зөрчигддөг. Хүүхдийн хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах эрхийг зөрчих, тэр бүү хэл, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч хүүхдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр цацах зэрэг зөрчлүүд гардаг.

Гэмт хэрэгт оролцсон, ял шийтгэл хүлээсэн хүүхдийн асуудалд хандах хандлага сул хэвээр байсаар байна. Тэднийг буруутгах, хүүхэд залууст буруу хандах байдал байсаар байгаа нь тэдгээр хүүхдүүдийн дунд хийсэн судалгаагаар батлагдаж байна. Тэдгээр хүүхдийн 80% нь шүүх хурал болтол сэтгэлийн дарамттай, хар дарж зүүдэлдэг, 70% нь байцаалтаас хойш амиа хорлох бодол тээж байсан, 15% нь ийм оролдлого хийж байсан, 10% нь урьдчилан хорих нөхцөлд буюу “Ганц худаг”-т байхдаа шоконд орсон байдаг. Ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, нийтэд тустай ажил хийлгэх; зорчих эрхийг хязгаарлах; сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих зэрэг шийтгэлийн арга хэмжээг нэвтрүүлэх шаардлагатай.

Гэмт хэргийн хохирол хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, нийтэд тустай тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно.

Үр дүнг үл хайхрах, цагдаа, хүүхдийн байгууллагын ажилтны хамтрах эрмэлзэл сул, засаг дарга хуулиа үл биелүүлэх, эцэг эх, хүүхэд хандах хүнгүй зэрэг асуудлууд байсаар байгааг дурдах хэрэгтэй. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй хувь хүмүүс, байгууллагыг төрөөс урамшуулан дэмжих ажлыг зохион байгуулах. Монгол Улс хүүхэд хамгаалалтын системээ олон улсын стандартад хүргэж, хамгаалалтын үндэсний системээ бэхжүүлэх шаардлагатай байна. Салбар хоорондын уялдаа холбоо сайн байх ёстой. Гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл

ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй байгаа билээ. Эмзэг бүлгийн гэр бүлүүдэд ядуурлаас чөлөөлөгдөх удирдамж, дэмжлэг хэрэгтэй байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16 дугаар бүлэг (Хүүхдийн эсрэг гэмт хэрэг)-т дараах гэмт хэргүүд хуульчлагдсан. Үүнд:

- 16.1 дүгээр зүйл. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах;
- 16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах;
- 16.3 дугаар зүйл. Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх;
- 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах;
- 16.5 дугаар зүйл. Хүүхэд солих;
- 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах;
- 16.7 дугаар зүйл. Хүүхэдтэй хэрцгий харьцах;
- 16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах;
- 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах;
- 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх;
- 16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх<sup>3</sup> зэрэг багтана.

Хүүхдийн эсрэг гэмт хэргүүдийн бүрэлдэхүүн дараах нийтлэг шинжтэй. Үүнд:

**Объект:** Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүүхдийн эрх ашгийг зөрчиж, хохироосон байна. Тодруулбал, Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд халдсан, ёс суртахууны хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж хохироосон байна.

**Объектив шинж:** Гэм буруутай этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөн хүүхэд хохирсон байна.

**Субъектив шинж:** Хүүхдийн эрхийг зөрчсөн гэмт этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйд шууд санаатайгаар хандаж, хүүхдийн эрх, ашгийг хохироосон үр дагаварт хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, гэм буруутай этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бусыг, үүний улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хохирохыг мэдэж, түүнийг хүсэж, тийм үр дагаварт хүргэсэн байна.

**Субъект:** Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, манай улсын, гадаад улсын хоёрдмол харьяалалтай, аль ч улсын харьяалалгүй иргэн байна<sup>4</sup>.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон. Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.2 дугаар (Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны

3 Монгол Улсын хууль. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). Улаанбаатар. 2017.

4 Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Онол, практикийн асуудал. Улаанбаатар. 2021. 94 дэх тал.

хязгаар) зүйлийн 1 дэх хэсэгт: “Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Хүүхдийн эрхийн тухай конвенцыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн уг заалттай харьцуулбал, хүүхэд гэх тодотголтой хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага үүсэж байна.

Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр, зөв тайлбарлах, хэрэглэх нь эрүүгийн процессын оролцогчдын зүгээс ямар нэг ялгаварлан гадуурхалт, авлига байгаа гэсэн хардалт дагуулахгүйгээр мэргэжлийн түвшинд ажиллах нэгэн баталгаа нь болж өгнө гэдгийг эрүүгийн эрх зүйн харилцаанд голлох үүрэгтэй оролцдог субъектуудад зөвлөж байна.

- Түүнчлэн гэрч, хохирогч хүүхэдтэй харьцах сэтгэл зүйн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх.
- Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, тэр тусмаа анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудыг өөрсдийг нь гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийг төрийн нэрийн өмнөөс өмгөөлөн хамгаалагчид гэдэг итгэл үнэмшил, сэтгэлгээг суулгах. Гэр бүлийн хүчирхийлэл, хүчин болон бусад бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчидтой ажилладаг тусгай сэтгэл зүй, чадвар, сэтгэлгээ бүхий мэргэжилтэн ажиллуулах, туслалцаа авах.
- Насанд хүрээгүй хүүхдэд тэнсэн харгалзах ял, тусгаарлах ялыг хэрэгжүүлэх, хорихоос өөртөрлийн хүмүүжүүлэх ялыг хэрэглэх, нийгэмшүүлэх, боловсруулах, амьдрах ур чадвар суулгах үйл ажиллагаануудад хөрөнгө оруулалт хийх, дэмжлэг үзүүлэх.
- Хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх талаар дорвитой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх, шинэ соёл нэвтрүүлэх.

## 2.2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

|                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                       |
|-------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн нэр                       | Хүүхдийн эрхийн эсрэг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                       |
| Хичээлийн гол зорилго               | Хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг зүйлчлэх, шалган шийдвэрлэхдээ хуулийн зүйл, хэсгийг практикт хэрэглэх талаар нэг мөр ойлголт өгөх, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын агуулга заалтуудыг зөв хэрэгжүүлэх ур чадвар эзэмших                                                                                             |                                                                                                                                                                       |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | Хүүхдийн эрхийг зөрчих зөрчлийн ойлголт, онцлог;<br>Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар гомдол мэдээллийг хүлээн авах<br>Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулахад хүүхдийн эрхийг хангах<br>Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг ялган зүйлчлэх<br>Хүүхдийн эсрэг зөрчлийг шалгахад анхаарах зүйл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл, онцлог |                                                                                                                                                                       |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | 5 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Жишиг сорил                                                                                                                                                           |
|                                     | 15 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Танилцуулга (лекц): Хүүхдийн эрхийн эсрэг зөрчил, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа дах хүүхэд хамгаалал;PP (Powerpoint) ашиглан тайлбарлана                         |
|                                     | 20 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Нийтээр ажиллах дасгал: Хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг зүйлчлэх, шалган шийдвэрлэхдээ хуулийн зүйл, хэсгийг практикт хэрэглэх                                         |
|                                     | 20 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Бүлгийн ажил: Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын агуулга заалтуудыг зөв хэрэгжүүлэх, тодорхой үйл ажиллагааг үр дүнтэй явуулах (кейс ашиглана). |
|                                     | 5 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Хяналтын асуулт хариулт                                                                                                                                               |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | <ul style="list-style-type: none"> <li>Зөрчлийн тухай Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Сургагч багшийн гарын авлага ХЗДХЯ, 2017 он</li> <li>Зөрчлийн хэрэг (Хүүхдийн эрхийн улсын байцаагч нарт зориулсан гарын авлага) 2021 он. Нийслэлийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар</li> </ul>                                       |                                                                                                                                                                       |

### Сургалтын өмнө авах сорил:

#### Зөрчлийн тухай хууль

- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд хуулийг буцаан хэрэглэх эсэх.
  - Хуулийг буцаан хэрэглэнэ
  - Хуулийг буцаан хэрэглэхгүй
  - Зөрчилд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах шийдвэр гарсан тул хуулийг буцаан хэрэглэхгүй
  - Аль нь ч биш
- Төрийн албан хаагч албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь



- зөрчлийн шинжтэй бол хэрхэн шийдвэрлэх вэ?
- Түүнийг албан тушаалаас нь түдгэлзүүлж, тусгай ангид заасан шийтгэл оногдуулна
  - Албан үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь шийтгэлээс чөлөөлөх үндэслэл мөн
  - Сахилгын шийтгэл хүлээлгэнэ
  - Аль нь ч биш
3. Нэг үйлдэл, эс үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжийг агуулсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх вэ?
- Зөрчил үйлдсэн хүнд аль ашигтай байдлаар шийдвэрлэнэ
  - Шийтгэлийг давхардуулж оногдуулна
  - Хөнгөнийг хүндэд нь багтаах зарчмаар шийтгэл оногдуулна
  - Аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна
4. Аль субъект баривчлах шийтгэл оногдуулах вэ?
- Прокурор
  - Мөрдөгч
  - Шүүгч
  - Олон нийтийн цагдаа
5. Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчил үйлдсэн хүнийг шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болох уу?
- Үндэслэл болно
  - Нэг үйлдэл, эс үйлдэхүйд давхар шийтгэл оногдуулахгүй
  - Үндэслэл болохгүй
  - Шударга ёсны зарчмыг зөрчих тул үндэслэл болно
6. Зөрчлийн тухай хуулийн “Хууль ёсны зарчим”-ын агуулгыг аль нь илэрхийлэхгүй вэ?
- Зөрчлийн шинжийг зөрчлийн тухай хуулиар тодорхойлно
  - Зөрчлийн шинжийг захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлно
  - Зөрчлийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй
  - Зөрчлийн хуулийг төсөөтэй хэрэглэнэ
7. Зөрчил гэж .....хэлнэ. Оновчтой тодорхойлолтыг ол.
- Үндсэн хууль зөрчсөн Үндсэн хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг
  - Зөрчлийн тухай хууль болон бусад хуульд заасан хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг

- c. Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, зөрчлийн хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг
  - d. Зөвхөн захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг
8. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаж аль шийдвэрийг гаргах вэ? хамаарахгүйг ол.
- a. Хэрэгсэхгүй болгох
  - b. Шийтгэл оногдуулах
  - c. Харьяаллаар шилжүүлэх
  - d. Шийтгэлээс чөлөөлөх
9. Оролцогч зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг аль субъектэд гаргах вэ?
- a. Шүүгч
  - b. Прокурор
  - c. Хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан
  - d. Эрх бүхий албан тушаалтан
10. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект аль нь биш вэ?
- a. Өмгөөлөгч
  - b. Шүүгч
  - c. Прокурор
  - d. Эрх бүхий цагдаагийн ажилтан

#### **Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль**

11. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаж ямар шийдвэрийг гаргах вэ? Хамаарахгүйг ол.
- a. Хэрэгсэхгүй болгох
  - b. Шийтгэл оногдуулах
  - c. Харьяаллаар шилжүүлэх
  - d. Шийтгэлээс чөлөөлөх
12. Оролцогч зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг аль субъектэд гаргах вэ?
- a. Шүүгч
  - b. Прокурор
  - c. Хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан
  - d. Эрх бүхий албан тушаалтан

13. Аль субъект зөрчлийг нэгдсэн бүртгэлд бүртгэх вэ?
- Шинжээч
  - Хэрэг бүртгэлтийн удирдах албан тушаалтан
  - Прокурор
  - Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий албан тушаалтан
14. Аль нь зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болохгүй вэ?
- Шийтгэл хүлээх насанд хүрээгүй
  - Тулгарсан аюулыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй нөхцөлд зөрчил үйлдсэн
  - Зөрчил үйлдсэн хүн нас барсан
  - Гэмт хэргийн шинжтэй бол
15. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд холбогдогчийн хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх эрхтэй субъект аль нь вэ?
- Шүүгч
  - Прокурор
  - Эрх бүхий албан тушаалтан
  - Хил хамгаалах ерөнхий газар
16. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект аль нь биш вэ?
- Өмгөөлөгч
  - Шүүгч
  - Прокурор
  - Эрх бүхий цагдаагийн ажилтан
17. Зөрчилд холбогдогчийн эрх аль нь биш вэ?
- Ямар зөрчилд холбогдон шалгагдаж байгааг мэдэх, энэ талаарх мэдээллийг эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхээс асуух
  - Эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах
  - Зөрчлийн улмаас өөрт учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлтээ эрх бүхий албан тушаалтанд гаргах
  - Хохирогчийн гомдолтой танилцаж тайлбар гаргах
18. Зөрчил шалгах тодорхой ажиллагааны төрөл аль нь биш вэ?
- Байцаалт авах
  - Мэдүүлэг авах
  - Шинжилгээнд зориулж дээж авах
  - Эд хөрөнгө битүүмжлэх

19. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах зорилгоор ямар эрх хязгаарлах арга хэмжээг хэрэглэж болох вэ?
- Хүнийг саатуулах
  - Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох
  - Хариултад дурдсан бүх арга хэмжээг хэрэглэж болно
  - Холбогдогчийн баримт бичгийг хураан авах
20. Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөрчил гаргасан холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор хүнийг саатуулах, эрх хязгаарлах арга хэмжээг ямар хугацаагаар хэрэглэж болох вэ?
- 6 цагаас илүүгүй хугацаагаар
  - 10 хоног хүртэл хугацаагаар
  - Харьяалах шүүхэд албан ёсоор мэдэгдэж 72 цаг хүртэл хугацаагаар

**Тестийн хариу: 1-а, 2-с, 3-д, 4-с, 5-с, 6-д, 7-с, 8-с, 9-б, 10-а, 11-с, 12-б, 13-с, 14-д, 15-б, 16-а, 17-с, 18-а, 19-с, 20-а**

#### Хяналтын асуулт:

- Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил үйлдэгчийн онцлог? Бусад төрлийн зөрчлийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчээс ямар ялгаатай вэ?
- Дээр тодорхойлсон ялгааг хүүхдийн эрхийн эсрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хэрхэн ашиглах вэ? Өөрөөр хэлбэл, та бүхэн тэдний талаарх мэдлэг, ойлголтоо өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглах вэ?
- Хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг үр дүнтэй шалган шийдвэрлэхийн тулд юуг анхаарах шаардлагатай вэ?
- Цагдаагийн алба хаагч болон хүүхдийн эрхийн улсын байцаагчийн харьяалан шалгах зөрчлийн ялгаа, онцлог юу вэ?
- Хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг харьяалал тогтоож шилжүүлэхэд юу анхаарах вэ?
- Хүүхдийн эрхийн эсрэг үйлдэгдэж байгаа зөрчлийн шалтгаан, нөхцөлийг нэрлэнэ үү?


#### СУРГАЛТАД ӨГӨХ МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ


Зөрчлийн тухай хууль нь:

- үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох;
- зөрчил үйлдсэн хүн хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийг тодорхойлж, түүний төрөл хэмжээг тогтоох;

- в. зөрчилд оногдуулах албадлагын арга хэмжээг тодорхойлж, түүний төрөл хэмжээг тогтоох замаар Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх зорилгыг агуулжээ.

Цагдаагийн алба хаагч эсхүл Хүүхдийн эрхийн улсын байцаагчид харьяалан шалгах хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг зөв ялган зүйлчлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг үнэн зөв, чадварлаг хэрэгжүүлэх, хөтлөгдөх баримт бичгийг үндэслэл, журмын дагуу боловсруулах шаардлага тавигдаж байгаа бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлд заасан “Эрх бүхий албан тушаалтан”-ы бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллана.





Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар дуудлага мэдээллийг хүлээн авах (102, 108 гэх мэт тусгай дугаарын утсаар эсхүл дүүргийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн газрын дуудлагын утас) ажиллагаа ямар нэг саадгүй явагдаж байгаа боловч хаягаар хүрэлцэн очих, нөхцөл байдлын үнэлгээ хийх, улмаар хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах анхан шатны үйл ажиллагаа явуулахаас эхлээд тухайн зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг тооцох зэрэг хүндрэл бэрхшээлтэй учирдаг.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолохоор заасан. Өөрөөр хэлбэл Зөрчлийн тухай хуульд зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг торгох шийтгэлийн хэмжээнээс харгалзан 6 сараас 2 жил хүртэл хугацаатай тогтоосон байна. Түүнчлэн зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа нь дараах онцлог шинжтэй байна. Үүнд:

Зөрчил хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчил шалган шийдвэрлэх эхлүүлэх өдрийг хүртэл тоолж, зөрчил гаргагчийг тодруулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулснаар хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсоохоор заасан. Өөрөөр хэлбэл зөрчил гаргагч хүн, хуулийн этгээдэд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх явуулж эхэлсэн бол уг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулна.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хэд хэдэн зөрчил үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг зөрчил тус бүрд шинээр тоолно.

**Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тооцно. Үүнд:**

1. Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт заасны дагуу 10,000 төгрөгнөөс 500,000 төгрөг хүртэл торгох шийтгэл оногдуулах /нэг нэгж=1000 төгрөг/ зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн.
2. Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2 дах заалт нь 500,000 төгрөгнөөс дээш 10,000,000 төгрөг хүртэл торгох шийтгэл оногдуулахаар заасан /нэг нэгж=1000 төгрөг/ зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;
3. Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.3 дах заалт нь 10,000,000 төгрөгнөөс 20,000,000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;

Хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйд мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгаж байгаа тухайн үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бөгөөд Зөрчлийн хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг болох “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг”-т Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирлын хэмжээ болон үйлдлийн бусад шинжээр Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл заасан хүүхдийн эрхийн зөрчил болох нь тогтоогдсон бол эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тухай тогтоол гарсан өдрөөс тухайн зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой ч түүнийг хангах талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэн гэж үзнэ” гэсэн нь зөрчил үйлдэх хэлбэрийг заасан. Урьд бидний үзэж байсанчлан зөрчлийн гэм буруу гэсэн ойлголт байхгүй болсон бөгөөд санаатай эсхүл болгоомжгүйгээр зөрчил гаргасан нь зөрчлийн зүйлчлэлд нөлөөлөхгүй болно.

Зөрчлийн тухай хуульд зөрчлийн шийтгэл, түүний хэмжээ хязгаарыг баримтлан хүн, хуулийн этгээдээс ямар журам зөрчсөн тохиолдолд зөрчил болохыг тодорхой заасан. Зөрчлийн шинж нь Зөрчлийн тухай хуулиар тодорхойлсон зөрчилд тооцогдох хүн, нийгэмд харш үйлдэл эс үйлдэхгүйг бүрдүүлэгч шинжүүдийн нийлбэр цогц юм. Эдгээрийг хууль зүйн ач холбогдлоор нь объектив шинж, субъектив шинж гэж ангилна.

Хууль сахиулагч, эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулахын тулд уг зөрчлийн шинж болон бусад нөхцөл байдлыг тогтооно. Тухайлбал, зөрчлийн нэг үндсэн шинж болох үйлдэл, эс үйлдэхүй нь захиргааны хууль тогтоомжоор урьдчилан хориглосон заалт буюу нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл хууль, захиргааны хэм хэмжээний актаар урьдаас журамлан тогтоогоогүй уг үйлдэл, эс үйлдэхүйд зөрчлийн шийтгэл оногдуулахгүй гэсэн үг юм.



**Зөрчилд оногдуулах шийтгэл:** Зөрчлийн шийтгэл нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл бөгөөд өөрийн мөн чанараараа бусад хариуцлагаас ялгагдах онцлогтой байна. Үүнд:

1. Шийтгэл хүлээлгэх үндэслэл нь хууль, зөрчлийн тухай хууль, нийтээр дагаж мөрдөх журмыг зөрчих буюу зөрчил гаргах явдал юм. Тухайлбал, хүүхдийн эрхийн эсрэг зөрчил нь Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын хуулиас гадна хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар заасан захиргааны хэм хэмжээний актаар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй байна. Түүнчлэн хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийн шинж нь Зөрчлийн тухай хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүйгээс гадна Боловсролын тухай багц хуулиар эрх олгож заасан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол, сайдын тушаал/ байдаг.
2. Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулахаар заасан байна. Тухайлбал, хүүхдийн эрхийг эсрэг үйлдэгддэг хор аюултай үйлдэл, эс үйлдэхүйг эрэмбэлэн, Зөрчлийн тухай хуульд “Хүүхдийн эрхийг зөрчих” гэсэн зөрчлийг тусгасан. Иймд тухайн хуулиар хориглосон боловч Зөрчлийн тухай хуульд зөрчил гэж үзээгүй бол хариуцлага хүлээлгэхгүй үйлдэл, эс үйлдэхүйд хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Хүүхэд хамгааллын хуульд заасны дагуу тусламж, үйлчилгээг үзүүлж, шаардлага, зөвлөмж хүргүүлдэг.
3. Хуулиар эрх олгосон, харьяалал тогтоосон зөрчлийн шийтгэлийг шүүгч, хууль сахиулагч, эрх бүхий албан тушаалтан оногдуулна. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг шалган шийдвэрлэх зөрчлийн харьяалал, шийтгэл оногдуулах журмыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тогтооно.
5. Шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулах эрх бүхий субъектийн хооронд захирах, захирагдах харилцаа үүсээгүй байна. Өөрөөр хэлбэл Захиргааны ерөнхий хуульд заасан хариуцлагын төрөлд хамаарахгүй.
6. Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу шийтгэл оногдуулах үндэслэл нь:
  - Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинж, нийгэм, төр, хүн, хуулийн этгээд, нийтийн эрх ашигт учруулсан хохирлын хэр хэмжээг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна.
  - Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг үүргээ биелүүлээгүйтэй нь холбогдуулж шийтгэл оногдуулсан нь уг үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн халамж үйлчилгээний тухай хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан тохиолдолд тухайн зөрчил гарах болсон нөхцөлийг арилгах, аюулгүй ажиллагааны арга хэмжээг хангах зэрэг хуулиар хүлээсэн үүргээс чөлөөлөхгүй.


- Нэг үйлдэл эс үйлдэхүйгээр хоёр ба түүнээс дээш зөрчлийн шинжийг хангасан бол аль хүнд санкцтай зөрчлийн шийтгэлийг оногдуулах ба бусад зөрчилд оногдуулахаар заасан албадлагын арга хэмжээг оногдуулж шийдвэрлэнэ.

### ЗӨРЧИЛҮЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ

Цагдаагийн албан хаагч, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн Зургаадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэлийн дагуу гомдол, мэдээллийг хүлээн авна.

Эрх бүхий албан тушаалтан нь мөн энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн, эсхүл хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн бол гомдол, мэдээллийг хүлээн авах бөгөөд 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу:

### ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН НЬ ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВААД:



- Уг гомдол, мэдээлэл гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй эсэх,
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллын дагуу Хүүхдийн эрхийн улсын байцаагчид харьяалах хэрэг мөн эсэхэд дүгнэлт хийснээр “гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах” эсхүл зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан нь “гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх” тогтоол үйлдэж прокурорт уламжилна.

**Харьяаллын дагуу шилжүүлэхэд анхаарах зүйлс:** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн Нэгдүгээр бүлгийн 1.8 дугаар зүйлийн цагдаагийн алба хаагч, хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл, 10.23 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг шалгахаар харьяалал тогтоосон.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчид хандахаар харьяалсан хэргүүд:

1. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд:

- 1.1. хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан;
- 1.2. хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн;
- 1.3. хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй;
- 1.4. хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хүн, хуулийн этгээд нь:
  - 2.1. хүүхдэд утаат тамхи татахыг санал болгосон, бэлэглэсэн, эсхүл утаат тамхи олж авах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлсэн;
  - 2.2. хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, өв залгамжлах, эсхүл ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарласан;
  - 2.3. хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Хүүхдийг:
  - 3.1. аливаа төлбөр, хураамжийг төлөөгүй үндэслэлээр хүүхдийн сурч боловсрох эрхийг хууль бусаар хязгаарласан;
  - 3.2. өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан;
  - 3.3. өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор хууль бусаар хүүхдийн нэрийг барьж, ашиг олох, эсхүл амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд нь харшлах, аюул учруулах тоглоом, наадам, бусад арга хэмжээнд оролцуулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Сургууль, сургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, асрамж, халамжийн төв, хүүхэд хамгааллын төв болон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн эрх зөрчигдсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй

бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

7. Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архиан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**Санамж:** Энэ зүйл ангийн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд харьяалал тогтоож өгсөн.

8. Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдэгдэх, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тодруулга: Эрх бүхий албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, мэдээлэл нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Хүүхдийн эрхийн улсын байцаагчид харьяалаагүй тохиолдолд Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай САНАЛ \35X-28\ Зөрчлийн хэргийг удирдах албан тушаалтанд танилцуулна.

Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай саналыг хүлээн авсан Зөрчлийн хэргийг удирдах албан тушаалтан нь уг саналыг хянаж үзээд Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай ТОГТООЛ \ЗХБ-68\ -ыг үйлдэнэ. Харин Эрх бүхий албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй бол Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай САНАЛ \35X-29\ -ыг үйлдэж прокурорт хүргүүлнэ.

Цагдаагийн болон хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага нь хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг тусгай дугаарын утаснаас гадна төрөл бүрийн эх үүсвэрээс шууд хүлээн авч болно. Эдгээрт хохирогч, хувь хүмүүс болон бүх шатны боловсролын байгууллагын багш, сургуулийн нийгмийн ажилтан, бусад ажилтан, эрүүл мэндийн, нийгмийн, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан, сум, дүүрэг, баг, хорооны холбогдох албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээдүүд хамаарна. Энэ тохиолдол бүрд эрх бүхий албан тушаалтан хүлээн авсан бүх гомдол, мэдээллийг хуульд заасан хугацаанд шалгана.

Хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх дуудлага, гомдол, мэдээлэл ирэхэд дуудлага, мэдээллийн дагуу нэн тэргүүнд дуудлага, мэдээлэлд газар дээр нь хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан, улсын байцаагч, эргүүлийн офицер, хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа гэх мэт эрх бүхий албан тушаалтнууд очиж ажиллаж байгаа

бөгөөд хуульд заасан тодорхой ажиллагааг хийж бүртгэлд авснаар прокурорын байгууллагын нэгдсэн бүртгэлд орж прокурорын хяналтад орно.

Хүүхдийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулахдаа дараах асуудлуудыг анхаарвал зохино. Үүнд:

- тухайн гомдол, мэдээлэл ямар байдлаар ирсэн, гомдол гаргагч нь биеэр болон холбоо мэдээллийн хэрэгслээр гаргасан эсэх.
- зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргагчид “Гэмт хэрэг, зөрчлийн талаар амаар болон холбоо, мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авсан тухай тэмдэглэл” үйлдэж танилцуулах.
- зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн гомдол гаргагч, хохирогч нь “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд эсэхийг шалгаж тогтоох.
- зөрчлийн талаарх гомдол мэдээлэлд хамаарах хүүхэд түүний хууль ёсны төлөөлөгч нарт хамгаалуулах эрхтэй болохыг нь танилцуулж, хамгаалах байранд хандах, хамгаалуулах эсэхийг нь лавлаж, тодруулж, хамгаалуулах эрхээр нь хангах;
- Тухайн орчны нөхцөл байдал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн байдал зэргийг нь шалгах, тогтоох, үзлэг хийх,
- Хүүхдийн эрхийг зөрчихөд ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйлийг эд мөрийн баримтаар хураан авах, бэхжүүлэх хойшлуулшгүй ажиллагааг хийх.
- Үзлэгээр зөрчлийн улмаас үүссэн ул мөрийг (цус, үс, шүлс, биологийн болон бусад) бэхжүүлэн авч, шинжилгээнд хүргүүлэх,
- Монгол хэл, бичиг мэдэхгүй, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчийг орчуулагч, хэлмэрч байлцуулж, эрхийг нь хангах.
- Дүрс бичлэг, дуу хураагуураар болж байгаа явдлыг давхар баримтжуулах.
- хүүхдийн эрсдэлийг үнэлж, хамтарсан багаар хэлэлцүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх асуудлыг шуурхай шийдвэрлэх,
- Хүүхдийг хамгаалах арга хэмжээг авах,
- Насанд хүрээгүй, бага насны хүүхэд, өндөр настанд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох;
- Хүүхдийн эрхийг зөрчих үйлдлүүдийн шинжийг нарийн тогтоох,

## НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад хүүхдийн эрхийн зөрчил 2020 онд 3215 бүртгэгдсэн. Энэ нь 2019 онтой харьцуулахад 1804 зөрчлөөр буюу 2.2 дахин их, 2021 оны нэгдүгээр улиралд 1162 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 540 буюу 82 хувиар өссөн нь хүүхдийн эрхийг зөрчих зөрчил жил бүр нэмэгдэж байгааг харуулж байна. Үүнээс 2767 буюу 86.1 хувь нь нийслэлд, 448 буюу 13.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Мэдээлэл авагдсан 3210 хохирогч хүүхдийн 1448 буюу 45.1 хувь нь 0-6, 1453 буюу 45.2 хувь нь 11-14, 309 буюу 9.6

хувь нь 15-18 насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд 90 орчим хувь нь бага насны хүүхдийн эрх зөрчигдсөн байна.

Судалгаанаас үзвэл зөрчигдсөн эрхийг илрүүлэх ажиллагаа хангалтгүй, хоёрдугаарт хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээдэггүй, гуравдугаарт Монгол Улсад хүүхдийн эрхийг зөрчих зөрчлийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй байна гэж дүгнэж хэлэхээр байна. Мөн жилдээ яг хэдэн хүүхдийн эрх зөрчигдөж байгаа бодит тоон мэдээлэл байхгүй болох нь тогтоогдсон. Учир нь хүүхдийн эрх зөрчсөн зөрчлийн материалд хэдэн настай, хэдэн хүүхдийн эрх зөрчигдөж байгааг эрх бүхий албан тушаалтнууд огт тусгадаггүй, тухайлбал “хүүхдийн дэргэд архидаан согтуурсан” гэсэн ерөнхий мэдээлэл бичдэг. Мөн тухайн зөрчлийн улмаас хүүхдэд ямар хор, хохирол учирсан, тухайн хүүхэд айж цочсоны улмаас сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авах шаардлагатай эсэхийг огт шалгадаггүй байна.

Зөрчлийн тухай хуульд Хүүхдийн эрхийг зөрчих 15 зөрчлийг хуульчилсан байдаг. Судалгаанаас харахад Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан “Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидаан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн” зөрчил нийт зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 2020 онд бүртгэгдсэн 3215 зөрчлийн 80.7 хувь нь, 2021 оны нэгдүгээр улиралд бүртгэгдсэн 1162 зөрчлийн 96.7 хувийг дээрх төрлийн зөрчлийн хэрэг эзэлж байна. Мөн шүүхийн шийтгэвэрт хийсэн дүн шинжилгээгээр 1207 тохиолдлын 14.3 хувь нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан “Шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг 3 сараас дээш хугацаанд төлөөгүй” зөрчил эзэлж, 1034 буюу 85.6 хувь нь “Хүүхдийн дэргэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн” зөрчил эзэлж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн дам хохирогч нь хүүхэд болж байгааг харуулж байна.

Анхаарах зүйл: ГБХ-ийн хохирогч нь эмэгтэйчүүд, өндөр настай ахмадууд, хүүхдүүд байх нь нийтлэг бөгөөд ялангуяа ГБХ-ийн хохирогчоор насанд хүрээгүй хүүхдүүд, тэр тундаа бага насны хүүхдүүд ихээр өртдөг.

Хүчирхийлэл нь бага насны хүүхдийн сэтгэц, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, өндөр эрсдэл, хор уршгийг дагуулдаг болохыг анхаарах ба цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй. Жишээлбэл: ГБХ – ийн шинжтэй үйлдлийг шалгах явцад хажууд нь байгаа хүүхэд хүчирхийлэлд өртөж, хохирогч болдог. Энэ тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл нь цагдаагийн харьяалан шалгах зөрчил болдог ба орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүүхдийн асуудлыг тусад нь салгаж зөрчлийн хэрэг гэж үзэж, улсын байцаагчаар шалгуулахаар шилжүүлдэг. Энэ нь буруу жишиг бөгөөд нэг үйлдлээр хоёр зөрчил үйлдэгдсэн гэж үзэж аль хүнд шийтгэлтэй зөрчлийг шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь нэгтгэж шалгадаг гэдгийг анхаарвал зохино.

Цагдаагийн алба хаагч, хүүхдийн эрхийн улсын байцаагч нь үүнд анхаарч, тухайн ГБХ-

ийн орчинд хүүхэд байсан эсэх, хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн байдал бий болсон эсэхийг сайтар хянаж, хүүхдийн зөрчигдөж байгаа эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ажиллагааг хийх хэрэгтэй.

Хэдийгээр эцэг эх нь үр хүүхдээ зодож хашраахыг хүмүүжүүлэх арга гэж үздэг уламжлал үзэл, үүнийг хэвийн үзэгдэл мэтээр ойлгож ирсэн зэрэг байдал байх хэдий ч насанд хүрээгүй буюу ялангуяа бага насны хүүхэд нь төрсөн эцэг, эх, ах, эгч, өвөө, эмээгээсээ илт хүч дутуу тэдэнтэй ямар нэгэн эрх тэгш байдлаар хандах боломжгүй, хувийн таарамжгүй харьцаа үүсгэх боломжгүй бөгөөд хэрвээ хүүхдэд бие махбодод нь хүч хэрэглэн халдаж зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан зөрчлийг гаргасан тохиолдлыг онцгой тохиолдолд авч үзэн хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг шуурхай авах нь зүйтэй. /Үүнд: хүүхдийн асран хамгааллын асуудлыг хөндөх, сэтгэл зүйд учирсан хүнд дарамт бий болж байгаа эсэхийг тогтоолгох, мэргэжлийн эмч, сэтгэл зүйчид хандах зэрэг/

Хэрэв хүүхэд өөрийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын зэрэг дунд болон өндөр, эсхүл дор дурдсан нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзахгүйгээр хамгаалах боломжтой иргэн, гэр бүлд хүлээлгэн өгөх, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх зэрэг хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

ГБХ-д өртсөн хүүхдэд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар баталсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримтална.



### 2.3. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

| Хичээлийн нэр                       | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангах                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн гол зорилго               | Хүүхдийн эсрэг гэмт хэргийн онцлог, мөрдөн шалгах ажиллагаа, тактик, насанд хүрээгүй хохирогч, гэмт хэрэг үйлдэгчийн онцлог болон нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны ур чадвараа хөгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаар гомдол мэдээллийг хүлээн авах ажиллагаа;</li> <li>• Хүүхэд оролцсон болон хүүхдийн эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа;</li> <li>• Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн онцлог;</li> <li>• Насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авах;</li> <li>• Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчийн онцлог, мэдүүлэг авах;</li> <li>• Хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн онцлог;</li> <li>• Хүүхэд үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог;</li> <li>• Мэдүүлэг авах нарийвчилсан процесс:</li> <li>• ярилцлагыг эхлүүлэх аргачлал,</li> <li>• Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийг хамгаалах, эрхийг хангах боломж</li> </ul> |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | <p>5 мин Оюуны довтолгоо хийх</p> <p>15 мин Танилцуулга (лекц): Хүүхдийн эсрэг хэрэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шийдвэрлэх ажиллагаа дах хүүхэд хамгаалал;PP (Powerpoint) ашиглан тайлбарлана</p> <p>20 мин Нийтээр ажиллах дасгал: Хүүхдийн эсрэг гэмт хэргийг зүйлчлэх, хянан шийдвэрлэхдээ хуулийн зүйл, хэсгийг практикт хэрэглэх</p> <p>20 мин Бүлгийн ажил: Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүүхдийн талаар заасан зүйл хэсгүүдийн агуулга заалтуудыг зөв хэрэгжүүлэх, тодорхой үйл ажиллагааг үр дүнтэй явуулах (кейс ашиглана).</p> <p>5 мин Хяналтын асуулт хариулт</p>                                                                                                                  |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | <ul style="list-style-type: none"> <li>• Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам</li> <li>• Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны журам, зааврын эмхэтгэл</li> <li>• Мөрдөн шалгах ажиллагааны талаар гарын авлага</li> <li>• “Гэрч хохирогчийг хамгаалах ажиллагаа” гарын авлага</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |

#### ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА: (ОЮУНЫ ДОВТОЛГОО ХИЙХЭД АШИГЛАХ МЭДЭЭЛЭЛ)

Цагдаагийн алба хаагчийн зүгээс хохирогч, гэрч хүүхдээс хохирол, нотолгоо шаардах, гомдол, нэхэмжлэлээ буцаах, хэрэгсэхгүй болгох, эвлэрүүлэх оролдлого хийх, зэргээр Эрүүгийн хэргийг хянан шалгах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын сэтгэлгээ хандлага сул байдгаас хүүхдийн эрх ашиг зөрчигддөг. Хүүхдийн хувийн мэдээллийн

нууцлалыг хамгаалах эрхийг зөрчих, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч хүүхдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр цацах зэрэг зөрчлүүд нийтлэг гардаг тул энэ чиглэлээр алба хаагчийн мэдлэг, хандлагыг өөрчлөх шаардлагатай.

- Ерөнхий сэдвийн хүрээнд мэдээлэл өгнө.
- Мөрдөн шалгах ажиллагааны тактик, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны талаар болон мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулахад хүүхдийн эсрэг гэмт хэргийн мөн чанар, насанд хүрээгүй хохирогчийн онцлогийн талаарх үндсэн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр харилцан ярилцана.
- Шийдвэрлэгдсэн тохиолдол дээр оролцогчид ажиллаж, мөрдөн шалгах ажиллагааг явуулна. Гаргасан алдаа дутагдлыг ярилцана.
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад насанд хүрээгүй хохирогчийн аюулгүй байдлыг хангахад анхаарна, үүний тулд дараах арга хэмжээг авах боломжтой:
  - Өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгчтэй холбож өгөх (танд итгэж болох юм байна гэдгээ мэдсэний дараа хохирогч тантай болсон явдлын талаар дуртайяа ярилцана);
  - Насанд хүрээгүй хохирогчид туслалцаа үзүүлж чадах бусад оролцогчийг тодорхойлох;
  - Хууль ёсны төлөөлөгчийг тогтооход эцэг эх, гэр бүлийн бусад хамаарал бүхий этгээд эсрэг ашиг сонирхолтой, тухайн хүүхдэд сөргөөр нөлөөлж болох бол авах арга хэмжээнүүд;
  - Насанд хүрээгүй хохирогчид томилж болох шинжилгээний төрөл, сэтгэл зүйн хохирол хор уршгийг тогтоож үнэлэх алхам, арга зүй;
  - Зарим нэг мэдээллийг хэрэглэж болох эсэх талаар хохирогчоос зөвшөөрөл авах, гэмтэл авсан газрыг нь харах, ярилцах. Хэдийгээр ажлын тань нэг хэсэг боловч хүүхэд гэдэг утгаараа энэ зэргийн энгийн зүйл асууж, санаа тавих нь танд итгэх итгэл, хүндэтгэлийг төрүүлнэ;
- Мөрдөн шалгах ажиллагааны талаар бодит шийдвэрлэгдсэн хэрэг дээр хэлэлцүүлэг хийнэ.

#### Хяналтын асуулт:


1. Хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэмт хэргийн онцлог нь юу вэ?
2. Хүүхэд хохирсон гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог юу вэ?
3. Насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны үйл явц, тактик ямар онцлогтой вэ?
4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнээс мэдүүлэг авах ажиллагааны тактикийн онцлог юу вэ?
5. Нотлох баримтын төрлийг нэрлэнэ үү.
6. Нотлох баримтыг цуглуулах болон бэхжүүлэхэд юу анхаарах вэ?

7. Энэ төрлийн хэрэг дээр мөрдөн шалгах ажиллагаанд ямар онцлогийг харгалзан үздэг вэ?

### СУРГАЛТАД АШИГЛАХ МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ

Хүүхдийн хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хамгаалах, зөрчил гаргагч, гэмт хэрэг үйлдэгчид эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхэд хууль хяналтын байгууллага үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлдэг бөгөөд энэ нь хуулиар заагдсан хүрээнд хэрэгждэг онцлогтой. Хүүхдийн эрхийг хамгаалах явцад дор дурдсан тохиолдлуудад хүүхдийн нийтлэг эрхийг хамгаалахаар хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах шаардлага үүсдэг.

1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, эрх ашгийг нь хохироосон буюу хүүхэд гэмт хэргийн хохирогч болсон,
2. Хүүхэд үзэж харсан хэргийн гэрч болсон,
3. Хүүхэд өөрөө хууль зөрчиж, гэмт хэрэг үйлдсэн



### **ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ:**

**Насанд хүрээгүй хохирогч гэж хэн бэ?** Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн 18 насанд хүрээгүй этгээдийг насанд хүрээгүй хохирогч буюу хохирогч хүүхэд гэнэ.

Гэмт хэргийн хохирогч нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдоос илүү нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтнээрээ хохирсон байдаг бөгөөд өөрийгөө тухайн гэмт хэрэгт буруутай мэтээр төсөөлөх, улмаар амиа хорлох, биедээ гэмтэл учруулахыг оролдох, бусдыг үзэн ядаж байдаг. Иймээс тэдэнд онцгой анхаарлыг хандуулж, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх, нийгэмшүүлэх, хамгаалах шаардлагатай.

Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэхүйн хөгжилд сөргөөр нөлөөлөх хүнд хөдөлмөр удаан хугацаагаар эрхлүүлсний улмаас насанд хүрээгүй этгээд бие эрхтний хувьд үлэмж их хохирол хүлээсэн байдаг. Насанд хүрээгүй этгээд гэмт хэргийн улмаас бие эрхтэндээ гэмтэл авах, улмаар хөгжлийн бэрхшээлтэй болох, сэтгэцийн эмгэгтэй болох, амь насaa алдах зэргээр бие махбодын хохирол хүлээдэг.

Хүүхдэд гэмт хэргийн улмаас бие махбодын хохирлоос гадна, ёс суртахууны, эд хөрөнгийн, санаа сэтгэлийн хохирол учирдаг. Ёс суртахууны хохирол нь тухайн хүүхдийн нэр төрийг нь гутаан доромжлох, сургууль, гэр бүлийн орчинд нэр хүндийг нь унагах, сэтгэлийг нь хямрааж шаналгах хэлбэрээр илэрнэ.

Хүүхдийг хохирогчоор тогтоохдоо мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана. Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол дээрх эрхийг түүний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүн эдэлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог.

**Насанд хүрээгүй гэрч, хохирогчоос мэдүүлэг авах:** Насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авахын өмнө сурган хүмүүжүүлэгч байцаалтын бэлтгэлийг сайтар хангах шаардлагатай. Бэлтгэл ажиллагаагаар олж авсан баримтыг харгалзан мөрдөгч байцаах тактик арга зүйг боловсруулж, эд мөрийн баримт, бичиг баримт, бусад оролцогчдын мэдүүлгийг үзүүлэх гэрч, хохирогчид хэрхэн үзүүлэх тактик, дарааллыг тогтооно. Мөрдөгчид мэдүүлэг авахад тэр бүр нарийн бэлтгэх бололцоо байдаггүй. Цагийн хүрэлцээ, хохирогчийн хувийн байдлын тухай мэдээлэл хангалтгүй байх, мэдүүлэг авах таагүй нөхцөл байдал болон бусад объектив зүйлийн нөлөөлөл мөрдөгчид тохиолддог. Үүнийг даван гарахад сурган хүмүүжүүлэгчээр тухайн ажиллагаанд оролцож байгаа багш туслалцаа үзүүлж болно.

**Мэдүүлэгт оролцогчдыг тодорхойлох:** Гадны хэн нэгэн хүнгүй орчинд байцаалтыг явуулах нь насанд хүрээгүй гэрч, хохирогчтой сэтгэл зүйн холбоо тогтоох нэг чухал нөхцөл юм. Гэвч хуульд мэдүүлэгт гуравдагч этгээдийг оролцуулах тухай зохицуулалт бий. Мэдүүлэг авахад гуравдагч этгээд оролцох эсэхийг харгалзан түүнд зохицсон байцаалтын хэлбэрийг сонгоно. Зарим тохиолдолд тухайн хүүхэдтэй таагүй харилцаатай

хүнийг сурган хүмүүжүүлэгчээр оролцуулах, өөрөөс нь саналыг нь авахгүй байх гэх мэт нийтлэг алдаа гардаг ба энэ тохиолдолд хүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзах эсхүл дутуу мэдүүлэх зэрэг хүндрэл учирдаг.

Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг мэдүүлэг авахаар дуудах, байцаах онцлог: 18 насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл сургууль, асрамжийн газрын удирдлагаар нь дамжуулан дуудна. Мөрдөгч нь насанд хүрээгүй этгээдийн хууль ёсны төлөөлөгч мөн эсхийг тогтоож дуудсан шалтгаанаа мэдэгдэнэ. Мөн насанд хүрээгүй гэрч, хохирогч нь мэдүүлэг өгөхөөс зайлсхийх, татгалзах, мөн худал мэдүүлэг өгөх тохиолдолд түүнд хууль зүйн хариуцлага хүлээлгэхгүй тухай байцаалтад дуудахдаа түүний хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэж болно.

Юун түрүүнд насанд хүрээгүй хүний сэтгэл зүйн онцлогийг мэдэх шаардлагатай юм. Үүнд:

**Насанд хүрээгүй хохирогчийн сэтгэл зүйн онцлог:** Гэмт хэргийн үр дүнд сэтгэл санааны хямралд өртөх нь хохирогчдын хувьд түгээмэл тохиолддог асуудал юм. Хохирогчдын дөрөвний гурвыг хамарсан хамгийн нийтлэг бэрхшээл бол сэтгэлзүйн тулгамдсан асуудлууд бөгөөд эдгээр нь айдас, өөрийгөө буруутгах, уур уцаар, ичгүүр, нойргүйдэх гэх мэт шинж тэмдгээр илэрдэг. Эдгээр бэрхшээлүүд нь ихэвчлэн гэмтлийн дараах архаг стрессийн эмгэг (PTSD) -ийг үүсгэдэг. Хохирогч дараах сэтгэлзүйн хариу үйлдлийг мэдэрч болзошгүй юм.

- Эмзэг байдлыг мэдрэх байдал нэмэгдэх,
- Ертөнцийн тухай ойлголт нь утгагүй, ойлгомжгүй болох,
- Өөрийгөө сөрөг талаас нь харах,

Бага наснаасаа албадлагын бэлгийн харьцаанд орсон туршлага нь эмэгтэй хүний бэлгийн харьцааг өөрийн хяналтад байдаг зүйл гэж үзэх чадварыг бууруулдаг.

Хүчиндсэний дараах хариу үйлдлийн талаар хийсэн судалгаагаар хүүхдүүдийн 96 хувь нь халдлагад өртсөнөөсөө хэдэн цагийн дараа айж, сандарч, чичирч байсан гэж хариулжээ. Илүү их хугацаа өнгөрсний дараа өмнөх шинж тэмдгүүд буурч, сэтгэлийн хямрал, ядаргаа, тайван бус байдлын түвшин нэмэгдсэн. Сэтгэл судлаач Дин Г.Килпатрикийн хэлснээр хүчингийн гэмт хохирогчид сэтгэлийн түгшүүр, фобитой холбоотой түгшүүр ихтэй байдаг. Шинж тэмдэг нь:

- Аймшгийн мэдрэмж,
- Сандрах,
- Сэтгэл санаа тавгүйрхэх,
- Сандарч дайрах,
- Зарим өдөөлтөд оновчгүй хариу үйлдэл үзүүлэх,
- Зугтахгаас зайлсхийх ба / эсвэл хариу арга хэмжээ авах .

- Гиперсексуал байдал (Хэрэг үйлдэгдсэний дараа маш их бэлгийн харьцаанд орохыг хүсдэг.)

Мөн дараах сэтгэцийн өөрчлөлт, эмгэгтэй болдог. Үүнд:

**Гэмтлийн дараах стресст эмгэг:** Хүчингийн гэмт хэрэг үйлдэгдсэний дараа хохирогч гэмтлийн дараах стресс эмгэгтэй болдог. Хүчиндүүлсэн эмэгтэйчүүдийн 31 хувь нь халдлагад өртсөнийхөө дараа амьдралынхаа тодорхой хугацаанд ПСДС өвчин туссан туссан байна.

**Сэтгэлийн хямрал:** Судалгааны үр дүнд хүчиндүүлсэн хохирогч хүчирхийлэлд өртөөгүй хүнээс илүү сэтгэл гутралд ордог болохыг тогтоожээ. Судалгааны үр дүнд Beck Depression Inventory тестийг ашиглан сэтгэл гутралын түвшнийг хэмжиж, судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дөчин таван хувь нь дунд болон хүнд хэлбэрийн сэтгэл гутралд орсон гэж дүгнэжээ.

Хохирогч хүүхэдтэй ажиллахад цочролд орсон хүүхдүүдийн сэтгэлзүйн цочролыг мэддэг, таних чадвартай байхаас гадна тэдэнд хариу үйлдэл өгөхөд бэлэн байх ёстой. Энэ ур чадварт зөвхөн мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэл засалч суралцсан байдаг онцлогтой. Тиймээс хохирогч хүүхдүүдэд заавал төрөөс санхүүждэг, нотолгоонд суурилсан сэтгэл заслын эмчилгээ хийх шаардлагатай байдаг.

**Өөрийгөө буруутгах:** Өөрийгөө буруутгах гэдэг нь богино болон урт хугацааны туршид хохирогчийн өөрт тулгамдсан бэрхшээлийг даван туулах хувь хүний чадварыг дарангуйлж, танин мэдэхүйн бүтцийн өөрчлөлтийг бий болгодог. Буруутгал нь өөрийн зан үйл болон зан чанарыг буруутгах байдлаар явагддаг. Зан үйлийн буруутгалын хувьд би ийм зүйл хийх ёсгүй байсан, хэрэв хийгээгүй байсан бол хохирохгүй байх байсан гэх байдлаар илэрдэг. Өөрийгөө буруутгадаг зан авирыг даван туулж байгаа хүмүүс өөрсдөд нь ямар нэгэн буруу зүйл байгаа нь тэднийг халдлагад өртөхөд хүргэсэн гэж үздэг.

**Ичих:** Хохирогч өдөр тутмын хэвийн амьдралдаа ичимхий, ууртай байвал гэмт хэрэгтэнтэй эргэж уулзах, өшөө авах сэдэл төрсөн байдаг. Ичимхий байдал нь сэтгэлзүйн асуудлуудтай холбоотой байдаг бөгөөд тухайлбал, хоол идэх эмгэг, мансууруулах бодис хэрэглэх эмгэг, сэтгэлийн хямрал болон бусад сэтгэцийн эмгэгүүдийн зан байдлын гадаад шинж юм. Хэдэн жилийн турш явуулсан судалгаагаар ичимхий хүүхдүүд нь мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх, эрт бэлгийн харьцаанд орох, бэлгийн аюулгүй байдал багатай, эрүүгийн гэмт хэрэг үйлдэх өндөр магадлалтай болох нь тогтоогдсон байна.

Ичимхий байдлыг танин мэдэхүйн дахин боловсруулалт хийх замаар ичгүүр, гэм буруугийн нөлөөнд автдаггүй логик дүгнэлтийг хохирогчийн сэтгэхүйд бий болгосноор арилгадаг. Хүчингийн гэмт хэргийн хохирогчдын ихэнх нь тэдэнд тохиолдсон зүйл нь “тэдний буруу биш” гэдэгт хангалттай итгэлтэй байж чадахгүй байдагт оршдог.

Ичгүүрийг арилгаснаар тэдэнд аюулгүй байдлыг мэдрэх, эрүүл аргаар сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд нь тусалдаг. Ихэнх тохиолдолд ойр дотны хүмүүсийнх нь дэмжлэгтэй удаан хугацааны эмчилгээ хийх шаардлагатай байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирогчийн сэтгэл зүйн зорилго, зорилтуудыг тодруулах шаардлагатай байдаг. Үүнд:

- Сэтгэц-физиологийн, танин мэдэхүйн үйл явцууд, ой санамж, сэтгэлгээний түвшин ба өвөрмөц онцлогуудын оношилгоо, үнэлгээ;
- Ой санамжийг идэвхжүүлэх, сэтгэн бодох чадварыг дэмжих, мэдрэмжийн хэлхээ холбоог сэргээх сэтгэлзүйн аргуудыг сонгож хэрэглэх;
- Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө, үйлдэгдэх үеийн болон үйлдэгдсэний дараах хохирогчийн зан төлөвийн дүн сэтгэлзүйн шинжилгээ;
- Хохирогчийн хувийн онцлогуудад хийх сэтгэлзүйн дүн шинжилгээ: нийгмийн чиг хандлага, итгэл үнэмшил г.м;
- Хохирогч болон гэрчийн гэмт үйл явдал, түүнийг үйлдсэн этгээдүүд, үүссэн үр дагавруудад хандаж байгаа байдлыг оношлох;
- Байцаалтын харилцан ярианы шатанд хохирогч болон гэрчийн ярианы бус хариу үйлдлүүдийг шуурхай үнэлж дүгнэх;
- Дээр дурдсан хүчин зүйлсийг үндэслэн байцаалтын тактикийг шуурхай өөрчлөх;
- Баримтыг санаатайгаар мушгин гуйвуулах явдлыг таньж, арилгах сэтгэлзүйн тусгай аргуудыг хэрэглэх.

**Насанд хүрээгүй хохирогчийн дараах эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хангах нь:** Хууль зүйн хороо нь зөрчил, эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагааны үед болон дараагийн шатанд хохирогч, гэрч, хууль зөрчсөн хүүхдийн эрх ашгийг ханган хамгаална.<sup>5</sup> Хууль зүйн хороо нь хохирогч хүүхдээс байцаалт мэдүүлэг авах, хохирогч хүүхдийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүх байгууллагатай хамтран ажиллана.<sup>6</sup>

5 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.1.

6 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.6.



| №  | Насанд хүрээгүй хохирогчийн эрх                                                          | Эрхийг хангах талаарх Хууль зүйн хорооны чиг үүрэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|----|------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх                            | - “Өсвөр насны хүнийг байцаах, шүүн таслах ажиллагаанд урьдчилан бэлтгэх, хэргийн оролцогчдын бүрэн оролцох боломжийг бүрдүүлэх, хүүхдийг байцаалтад дуудахдаа тэдгээрийн эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг заавал оролцуулах ба өсвөр насны хүн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг тайлбарлаж өгөх” нийтлэг чиг үүрэгтэй. <sup>7</sup><br>-“Хохирогч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа хохирогч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг нэн даруй зохион байгуулах” туслалцаа үзүүлнэ. <sup>8</sup><br>-Өмгөөлөгч авах хүсэлтэй, төлбөрийн чадваргүй хохирогч хүүхдийн эрхийг хангах асуудлаар хорооны хуралд санал оруулж, шийдвэр гаргуулах. <sup>9</sup>                             |
| 2. | Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах | Зөрчил, гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан хохирол, гэм хорыг хууль зүйн дагуу барагдуулах, чухал шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг урьдчилан гаргуулах ажлыг зохион байгуулах. <sup>10</sup> Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг.                                                                                                                                                                                                                    |
| 3. | - Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх    | Сум, хорооны нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хохирогч хүүхэд, түүний эцэг, эх, хамтарсан баг, бусад оролцогчтой хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах нийгэм, сэтгэл зүйн эрүүл мэндийн, хууль эрх зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөө туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах. Энэ үйлчилгээний дэс дараалалд хүүхэдтэй холбоотой хэргийн газарт очиход хамгийн түрүүнд сэтгэл зүйчийг уулзуулан зөвлөгөө авхуулахдаа энэ эрхийг нь тайлбарлан ойлгуулах нь хүүхдийн дээд эрх ашигт нийцнэ.<br>Энэ эрх хамгийн эхэнд хэрэгжих эрх бөгөөд үүнийг байцаалт авахаасаа өмнө хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, сэтгэл зүйч энэ эрхийн учир холбогдлыг тайлбарлан таниулж, мөрдөгч мөн байцаалт эхлэхийн өмнө хүүхдэд сануулж ойлгуулна. |

7 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.5.5.

8 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.7.

9 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.7

10 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.4.

|    |                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 4. | <p>- Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно.</p> | <p>-Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хохирогч хүүхдэд авах шаардлагатай тохиолдолд хуулийн 19.1-т заасан хамгаалалтыг хэрэглэх тухай хохирогч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлт, эсвэл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн саналыг бичгээр гаргуулах ажлыг зохион байгуулна.<sup>11</sup></p> <p>-Нийгмийн халамжийн тухай хуульд: (191.1.2)</p> <p>Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг олгодог. Уг хуулийн энэ заалтыг өнөөгийн нөхцөл байдалд тохируулан хүүхдийн эрхийг хамгаалж буй төрийн бус байгууллага мөн адил авах эрхтэй байхаар өөрчлөн найруулах нь үр дүнтэй байж болох юм. Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэхээс бусад тохиолдолд энэ төрлийн байгууллага нь сайн дурын санхүүжилтээр, ашгийн төлөө бус байдлаар үйл ажиллагаа явуулдаг учир эдийн засгийн хувьд тэр бүр сайнгүй байх нь бий. Тийм учраас санхүүгийн хувьд бүрэн биш ч тодорхой хэмжээгээр дэмжлэг юм. Нөгөө талаас бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг аль нэг гэр бүлд шууд өгөх боломж бага билээ. Өөрөөр хэлбэл хохирогч хүүхдийг аль нэг гэр бүлд шилжүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, үрчлүүлэх асуудал нь эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гаргах зэрэг тодорхой ажиллагаа хийгдсэний үндсэн дээр шийдвэрлэгддэг асуудал тул зарим нэг хүндрэл бэрхшээлийг үүсгэдэг. Уг хуульд заасан нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар тогтоодог бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмыг 2008 оны 162 дугаар тогтоолоор /2 дугаар хавсралт/ баталсан байна. Ингэхдээ хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ асарч байгаа гэр бүлийн тэтгэмж авах эрх нь “Асран хүмүүжүүлэх гэрээ”-г үндэслэн бий болдог ба иргэний гаргасан хүсэлтийг “Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл” шийдвэрлэдэг байна.</p> |
| 5. | <p>- Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх;</p>                                                                                                                                                                                                                                                   | <p>Хүчирхийллийн улмаас үүдэлтэй гэр бүлийн хүчирхийлэл, хүчиндэх гэх мэт хэрэгт хүүхэд сэтгэл санааны хохирол амсдаг ба энэ тохиолдолд шүүх сэтгэц гэм судлаачид хандаж сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тогтоолгохоор шинжээч томилж эрүүл мэндийн хохирлыг үнэлж болно.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 6. | <p>- Шүүх хуралдааны танхимд хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;</p>                                                                                                                                                                                                                                              | <p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч сурган хүмүүжүүлэгч нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтантай холбоо тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдэд хүндрэл бэрхшээлгүй шуурхай явуулах ажлыг зохион байгуулна.<sup>12</sup></p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |

11 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.8.

12 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.5.

|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7. | - Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.                                                                                                    | Мөрдөгч прокурор хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг сонгоход хүүхдийн эсэг ашиг сонирхолтой эсхүл хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн эсхүл гэмт хэрэг үйлдсэн хүмүүстэй шууд болон шууд бус байдлаар хамааралтай тэдгээрийн нөлөөнд байдаг хүнийг оролцуулж болохгүй. Хууль ёсны төлөөлөгч тогтооход хүүхдийн санал болон хүүхдийн байгууллагын үнэлгээ, шийдвэрийг аль болох харгалзаж шийдвэр гаргах нь хэргийн шийдвэрлэлтэд шууд нөлөө үзүүлдэг.     |
| 8. | - Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.                                                                                                                                  | Энэ эрхийг өмгөөлөгч, сэтгэл зүйч, хууль ёсны төлөөлөгч хохирогч хүүхдэд тайлбарлан ойлгуулна. Ихэнх тохиолдолд хэргийн оролцогчийн өмгөөлөгч эсхүл усад этгээд энэ талаар нийтийн сүлжээ, зурагтаар ярих, мэдээлэх зэрэг байдлууд гаргаж хохирогчийг дам сэтгэл зүйн хохирол учруулдаг тул сануулах, анхааруулах нь зүйтэй. Мөн прокурор нь хэргийн талаар мэдээлэл өгөх зөвшөөрлийг олгодог ба шаардлагатай бол баталгаа гаргуулж, зөвлөгөө өгч болно. |
| 9. | Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ. Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно. |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |

### ГЭРЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ НЬ:

**Гэрч хүүхэд гэж:** Гэрчийн насны хязгаарыг хуульчлан тогтоогоогүй. Тиймээс болж өнгөрсөн гэмт үйл явдлыг ойлгож, мэдүүлэх чадвар бүхий 18 хүртэлх насны хүүхдийг гэрчээр асууж болно. Копенхагены Их сургуулийн сэтгэл судлалын профессор Г.Дэвис “5 настай хүүхэд ч болж өнгөрсөн үйл явдлыг үнэн зөвөөр илэрхийлэх чадвартай, түүнийгээ бүтэн жил ч мартдаггүй хадгалдаг” хэмээн судалгааны үр дүндээ үндэслэн мэдэгдсэн. Харин байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид бага насны хүүхдүүдийн болж өнгөрсөн үйл явдлыг хэт дөвийлгөн, худал ярьдаг сэтгэхүйн болон насны онцлогийг нь гэрчээр байцаахдаа харгалзан үзэх нь зүйтэй.

Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт мэдээлэл нь гэрчийн мэдүүлэг болон бусад баримтаар тогтоогдох тул нотлох баримтын нэгэн гол эх сурвалж

нь гэрч юм. Гэрч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй.

Өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон этгээд, тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн шүүгч, өмгөөлөх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгчийг тус тус гэрчээр байцааж болохгүй.

Гэрчийн мэдүүлэг нь хэргийг нотлоход хамааралтай бүхий л байдал, түүний дотор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн хувийн байдал, түүнчлэн тэдэнтэй ямар харилцаатай болохыг тогтооход чухал ач холбогдолтой байдаг.

**Тохиолдол 1.** Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хамтран амьдагчаа алсан гэмт хэргийн цорын ганц гэрч 7 настай хүүхдийн мэдүүлгийг нотлох баримтаар үнэлэхгүй, мэдүүлгийг зааж өгсөн гэх мэтээр яллагдагч талаас маргасан. Энэ тохиолдолд тухайн хүүхэд үзэж харсан үйл явдлын талаар ойлгох, тайлбарлах чадвартай эсэхийг тогтоолгохоор шинжээч томилж шинжээчийн дүгнэлтийг үнэлж гэрч хүүхдийн мэдүүлгийг шүүх нотлох баримтаар мэдүүлгийг үнэлсэн байдаг.

Гэрчээр хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, яллагдагч, иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн төлөөлөгчийг асууж болохыг хуулиар зөвшөөрсөн байдаг. ЭХХШ ажиллагааг эрхлэн явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гэрчээр дуудагдсан мөчөөс насанд хүрээгүй этгээд эрх зүйн харилцааны субъект болж гэрч хэмээн нэрлэгдэх болно.

**Гэрч хүүхдийн сэтгэл зүйн онцлог:** Хүүхдүүдийн болсон үйл явдлыг кодлох, хадгалах, олж авах, тайлагнахад нийгмийн болон сэтгэлзүйн олон хүчин зүйл нөлөөлдөг.

6-8 насны хүүхдүүд худал мэдүүлэг өгөх хувь нь 3-5 настай хүүхдүүдийнхээс хоёр дахин их байдаг бөгөөд энэ нь хүүхдийн эцэг эх, бусад хүмүүсийн ятгалга, дарамт, шахалтаас болдог байна. Хүүхдүүд насанд хүрэгчдээс илүү төвөгтэй, эргэлзээтэй асуултад илүү их хариулдаг. Бага насны хүүхдүүдийг эцэг эхэд нь таалагдуулах гэж худал хэлэхийг тулгавал харин 6-аас дээш насны хүүхдүүд заналхийлэлд автвал худлаа ярьж болно.

Хүүхдүүдийн мэдүүлэг хэдийгээр чухал боловч гэрчээр мэдүүлэг өгсний дараа хүүхдэд анхаарал хандуулдаггүй. Хүүхдүүд гэрчийн мэдүүлэг өгөх үеэр түгшүүртэй байдаг бөгөөд гол айдас нь гэмт хэрэгтэнд чиглэх бол бусад айдас нь тухайн хүүхдэд тавьж буй асуултад хариулж чадахгүй байхаас ичдэгтэй холбоотой. Хүүхэд хэдий чинээ их айна, төдий чинээ асуултад хариулж чадахгүй. Хүүхэд нэгээс илүү удаа гэрчээр оролцоход урт хугацааны сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүсдэг.

Өсвөр насны хүүхдүүдийн хувьд хэрэгт гэрчээр оролцож байсан нь тэдний эрх зүйн тогтолцоог үзэх үзэлд сөргөөр нөлөөлдөг. Богино хугацааны үр дагаврын хувьд 218 хүүхдэд хийсэн судалгаанд гэрчийн мэдүүлэг өгөөгүй хүүхдүүдтэй харьцуулахад

мэдүүлэг өгсөн хүүхдүүд сэтгэлийн түгшүүр мэдрэх хандлага өндөр байсан бөгөөд гэрчийн мэдүүлэг өгөх хугацаа хойшлогдох нь тэдний сэтгэлийн түгшүүрийг нэмэгдүүлдэг. Урт хугацааны үр дагаврыг судлахад гэрчийн мэдүүлэг өгснөөс хойш 12 жилийн дараа 176 хүүхэдтэй ярилцлага хийсэн. Бага байхдаа гэрчийн мэдүүлэг өгсөн хүүхдүүдэд сэтгэл зүйн хүнд шинж тэмдэг илэрч байв. Гэрчийн мэдүүлэг өгсөн хүүхдүүд шүүгдэгчид хөнгөн ял онооход сэтгэл зүйн хор уршиг их гарсан. Эдгээр судалгаанууд нь гэрчийн мэдүүлэг өгсөн хүүхдэд сэтгэлзүйн байнгын дэмжлэг, зөвлөгөө өгөх шаардлагатай байгааг харуулж байна.<sup>13</sup>

Насанд хүрээгүй гэрчийн дараах эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хангах нь:

- Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.<sup>14</sup>
- Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.<sup>15</sup>
- Шүүх хуралдааны танхимд гэрчтэй хамт сэтгэл зүйчийг хамт байлцуулах;<sup>16</sup>
- Гэрчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.<sup>17</sup>

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд:** 35.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний оюун санааны байдал, учирч болох сөрөг нөлөөнөөс сэргийлэх нөхцөл байдлыг улсын яллагч, өмгөөлөгч нь шалгана.”

8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.”

3. Арван найман насанд хүрээгүй хүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг оролцуулахгүй байж болох ба өмгөөлөгчийг оролцуулна.

<sup>13</sup> <https://pediatrics.aappublications.org/content/139/3/e20164008>

<sup>14</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 5.

<sup>15</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6.

<sup>16</sup> Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17.2.4.

<sup>17</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32.9

**Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд:** Гэрч хохирогчийн хамгаалалтад байгаа хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцлалыг хамгаалах, (Энэ нь гэрч хохирогчийн хувийн орон зай, нэр төр болон аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хэрэгжих зарчим болохоос хамгаалах байрны үйл ажиллагааг нууцлах зохицуулалт биш юм гэдгийг хамгаалалтад байгаа гэрч хохирогчид ойлгуулах) шуурхай байх, хамтран ажиллах, гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана. /Энэ хэсгийг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн. /

**Гэрч, хохирогчийг нүүлгэн шилжүүлэх:** Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ.

Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

17 дугаар зүйл. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

17.1. Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

Шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, баталж мөрдүүлнэ.

**Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд:** Хүүхдийн эрхийн Конвенцын 37, 40 дүгээр зүйлүүдэд заасан насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх талаарх заалтууд нь насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх хууль зүйн шинэтгэлийн үндсэн агуулгатай. Монгол Улс Хүүхдийн Эрхийн Конвенцыг хэрэгжүүлэгч орны хувьд хууль зөрчсөн насанд хүрээгүй хүнийг зөвхөн гэмт хэрэгтэн гэж үзэлгүй тэднийг хүүхдийнх нь хувьд эрхийг нь хамгаалах хууль зүйн тусгай хамгаалалтыг бий болгох үүрэг хүлээснээ хэрэгжүүлж эхлээд байна.

Өсвөр насны хүнд ял оногдуулах (Эрүүгийн хуулийн наймдугаар бүлэг)

Урьд хүчин төгөлдөр үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуульд тодорхойлсон “насанд хүрээгүй хүн” гэсэн нэр томъёог Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад “өсвөр насны хүн” гэж өөрчилсөн бөгөөд Эрүүгийн хуулийг хэрэглэхдээ 18 насанд хүрсэн хүнээс ялгамжтай хэрэглэх зорилгоор уг хуулийн ерөнхий ангид тусгайлсан бүлэг оруулсан байна.

**2015 оны Эрүүгийн хуульд (шинээр тусгасан Наймдугаар бүлэг):**

1. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”
2. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.
3. Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.
4. Хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр энэ бүлэгт заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй.
5. Шүүхээс арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно.

Өсвөр насны хүнд ял оногдуулахдаа энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай арга хэмжээ хэрэглэж болно. Харин энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг ял оногдуулахгүйгээр дангаар хэрэглэж болохгүй.

“Анх удаа гэмт хэрэг үйлдсэн” гэсэн хязгаарлалтыг шинэчилсэн найруулгад тусгаагүй ба энэхүү нөхцөл нь шүүхээс тухайн өсвөр насны хүнд ял оногдуулахдаа харгалзан үзэх нөхцөл, байдал учраас хуульд тусгайлан заагаагүй байна.

НҮБ-ын 1985 оны “Өсвөр насны хүнд хэрэглэх шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм” буюу Бээжингийн дүрмийн 3.3 дугаар зүйлд гишүүн улс орнууд нь энэхүү дүрэмд заасан жишиг хэм хэмжээг өсвөр насны хүнд хэрэглэхээс гадна тухайн улсын хуулиар насанд хүрсэн гэж тооцогдсон залуу хүнд мөн адил хэрэглэх боломжийг



дотоодын хууль тогтоомжид тусгахыг үүрэг болгосон. Иймд уг олон улсын хүний эрхийн стандартыг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад шинээр тусгасан байна.

### **Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад:**

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өсвөр насны хүнд ял оногдуулах бодлогыг тусгайлан заасантай холбогдуулан өсвөр насны хүнд хэрэглэх ялын төрөл хэмжээ ч мөн адил ялгамжтай байхаар заасан. Шинэчилсэн найруулгад гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих гэсэн гурван төрлийн ял оногдуулахаар заасан.

Өсвөр насны хүний хийх нийтэд тустай ажил нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй байх бол зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэхдээ цахим гав ашиглан хэрэгжүүлнэ. Өсвөр насны хүнд хэрэглэх хорих ялыг “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих” гэж нэрлэсэн нь өсвөр насны хүнд оногдуулах “хорих ял” нь насанд хүрсэн хүнд оногдуулдаг хорих ялаас ялгамжтай хэрэгжих ёстой гэсэн санааг агуулсан.

### **Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйл. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах**

1. Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.
2. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж шийдвэр гаргана.
3. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.
4. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцод нийцүүлэн өсвөр насны хүнд оногдуулах нийтэд тустай ажил хийлгэх ял нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн хөгжилд харшлахгүй байхаар заасан. Иймд өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажлын байрны жагсаалт гаргах шаардлагатай.

Өсвөр насны хүнд оногдуулах зорчих эрхийг хязгаарлах ялын тухайд насанд хүрсэн хүнд хэрэглэхээр заасан журам мөн адил үйлчлэх боловч энэ журмаар тусгай ангид заасан зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгахаар заасан. Эдгээр шинээр орсон ялын төрлүүдээс гадна “насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” зохицуулалтыг агуулгыг хэвээр үлдээж нэр, томьёоны хувьд өөрчилсөн.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын бодлого, төрөл, хэмжээ зэрэг асуудлыг шинээр зохицуулжээ. Мөн хорих ялын хэмжээг 6 сараас эхлүүлсэнтэй холбогдуулан баривчлах ялыг хассан ба шинэчилсэн найруулгын тусгай ангид оногдуулахаар заасан хорих ялын хэмжээг өсвөр насны хүнд оногдуулж, эдлэх ялыг 2 дахин багасгахаар зохицуулсан. Түүнчлэн өсвөр насны хүнд оногдуулах хорих ялыг хэрэгжүүлэхдээ насанд хүрсэн хүнд оногдуулдаг хорих ялаас ялгамжтай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих” гэж нэрлэсэн байна.

Мөн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх субъектийг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхаар туйлын тодорхой заасан.

Энэхүү заалттай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэлэлцэн батлахдаа Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх процессын асуудлыг тусгасан байна.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх нөхцөл журам, хэрэгжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэх процесс зэргийг Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуульд нарийвчлан зааж өгснөөр шүүхээс уг албадлагын арга хэмжээг хэрэглэх боломж бүрдэхээс гадна гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг хуульд заасан гол зорилгууд биелэх бодит нөхцөл үүснэ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан шинээр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г байгуулахаар заасан ба уг хороо нь дараах үйл ажиллагааг явуулахаар заасан байна:

- 15.1.1. гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 15.1.2. сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

- 15.1.3. гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;
- 15.1.4. хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;
- 15.1.5. эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;
- 15.1.6. хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;
- 15.1.7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах.

Иймд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг практикт хэрэглэх, хэрэгжүүлэх зэрэг олон асуудал тодорхой болсон.

**Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүний эрх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгаа:** Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчим, ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх, мэдүүлэг өгөхөөс татгалзах, өмгөөлөгч авах, эцэг эх харгалзан дэмжигчийгээ байлцуулах, гэрчтэй нүүрэлдэх, дээд шатны шүүхэд давж заалдах эрх зэрэг насанд хүрээгүй хүний эрх байцаан шийтгэх ажиллагааны үндсэн баталгааг хэрэг хянан шийдвэрлэх бүх үе шатанд бэхжүүлсэн байх ёстой.

(Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам “Бээжингийн журам”)

Оролцогч улсууд эрүүгийн хууль зөрчсөн хэмээн сэжиглэгдсэн, яллагдсан, гэм буруутай нь тогтоогдсон хүүхдийн нэр төр, үнэ цэнэ, хүний эрх, бусдын үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үзлийг бататгах, нийгмийн амьдралд буцаан оруулах шаардлага, насны онцлогийг харгалзан, нийгэмд бүтээлч үүрэг гүйцэтгэх эрхийг хүндэтгэн хандана.

Хүүхдийг хэрэг үйлдэгдэх үед үндэсний хууль буюу олон улсын эрх зүйгээр хориглоогүй байсан үйлдэл, эс үйлдэлд холбон хууль зөрчсөн хэмээн сэрдэх, яллах, буруутгахгүй байх;

Гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэрдэгдсэн буюу яллагдагчаар татагдсан хүүхэд бүрийг дараах наад захын баталгаагаар хангана:

- I) гэм буруутай нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцох;
- II) ямар хэрэгт яллагдагчаар татаж байгааг өөрт нь шууд бөгөөд шуурхай мэдэгдэх, зохих тохиолдолд эцэг эх, түүний хууль ёсны асран хамгаалагчаар нь дамжуулан мэдэгдэж, өмгөөлөгч, эрх зүйн болон бусад шаардлагатай туслалцаа үзүүлэх;

- III) эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлж, хүүхдийн дээд ашиг сонирхолд харшлахгүй бол нас, нөхцөл байдал, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчдын хүсэл зоригийг харгалзан нэг талын эрх ашигт үйлчлэхгүй, хараат бус, эрх бүхий байгууллага, шүүхээр асуудлыг шударга шүүлгэх;
- IV) мэдүүлэг өгөх, гэм буруугаа хүлээхийг албадахгүй байх; эсрэг мэдүүлэг өгөх гэрчийг байцаах, байцаалгах, эрх тэгш нөхцөлд хүүхдийн өмнөөс гэрчийг байцаах, гэрчийг байлцуулах;
- V) эрүүгийн хууль зөрчсөн хэмээн гаргасан шийдвэр, түүний дагуу авсан арга хэмжээг нэг талын эрх ашигт үйлчлэхгүй, хараат бус, эрх бүхий дээд шатны байгууллагаар хянуулах;
- VI) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлийг ойлгохгүй буюу уг хэлээр ярьж чадахгүй бол орчуулагчийн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх;
- VII) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хүүхдийн хувийн байдлыг бүрэн хүндэтгэх. (Хүүхдийн эрхийн тухай конвенц. 40 дүгээр зүйл)

Сүүлийн 4 жилд насанд хүрээгүй хүмүүсээс 2800 гэмт хэрэг үйлдэж, нийт 4000 хүүхэд холбогдсон байна. Хүүхэд ихэвчлэн:

- Бусдын эд хөрөнгийг хулгайлах;
- Дээрэмдэх, булаах;
- Гэмтэл учруулж, зодох;
- Хүчиндэх;
- Завших, үрэгдүүлэх;
- Залилан мэхлэх;

Криминологи судалгаанаас үзэхэд хүүхдүүд дээрх хэргүүдийг түгээмэл үйлддэг бөгөөд, нас, бие, сэтгэхүйн онцлогоор бусдад уруу татагдаж бүлэглэн гэмт хэрэг үйлдэж цагдаагийн байгууллагад шалгагддаг. Жилд дунджаар 18 хүртэл насны 900 орчим хүүхэд гэмт хэрэгт холбогддог бөгөөд нийт гэмт хэрэг үйлдэгчийн 2.8 хувь нь сурагч байдаг гэсэн дүн мэдээ байна. Шүүхээр шийдэгдэж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн 95.8 хувь нь хорих ял шийтгэж, үүнээс 85 хувьд хорих ялыг хойшлуулж шийдвэрлэдэг байжээ.

Монгол Улсад жилд дунджаар 30,000 гаруй гэмт хэрэг бүртгэгддэгийн 7 хувь гаруй нь насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт хэрэг эзэлдэг боловч насанд хүрээгүй хүмүүстэй харьцуулахад гэмт хэрэг давтан үйлдэх, хорих ялаар шийтгүүлэгч хүүхдийн тоо өсөх хандлага ажиглагдах болсон.

Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнх нь урьд нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн

сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Энэ үед багш, нийгмийн ажилтан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу хүүхдийн хэрэг хянан шалгах ажиллагаанд “сурган хүмүүжүүлэгч” гэсэн статустай оролцдог.

Практикт багш сургуулийн нийгмийн ажилтнууд хүүхдийн байцаагчийг хүүхдийн хэрэг шалгадаг хэмээн буруу төсөөлөлтэй байдаг. Одоо хуулиар заасан хүрээнд хүүхдийн байцаагч нь хөнгөн гэмт хэргийг шалгахад гадна тухайн дүүрэг, орон нутагт хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулах, тэр дундаа хүүхдэд зориулсан яриа таниулга хийх, сургуулийн удирдлага багш, нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах байдлаар үйл ажиллагаа явуулдаг.

**Прокурорын чиг үүрэг:** Аймаг, дүүрэгт сургагч багшаар хүүхдийн хэрэгт хяналт тавих прокурорыг бэлтгэсэн бөгөөд заримдаа тухайн байгууллагын хүний нөөцийн бодлого, шилжилт, хөдөлгөөнөөс хамаараад хүүхдийн хэргийг энэ чиглэлээр дагнаж мэргэшээгүй прокурор хэргийг хянах тохиолдол гардаг.

Хууль ёсны төлөөлөгчийн зүгээс мэдвэл зохих гол зүйл бол мөрдөн шалгах ажиллагааны явцад хүүхдийг эрүүдэн шүүсэн, хууран мэхэлж, айлган сүрдүүлэх замаар мэдүүлэг авах, үндэслэлгүйгээр удаан хугацаанд хүүхдийг цагдан хорьсон, өмгөөлөгчгүй байцаасан гэх мэт хүүхдийн эрхийг зөрчсөн шинжтэй үйлдэл гарсан гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт зөрчлийн талаар мэдэгдэж уг зөрчлийг арилгуулж болдог.

**Шүүхийн чиг үүрэг:** Шүүхийн тухайд хүүхэд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзвэл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага ногдуулдаг бөгөөд хүүхдэд ногдуулсан хорих ялыг хойшлуулах, тэнсэх, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэх гэх шийдвэрүүдийг гаргадаг. Шүүхээс хүүхдийн хэргийг шийдвэрлэх шүүгчдийг мөн хуульчдын сургалтаар бэлтгэсэн бөгөөд дээр дурдсан мөрдөгч, прокурорт тулгардаг бэрхшээл мөн л адилхан гардаг.

Шүүхийн шатанд сурган хүмүүжүүлэгч, багш оролцож байгаа тохиолдолд анхаарвал зохих дараах бэрхшээл тулгардаг. Үүнд:

- Хүүхэд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзсэн тохиолдолд Эрүүгийн хуульд ял оногдуулахгүй байх, ногдуулсан хорих ялыг хойшлуулах зохицуулалт байдаг. Харин энэ арга хэмжээг хэрэглэхдээ “... хүүхдийн болон цагдаагийн байгууллагын санал”-ыг үндэслэн шүүх шийдвэрээ гаргана. Тиймээс багш, сурган хүмүүжүүлэгчийн хувиар оролцож байгаа үед хэргийн эхнээс л хүүхдийн байгууллагад урьдчилан хандсан байх ёстой.
- Хүүхдийн хэргийг шүүхээр шийдвэрлэх үед түүний хувийн байдлын талаар баримтууд ял онооход ихээхэн нөлөө үзүүлдэг. Тиймээс сурагч, хүүхдийн хувийн

байдал, сургалт, хүмүүжлийн талаар таны гаргаж өгч байгаа тодорхойлолт нөлөөлдөг гэдгийг анхаарвал зохино.

- Хүүхдэд оногдуулсан ялыг хойшлуулахдаа цагдаагийн байгууллагын саналыг бас үндэслэдэг. Гэхдээ үүнд хүүхдийн хэрэг шалгасан тухайн цагдаагийн байгууллагын албан хаагч биш харин хүүхдийн оршин суугаа газрын хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч эсвэл хүүхдийн байцаагчийн санал байдаг. Багш ихэнх тохиолдолд энэ ялгаа заагийг нарийн мэддэггүйгээс шүүх хурлын явцад хүүхдэд шаардагдсан тодорхойлолтыг гаргуулж чадаагүй, цагийг нь тулгаж хандсанаас амжихгүй болж хүүхэд хорих ялыг биечлэн эдлэхэд хүрч болох талтай

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлэгт “Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх” ажиллагааг тусгай журмын дагуу явуулдаг. Хууль сахиулах байгууллагын хандлага, хуулийн заалтын агуулга, хүүхдийг цагдаагийн байгууллагад шалгагдаж байх үед хамгаалах боломжуудын талаар багш, нийгмийн ажилтан тодорхой мэдлэгтэй болоход нэн тэргүүнд анхаарах хэд хэдэн зүйл байдаг.

- а/ Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг аль болох сургуулиас завсардуулахгүй, хөөхгүй, гадуурхагдахгүй байхад анхаарах. Цагдаагийн байгууллагад хүүхэд гэмт хэрэг үйлдээд шалгагдах үед тэднийг зурагтаар шууд гаргаж, шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад гэмт хэрэгтэн гэж зарлаж, сургуулиас хөөж байгаа нь туйлын буруу хандлага юм. Энэ нь хүүхдийн эрхийн зөрчлийн нэг хэлбэр болдгоос гадна хүүхэд өөрөө сэтгэхүйн хувьд эмзэг, мэдрэг байдгаас шалтгаалж айж эмээх, гэмшиж байсан сэтгэхүй нь өөрчлөгдөх, дөнгөж бүрэлдэж буй хувь хүний зан чанарт өөрчлөлт орох, өширхөх, хонзогнох, гэр орноосоо дайжих, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх зэрэг байдалд ордог.

Гэмт хэрэгт холбогдсон л бол сургуулиас хүүхдийг хөөдөг, нэр төрийг гутаан доромжилж харьцан, сургуулийн орчинд хүүхдийг гэмт хэрэгтэн, хулгайч, дээрэмчин мэтээр зарлах нь багш нийгмийн ажилтны ёс зүйд харш, зүй бус үйлдэл юм. Аль ч хуульд гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүүхдийг сургуулийн орчноос хөндийрүүлэх утга бүхий заалт байхгүй.

- б/ Нууцлалыг хадгалах. Хэрэг хянан ажиллагаанд татагдан оролцож, сурган хүмүүжүүлэгч гэсэн статустай болсон багш, нийгмийн ажилтан тухайн хэргийн талаарх мэдээллээс гадна хүүхдийн хувийн байдал, өвчин эмгэг ч юм уу бусад байдлаар хувь хүүхдийн нууцыг хамгаалах хэрэгтэй. Ялангуяа сургуулийн орчинд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн талаар ямар нэг яриа, мэдээлэл гаргахгүй байхад чухалчлан анхаарч, хүүхэдтэй өөртэй нь харилцаа тогтоох, итгэл төрүүлэх, аль болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хөндийрүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

в/ Хуулийн зүйл заалтын талаар зохих хэмжээний мэдлэгтэй байх. Ялангуяа Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэдтэй хамааралтай заалтуудын талаар өөрийн гэсэн мэдлэг, эзэмшиж, ашиглаж чаддаг байх нь багшид давуу байдал үүсгэж хүүхэд гэмт хэргийн карьер ахихгүй байхад тустай байдаг. Хуульд заагдсан боломжуудыг ашиглахгүй, хүүхдийн эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчигдсөн үед зүй ёсны шаардлага тавьж зөрчлийн элдэв хэлбэрүүдийг таслан зогсоохгүй байснаас хүүхэд гэмт хэргийн зам руу эргэлт буцалтгүй орж, зан аашны хувьд ихээхэн эвдэрч илүү ноцтой гэмт хэрэг үйлдэж болох талтай. Ямар үед хамт олны батлан даалтад авч болох, өмгөөлөгчтэй хэрхэн харилцах, байцаалтад хэрхэн оролцох, тодорхойлолт гаргахдаа юу анхаарах, шүүх хуралд оролцох шаардлага гарвал хэрхэх вэ гэх мэтчилэн олон зүйлд энгийн мэдлэгийг эзэмшсэн байх нь хүүхдийн эрхийг хамгаалах хамгийн боломжит хувилбар мөн.

**Сэжигтэн, яллагдагч хүүхдийн эрх:** Тухайн хүүхдийг зөвхөн гэмт хэрэгт сэрдэж байгаа тохиолдолд сэжигтнээр тооцдог бол харин гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон нотолгоог үндэслэн яллагдагчаар тооцдог. Хүүхэд ямар хэргээр сэжигтэн болсноо мэдэхгүй байвал энэ талаар мөрдөгч тайлбарлаж өгөөгүй, хүүхдийн ямар хэргээр сэжигтэн болсноо мэдэх эрхийг нь хангаагүй байна гэж ойлгож болно.

Хүүхэд сэжиглэгдсэн тохиолдолд нэн тэргүүнд хууль ёсны төлөөлөгчийн мэдэх ёстой зүйл нь:

**Хүүхэд холбогдсон хэрэгт заавал өмгөөлөгч оролцох ёстой:** Хүүхдэд өмгөөлөгч заавал авах үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол мөрдөгч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй. Ийм учраас хүүхдийн хэрэгт сурган хүмүүжүүлэгчээр оролцож байгаа багш, нийгмийн ажилтан нь хуулийн байгууллагын ажилтан, мөрдөгч, прокуророос өмгөөлөгчөөр хангахыг шаардаж аль болох хамгийн богино хугацаанд хүүхдийг өмгөөлүүлэх бололцоогоор хангах нь чухал.

Оройтож өмгөөлөгч авах эсвэл хүүхдийн хэрэгт өмгөөлөгч оролцуулаагүйгээс хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөл үүсэж болох талтай тул багш энэ асуудалд санаачилгатай оролцож, Өмгөөлөгчдийн Холбооны гишүүдийн нэрсийн жагсаалттай танилцах, эсвэл өмгөөллийн товчоонд хандаж болно. Өмгөөллийн тухай хуульд зааснаар өмгөөлөгч нь жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх, өмгөөллийн холбооны томилолтыг биелүүлэх үүрэгтэй байдаг. Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа багш нь тухайн хүүхэд төлбөрийн чадваргүй бол хуулийн дээрх заалтыг ашиглан өмгөөлөгч томилж өгөхийг хүссэн албан бичгийг сургуулийн захиргаа эсвэл цагдаагийн байгууллагаар хийлгэж, Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлэн асуудлыг шийдвэрлэж болно.



**Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх:** Зарим эцэг эхчүүд хүүхдээ гэмт хэрэг үйлдсэнийг гэнэт дуулаад өөрсдөө зодож шийтгэхийг урьтал болгодог. Мөн хохирогчдын гэр бүлийнхний зүгээс заналхийлэх явдал ч гардаг. Энэ тохиолдолд хүүхдийн хамгаалуулах эрхийг хангахын тулд нийгмийн ажилтан гэр бүлийнхэнтэй нь ажиллах шаардлагатай. Хүүхэд хийсэн хэргийнхээ төлөө шаналан, ичиж эмээж өөрийгөө өөрөө шийтгэж байхад нь нэрмээс болохгүй байх талаар ойлгуулж, хүүхдийн хүчирхийлэл бол гэмт үйлдэл гэж таниулах нь зүйтэй. Хэрвээ хүүхэд, гэр бүлийн гишүүдийн хооронд энэ мэт зөрчил, маргаан байвал харилцааг сайжруулах, бие биеэ ойлгох боломж олгох зөвлөгөө засал өгөх хэрэгтэй. Мөн хүүхдийн оршин сууж байгаа хорооны хэсгийн байцаагчтай холбоо тогтоож хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй алхам хийж болно.

**Хүүхэд сэжигтэн, яллагдагч болж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо хууль ёсны төлөөлөгчтэй байх эрхтэй.** Мөрдөгчийн тогтоолоор насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгчийг тогтоож, түүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад ямар эрхтэй оролцохыг тайлбарлана.

Хууль ёсны төлөөлөгчөөр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтооно.

- Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч нь дор дурдсан эрхтэй:
- Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг ямар хэрэгт сэрдэгдэж байгааг мэдэх;
- Яллагдагчаар тогтоогдож, мэдүүлэг байлцах;
- Байцаалт болон сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгчийг байлцуулан хийж байгаа бусад ажиллагаанд мөрдөгчийн зөвшөөрснөөр оролцох;
- Байлцсан ажиллагааны талаар саналаа бичгээр өгөх;
- Нотлох баримтын ач холбогдол бүхий зүйлийг шалгуулах хүсэлт тавих;

Хэрвээ амьдралын элдэв шалтгаанаар хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр томилох хүн байхгүй бол багш, нийгмийн ажилтан өөрөө байлцахаар санал тавьж болно. Гэхдээ хуульд сурган хүмүүжүүлэгч гэж онцлон заасан байдгийг сануулъя. Нийгмийн ажилтны хийж гүйцэтгэж байгаа ажлаар нь тэднийг сурган хүмүүжүүлэгч гэж тооцож болох тул өнөөгийн хуулийн хүрээнд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч гэж тооцож болох боломжтой.

**Хүүхдээс мэдүүлэг авахад оролцох:** Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад сурган хүмүүжүүлэгчийг байлцуулж болох ба оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй гэж үзвэл сурган хүмүүжүүлэгчийг заавал байлцуулна.

Сурган хүмүүжүүлэгч нь насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн бодол санаагаа хэрхэн илэрхийлж байгаа, түүний хэлсэн тодорхой үг, өгүүлбэрийг яаж ойлгож болох зэргийг сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс тайлбарлах үүрэгтэй мэргэжилтний хувиар мэдүүлэг өгөхөд байлцана.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаахад байлцсан сурган хүмүүжүүлэгч нь мөрдөгчийн зөвшөөрснөөр сэжигтэн, яллагдагчид асуулт тавих эрхтэй.

Мэдүүлэг авч дууссаны дараа түүнд байлцсан сурган хүмүүжүүлэгч тэмдэглэлтэй танилцах ба түүнд бичигдсэн зүйл бүрэн зөв болсон эсэх талаар саналаа бичгээр өгөх эрхтэй.

- Мөрдөгч, прокурор байцаалтын өмнө тухайн хэрэгт хамааралтай нөхцөл байдал, түүнчлэн насанд хүрээгүй этгээдийн хувийн байдлын талаар танилцуулга өгч, насанд хүрээгүй этгээдээс бодол санаагаа илэрхийлэхэд туслах талаар хэлж, сурган хүмүүжүүлэгчид түүний эрхийг тайлбарлан өгөх үүрэгтэй бөгөөд тэр тухайгаа мэдүүлэгт дурдана.

Хуулийн байгууллагаас хөнгөн хэрэгт сэрдэгдсэн сэжигтэн, яллагдагч хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийнх нь хяналтад гадуур байлгаж мэдүүлэг авахаар дуудаж ирүүлдэг. Зарим мөрдөгч хүүхдийг олон дахин ирүүлж гаднаа олон цагаар хүлээлгэх, сургуульд нь зарлан дуудах хуудсаар дуудлага явуулах зэрэг нь хүүхдийг хашраах, улмаар хэргээ хурдан хүлээхэд хэрэгтэй гэж үздэг. Энэ буруу арга барил нь хүүхдийг хичээлээ олон цагаар таслах, улмаар сургуулиас завсардахад хүргэдэг. Багш мэдүүлэг өгөх цагийг хүүхэдтэй тохиролцож урьдчилан төлөвлөж өгвөл хүүхдийн сурч боловсрох, нэр төрөө хамгаалах, өөрийнхөө эрх ашигт хамааралтай шийдвэр гаргахад оролцох зэрэг олон эрхийг нь алдагдуулахгүй байх сайн талтай. Наад зах нь хүүхдийг заавал цагдаагийн байгууллага дээр биш зарим тохиолдолд багштай сургуулийнх нь эсвэл гэр бүлийнх нь орчинд мөрдөгчийг энгийн хувцастай ирүүлж байцаалгаж болдог. Энэ хэлбэрийг хуулиар хориглоогүй учраас цэвэр санаачилгын асуудал гэдэг нь тодорхой байна.

Хүүхдийг нэг удаа 2 цаг, өдөрт 4 цагаас илүү байцааж болохгүй гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заадаг. Хоёр цагийг мөн цагаар тооцох ёстой. Жишээ нь байцаалт 14 цаг 50 минутад эхэлсэн бол 16 цаг 50 минутад завсарлах ёстой. Түүнээс биш энэ байцаалтыг 14 цагт эхэлсэн гэж үзээд 16 цагт дуусгаад дараа ир гэж явуулаад байх юм бол хэргийг шийдэхгүй сунжруулах болно. Гэхдээ хурдан шийднэ гэж 4 цагаас олон цагаар байцааж хүүхдийг ядрааж залхааж болохгүй.

**Амьдралын нөхцөл байдал ба хүмүүжлийг тогтоох талаар тулгамдаж буй асуудал:** ЭХХШТХ-д заасны дагуу өсвөр насны хүний хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах буюу шүүхээр хянан хэлэлцэхэд амьдралын нөхцөл байдал ба хүмүүжил зэрэг байдлыг заавал тодруулна.

Тухайн насанд хүрээгүй этгээдийн амьдралын нөхцөл байдлыг тогтоохдоо дараах зүйлийг тодруулах шаардлагатай байдаг. Үүнд:

- Амьдрал ахуйн нөхцөл, орон гэртэй эсэх,
- Тухайн хүүхдийн хэвийн өсөлт, хөгжилтөд шаардагдах эрдэс бодис, илчлэгийг өдөр тутамд хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнээрээ авч чаддаг эсэх,

- Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрх гэсэн ангилалд хамаардаг эсэх, өрхийн орлого,
- Тухайн хүүхэд бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдардаг эсэх, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээсэн эсэх, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй эсэх,
- Эцэг, эх нь хүүхэдтэйгээ хэрхэн харьцдаг, хүүхдээ хүмүүжүүлдэг арга барил, эцэг эх нь эцэг, эх байх эрхээ шүүхээр хасуулсан эсэх, хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл, дарамтад байдаг эсэх.
- Хүүхдийн хүмүүжлийг тогтоохдоо түүний сурлага, сахилга бат, хичээлийн идэвх, оролцоо, хичээлийн бус цагаар зохиогдож буй олон нийтийн ажил, арга хэмжээний оролцоо, секц, дугуйлан, клубт хамрагдаж хичээллэдэг эсэх, хэрэв ажил эрхэлдэг бол ажилдаа хандах хандлага, найз нөхөд, хамт олны нөлөөлөл зэргийг тодруулах нь зүйтэй.

Гэвч мөрдөгч хүүхдийн амьдралын нөхцөл байдал, хүмүүжлийн байдлыг хэрхэн тогтоох талаар мэдлэг дутмаг, хууль эрх зүйн орчин төгс бүрдээгүй, тухайлбал, ЭХХШ тухай хуульд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдийн амьдралын нөхцөл байдал ба хүмүүжлийн байдлыг хэрхэн тогтоох, ямар нотлох баримт, нөхцөл байдлуудыг заавал тодруулсан байх талаар тусгаагүйн улмаас байцаалт төдийгөөр хязгаарлан хүүхдийн амьдралын нөхцөл байдал, хүмүүжлийн байдлыг хангалтгүй тогтоож байна.

Эндээс харвал мөрдөгчийн дээрх ажилд багш, сурган хүмүүжүүлэгчийн нөлөөлөл ямар их болох нь анзаарагдаж байна. Хүүхдийн талаар хамгийн их мэдэх, тодорхойлолт гаргаж чадах хүмүүс бол анги хамт олон, багш байдаг онцлогийг давуу байдлаар ашиглаж чаддаг байх хэрэгтэй.

Гэм буруутай этгээдийн хувийн байдал нь хүний нийгмийн мөн чанар, түүний сэтгэхүй ба биологийн онцлогийг багтаасан ойлголт мөн. Уг этгээдийн зан төлөвийн өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагийн орчлоор авч үзвэл эерэг тал нь тогтоогдсон байхаас гадна түүний насны болон эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэх учиртай.

Гэм буруутай этгээдийн гэмт хэрэг үйлдэх болон үйлдсэний дараах зан үйлийн баримт сэлтийг бүрэн ба гүнзгий харгалзан үзэхгүйгээр ялын зорилгод хүрэх, ялын зохистой төрөл хэмжээг сонгон авахад ихээхэн хүндрэл учирна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал гэдэгт ялыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдал, түүнчлэн яллагдагчийн амьдрал, хүмүүжлийн нөхцөл, ял хойшлуулах тохиолдолд түүний хүрээлэн буй орчныг тодорхойлогч нөхцөл байдал хамаарна.

Жишээ нь: Б насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн бөгөөд үүнээс өмнө ямар

нэгэн хэрэг төвөгт холбогдож байгаагүй, сургууль, оршин суугаа газраас нь эергээр тодорхойлсон, гэм буруугаа хүлээж, үйлдсэн хэрэгтээ чин сэтгэлээсээ гэмшсэн, хулгайлсан эд зүйлээ буцааж эзэнд нь өгсөн зэргээс үндэслэн шүүх түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрчээ.

**Таслан сэргийлэх арга хэмжээ авахад нөлөөлөх:** Эрүүгийн хэрэг үүсгэн хүүхдэд таслан сэргийлэх арга хэмжээ авдаг. Таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь мөрдөн шалгах ажиллагааг саадгүй, түргэн шуурхай явуулах, сэжигтнийг оргож зайлуулахгүй байх зорилгоор тодорхой үндэслэл бий болсон тохиолдолд хэрэглэдэг арга хэмжээ юм.

Тэнэмэл амьдралтай, хараа хяналтгүй, өнчин өрөөсөн, гэр орныхондоо шоовдорлогдсон хөнгөн хэрэгт сэрдэгдсэн сэжигтэн хүүхдийг хараа хяналтдаа байлгах насанд хүрэгчдийг тогтоож чадахгүйгээс болж хэргийг нь шүүхэд шилжүүлэлт урьдчилан хорих явдал байсаар байна. Түр цагдан хорих практикийг түлхүү хэрэглэх нь хүүхдийг гэмт хэргийн ертөнцөд татагдан орох, давтан гэмт хэрэг үйлдэх явдлыг нэмэгдүүлдгийг олон оронд хийгдсэн судалгаа харуулдаг. Тэгэхлээр хараа хяналтгүй болон амьдралын элдэв гачигдал шалтгааны улмаас хууль ёсны төлөөлөгчтэй байж чадахгүй хүүхдүүдэд цагдан хорихоос өөр арга хэмжээг авах талаар бодлогын хэмжээнд их зүйл хийх хэрэгтэй байна.

Хүнд буюу ноцтой гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг урьдчилан хорих байранд хуулийн холбогдох заалтын дагуу шүүхээс зөвшөөрөл авсны дагуу хорьж болдог. Гэхдээ хүүхдүүдийн хоригдох хугацаа хэтэрхий урт байж болохгүй. Насанд хүрээгүй хүнийг хорьж мөрдөх хугацаа бага байх ёстой гэсэн заалт хуульд бий. Сүүлийн үед хуулийн байгууллагын баримталж байгаа зарчим бол хүүхдийг аль болох хорихгүйгээр шалгаж шийдэх талаар адилхан байр суурьтай байгаа болно.

Хэрэв хүүхдийн хэрэг шийдэгдэхгүй удах юм бол мөрдөгчтэй нь уулзаж хүүхдийн эрх зөрчигдөж байгааг сануулах нь зүйтэй.

Урьдчилан хорих явдлыг хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэхийн тулд мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хүүхдүүдийг зүй ёсоор хянах оновчтой арга барилыг нэвтрүүлэхэд багш, нийгмийн ажилтнууд өөрийн мэргэжлийн ур чадварыг дайчлан ажиллавал зохино.

**Насанд хүрээгүй этгээдийг хяналтад өгөх:** Өсвөр насны хүнийг түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийн бичгээр буюу амаар гаргасан хүсэлтээр буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчийн санаачилгаар хяналтад шилжүүлэн өгч болно.

Мөрдөгч, прокурор, шүүгч хяналтад шилжүүлэх тухай шийдвэр гаргахын өмнө насанд хүрээгүй этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь түүнтэй дотны харьцаатай эсэх, үйл хөдлөл, зан байдалд нь хяналт тавих бололцоотой эсэхийг урьдчилан судалж, тогтооно.

Насанд хүрээгүй этгээдийг эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийн хяналтад шилжүүлэх тухай шийдвэр гармагц уг этгээд нь насанд хүрээгүй этгээдийг мөрдөгч болон шүүхээс

дуудсан цагт ирүүлж байх, түүнийг төлөв томоотой байлгах үүргийг хүлээнэ.

Насанд хүрээгүй этгээдийг хяналтдаа авч байгаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид түүний сэрдэгдэж байгаа буюу яллагдах гэж байгаа хэргийн талаар мэдэгдэж, хүлээсэн үүргээ зөрчвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулна.

Насанд хүрээгүй этгээдийг хяналтдаа авсан этгээд хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд торгууль оногдуулна. Мөнгөн торгуулийн хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг байх бөгөөд түүнийг улсын төсөвт оруулдаг.

Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг хэргийн материалтай танилцуулах:

Насанд хүрээгүй яллагдагчид хэргийн материалыг танилцуулахад түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийн гаргасан хүсэлтийг харгалзан оролцуулдаг онцлогтой.

Хууль ёсны төлөөлөгч нь хэргийн материалтай танилцах явцдаа өмгөөлөгчтэй ярилцаж түүнд хэрэгт ач холбогдол бүхий зарим зүйлд анхаарлаа хандуулахыг зөвлөхөөс гадна хэргийн материалтай танилцахад нь насанд хүрээгүй яллагдагчид тусална. Ямар ч байдлаар багш хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бол тэдний эрх ашгийг хамгаалах бүхий л хэлбэрүүдийг хэрэглэж чаддаг байх ёстой.

Насанд хүрээгүй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл мөрдөгч нь насанд хүрээгүй яллагдагчид хэргийн материалыг танилцуулахад түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг оролцуулахгүй байж болно. Энэ нь хүүхдийн талаар сөрөг мэдээлэл тараах боломжтой, эсвэл хүүхдийн эсрэг ашиг сонирхолтой, эрх хөндөгдөхөөр байвал оролцуулахгүй гэсэн үг юм. Гэр бүлийн хүчирхийлэлд байсан, эцэг эх нь хүүхдийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдсэн үед энэ байдлын талаар хамгийн сайн мэдэх хүмүүс анги даасан багш байдаг.

Гэмт хэрэг шалгах явцад магадгүй багш, сурган хүмүүжүүлэгчийн хувиар оролцож байгаа таны мэдүүлэг, гаргаж өгч байгаа тодорхойлолт хүүхдийн хувь заяатай шууд холбогдож, хүндхэн хариуцлага ирдэг учраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас төвөгшөөж, хайнга хандаж огт болохгүй. Ирээдүйд мэргэшсэн гэмт хэрэгтэн бий болгохгүйн тулд, сайн хүн болгохын тулд нийгмийн өмнө хүлээсэн багшийн үүргээ ухамсарлаж байж, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг цааш түлхэхгүйгээр, хуулийн талаар энгийн мэдлэгтэй байж, хүүхэд холбогдсон хэрэг нэг бүрийн араас хөөцөлдөж явж чадвал хүнд ял шийтгүүлэлгүйгээр хүмүүжүүлж засаж авах боломж хуульд тусгагдсан байдаг.

Иймэрхүү явдал хүүхдийн гэмт хэргийн практикт тохиолддогийг нийгмийн ажилтнууд ямагт харгалзан үзэж өөрийн мэргэжлийн онцлог, ур чадвараа ашиглан гэмт хэрэгт холбогдсон хүүхэд болон түүнтэй ажиллаж байгаа хуулийн байгууллагын ажилтнуудад зөвлөн нөлөөлж, хүүхдийг хилс хэрэгт орохоос хамгаалах нь чухал.

**Шүүгдэгч хүүхдийн эрх:** Хүн бүр эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас ял шийтгүүлэх буюу иргэний шүүн таслах ажиллагаагаар эрх, үүргээ тодорхойлуулахдаа хэргээ хуулийн дагуу байгуулагдсан эрх мэдэл бүхий, бие даасан, шударга шүүхээр нээлттэй хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй. Эрүүгийн гэмт хэрэгт шүүгдэж байгаа хэн боловч шүүх ажиллагаанд биеэр оролцох, өөрийгөө өмгөөлөх буюу сонгож авсан өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх, өөрийн эсрэг мэдүүлж байгаа гэрчийг байцаах буюу байцаахыг шаардах, орчуулагч авах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээр хангагдана.

Хүүхэд нь аль нэг талын ашиг сонирхлыг баримтлаагүй хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх ёстой. Шүүх бол зөвхөн ял шийтгэл оноох биш хууль зүйн туслалцааг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдыг нь байлцуулан үнэ төлбөргүй үзүүлэх ёстой. Хэргээ шүүлгэж байгаа хүүхэд шүүхийн өмнө өөрийгөө өмгөөлж гэрчид асуулт тавих эрхтэй байдаг. Нийгмийн ажилтны хувьд хүүхдэд олны өмнө ярих, асуулт тавих чадварыг нь дээшлүүлэх талаар ажиллавал зохино.

Шүүх хуралдаан эхлэхэд шүүгчийн зүгээс шүүгдэгчид эрх үүргийг нь тайлбарлаж өгнө. Манайд хүүхдийн хэргээр мэргэшсэн шүүгч байхгүй болохоор зарим үед хүүхдийн тайлбарыг ойлгохгүй байх нь бий. Иймд нийгмийн ажилтан шүүх хурлаас өмнө хүүхдэд эрх, үүргийг нь сайн тайлбарлаж өгөх нь зүйтэй бөгөөд шүүх хуралд хууль ёсны төлөөлөгчөөр ч оролцож болно. Харин шүүхийн зүгээс энэ нь шүүгдэгч хүүхдийн эрх ашигт харшилна гэж үзвэл тэднийг шүүх хуралдаанд оролцуулахгүй байж болдог.

Хэрвээ хүүхэд холбогдсон тухайн хэрэгт насанд хүрсэн том хүмүүс оролцсон бол хэргийг нь тус тусад нь шүүдэг.

**Өсвөр насны хүн гэмт хэрэгтэн болохоос өмнөх сэтгэл зүйн байдал:** Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх болсон хүчин зүйл нь генетикийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйлийн холимог байдлаас үүдэлтэй байдаг. Өсвөр насны хүүхдүүдийн гэмт хэрэг үйлдэх хамгийн чухал хүчин зүйл нь эцэг эхийн хэв маяг, үе тэнгийн бүлгийн холбоо юм. Өсвөр насны хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болзошгүй нэмэлт хүчин зүйлүүд нь санхүүгийн бэрхшээл, сургуулиас завсардсан байдал, бүтэлгүйтэл, мөн үе тэнгийнхнээсээ хөндийрөх зан үйл байдаг.

Өсвөр насандаа ганц бие эцэг эхийн гар дээр өссөн хүүхдүүд эцэг эх хоёулаа амьдардаг хүмүүстэй харьцуулбал ядууралд нэрвэгдэх, гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг.

Үе тэнгийнхнээс татгалзах нь насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх урьдчилсан бэлтгэлийг хангадаг. Өсвөр насны хүүхэд ийнхүү үе тэнгийнхнээсээ хөндийрснөөр түүний зөв нийгэмших чадварт нөлөөлж, ихэвчлэн нийгмийн сөрөг үе тэнгийн бүлгүүдэд татагдахад хүргэдэг. Өсвөр насны хүүхдийн хөгжлийн судалгаанаас харахад өсвөр насныхан эрсдэлд өртөмтгий байдаг.

Өсвөр насны хүүхэд зан авирын сөрөг хэв маягаа үргэлжлүүлсээр арван найман нас хүрмэгц эрүүгийн ноцтой гэмт хэрэгтэн болох магадлал өндөр байна. 15 наснаас өмнө

зан авирын эмгэгийн түүхийг тодруулах шаардлагатай. Зан авирын эмгэг нь тогтворгүй, түрэмгий зан авиртай ижил төстэй байдаг. Тиймээс зан авирын эмгэг гэж оношлогдсон насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн эрт үеийн шинж нас бие гүйцсэн хойноо илэрдэг. Гэмт хэрэгтэн бие хүн бага сургуульд орохоосоо өмнө нийгмийн эсрэг зан үйл үйлдэж эхэлдэг бөгөөд тэд олон төрлийн хор хөнөөлтэй зан авир гаргадаг, бусдад маш ихээр гомддог онцлог төрх үйлийн шинж илэрдэг.

**Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүүхдийн сэтгэл зүйн онцлог:** Сэжигтэн ч буруутгагдаж буй этгээд ч заавал хэрэгтэн байх албагүй. Иймд хэргийн гол асуудал буюу уг хэргийг тухайн этгээд үйлдсэн үү үгүй юу гэдгийг тогтоохын тулд тэдний сэтгэлзүйг маш сайн ойлгодог байх хэрэгтэй юм. Тухайлбал, сэжигтний хувьд зан байдал нь ойр ойрхон хувирч байх талтай.

Гадны цочролд хүний үзүүлэх хариу үйлдэл нь хоёр янз байдаг. Тэгвэл физиологийн хариу үйлдэл нь мөн л сэтгэлзүйн хувьд түгшүүртэй, хурцадмал байдалтай байгааг гэрчлэх бөгөөд сэжигтний нүүрний хувирал болон гарын дохио зангаагаар илэрч байдаг болно.

Байцаалтын үеэр буруутан этгээд сэтгэлзүйн янз бүрийн байдалд орж байж болно. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн бол илчлэгдэх, улмаар ял зэмлэлээс айж байх нь тодорхой. Энэ нь сэтгэлзүйд дарамт учруулж, сэжигтнийг ихээхэн мохоож, үүссэн нөхцөл байдлыг буруу үнэлэх нөхцөл бүрдүүлэх, бие барих чадвар алдахад хүргэж байх магадлалтай. Ингэснээр сэжигтнийг сэтгэлзүйн холбоо тогтоох явдлыг хүндрүүлж, улмаар байцаалтын тактикийн аргуудын үр нөлөөг бууруулна.
2. Байцаалтын үеэр гэр бүл, ойр дотны хүмүүс, найз нөхөд болон хамт ажиллагсад нь хэргийн талаар мэдэх вий гэж айсны улмаас сэтгэлийн хямрал, ичгүүртэй байдалд орсон байж болох юм. Иймд бусдад задруулахгүй байх хүсэл нь буруутны зан байдлыг тодорхойлогч хүчтэй сэдэл болж байдаг.
3. Буруутан этгээдийн хувьд өөрийн хүрсэн нийгмийн байр суурь, албан тушаал, эд хөрөнгөө алдахаас айх явдал үндсэн шинж болж байдаг. Иймээс гэмт хэрэг үйлдсэн бол байцаалтын үеэр үнэн зөв хариулт өгөхөөс зайлсхийдэг.
4. Сэжигтний зан төлөвийг тодорхойлогч хамгийн хүчтэй сэтгэлзүйн байдлуудын нэг нь эрх чөлөө, хэвийн амьдралаа алдаж, улмаар гэмт хэрэгтнүүдтэй нэг дор байхаас айх айдас юм.
5. Сэжигтний зан төлөвийг нэлээдгүй хэмжээгээр тодорхойлогч сэтгэлзүйн байдал бол ойр дотны хүмүүсээсээ хагацахтай холбоотой сэтгэл зовнил байна. Энэ нь нэг талаас буруугаа хүлээж үнэн зөв мэдүүлэг өгөх, эсвэл эсрэгээрээ худал мэдүүлэхэд хүргэж байж болно.
6. Сэжигтний хувьд хохирогч, түүний гэр бүл, ойр дотны хүмүүсийг өрөвдөх сэтгэл төрөх нь цөөнгүй. Үүнийг нь мөрдөгч дэмжиж, бататгаж өгөх нь чухал.
7. Байцаалтын үеэр ихэвчлэн үүсэх хурцадмал байдлуудад сэжигтэн нэг л “зайдгай”



байдалтай болж, сандарч байгаагаа дарах, мөрдөгчид “үнэнээ хэлэх” хүсэлтэй, өөрийн амьдрал, хүсэл сонирхол, азтай болон азгүй тохиол, мөрөөдөл, төлөвлөж явдаг зүйлс гэх мэтийн талаар бүхнийг биш юм аа гэхэд нэлээдийг нь ярьж өгөхөд бэлэн болсон байх магадлалтай. Энэ нь түүнийг гэмээ ухаарч, үнэн зөв мэдүүлэг өгөхөд хамгийн тохиромжтой үед байгааг илэрхийлнэ.

8. Зарим сэжигтэн цагдаагийн ажилтан, мөрдөгч, прокурор, гэрч гээд түүнийг илчлэхэд оролцож буй бүхий л хүмүүст дайсан шиг ханддаг. Сэжигтний ийм байр суурь түүнд сэтгэлзүйн зөв арга хэрэглэх явдлыг ихээхэн бэрхшээлтэй болгож байдаг.<sup>18</sup>

**Гэмт хэрэг үйлдсэн хүүхэдтэй ажиллах нь:** хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх нөхцөл журам, хэрэгжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэх процесс зэргийг Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуульд нарийвчлан зааж өгснөөр шүүхээс уг албадлагын арга хэмжээг хэрэглэх боломж бүрдэхээс гадна гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг хуульд заасан гол зорилгууд биелэх бодит нөхцөл үүснэ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан шинээр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г байгуулахаар заасан ба уг хороо нь дараах үйл ажиллагааг явуулахаар заасан байна:

1. гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
2. сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
3. гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;
4. хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;
5. эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;
6. хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;
7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах. гэх мэтчилэн тодорхой заасан боловч үүнийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нэгж, орон тооны бус хороонууд хэлбэрийн шинжтэй үйл ажиллагаа явуулж, нэгдсэн бодлого

18 Хуулийн сэтгэл зүйч, докторант Ш.Номин-Эрдэнэ Хуулийн сэтгэл судлал (2021 он)

төлөвлөгөөтэй ажиллахгүй байгаагаас хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх нь сорилт, бэрхшээлтэй нүүр тулж байна.

#### **Сорилт, бэрхшээл:**

- Хэдийгээр хүүхэд хамгаалах арга хэмжээг хууль тогтоомжид цогц байдлаар тусгасан боловч түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага, алба хаагчид өөр, өөр ойлголтой, тус тусын үйл ажиллагааны хэлбэрээр ажлын үзүүлэлтийг дүгнэдэг нь үндсэн бэрхшээл гэж үзэж байна.
- Өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын ажиллагаа зэрэгцээ /параллель/ хэрэгжиж явах учиртай. Гэтэл эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх, тухайн орчинд хамгаалж төлөвшүүлж, хүүхэдтэй ажиллах талаар тус тусдаа үйл ажиллагаа явуулж, харилцан мэдээлэл солилцохгүй шийдвэрлэж байгаа нь цаашид шийдвэрлэх сорилт болж байна.
- Өсвөр насны хүн, эрсдэлт нөхцөлд хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах анхан шатны хэлбэр болох хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны шийдвэр түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх явцад шийдвэр гаргах эрх бүхий субъект болох мөрдөгч, прокурор, шүүгчийн шийдвэр харилцан адилгүй, мөн чанарын хувьд ялгаатай байгаа нь хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэхэд шийдвэрлэх асуудлын нэг хэвээр байна.
- Өөрөөр хэлбэл хүүхэд хамгааллын тогтолцоо нь өсвөр насны хүний хэрэг шийдвэрлэх тогтолцоотой нягт уялдаатай тул тулгамдаж асуудлыг “том зургаар” харж хамтдаа гарц шийдлийг олох шаардлагатай юм.

#### **Гарц боломж:**

- Өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хамтад нь хэрэгжүүлэх, хууль сахиулагч болон хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан ажилтныг чадавхжуулах
- Өсвөр насны хүн эрсдэлт нөхцөлд байгаагаас хамаарч гэмт хэрэг үйлдсэн эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон тохиолдолд хамтарч ажиллах, мэдээллийн сан үүсгэж ашиглах
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг чиглүүлэх, түүний гишүүдийг арга зүйгээр хангах
- Хуульчийн үргэлжилсэн сургалтад хүүхдийн асуудлаар тусгай сургалтын хөтөлбөр нэмж, хуульчдад сургалт зохион байгуулах
- Нийгмийн хамгааллын салбарын ажилтан буюу хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн ажилтан, мэргэжилтэнд хууль зүйн тогтолцооны талаар нэгдсэн ойлголт өгөх зэрэг хэлбэрээр хүнээс хамаарах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

**Сургалтад ашиглах кейс<sup>19</sup>**

**Кейс-1.** Шүүгдэгч \*\*\*\*\* нь 2021.01.21-ний өдрийн 21 цагийн үед согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ эхнэр Ж.Жавзанхоролыг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, нүүр толгойн хэсэг газарт цохиж, улмаар хоолойг нь багалзуурдаж амьсгалыг нь бүтээж алсан гэмт хэрэгт холбогджээ. Төрсөн эцэг нь төрсөн эхийнх нь амь насыг хохироосны улмаас насанд хүрээгүй хохирогч үлдсэн. Хохирогч хүүхдийг шүүх хуралд оролцуулаагүй, харин хууль ёсны төлөөлөгчийг оролцуулсан. Мөн шүүх бүрэлдэхүүн шүүгдэгч \*\*\*\*\*ын насанд хүрээгүй охин Н-ий асрамжийг Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д заасны дагуу шийдвэрлэхийг Баянзүрх дүүргийн Засаг даргад даалгаж шийдвэрлэв. Харин хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Ц. нь талийгаачийн насанд хүрээгүй хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэмж болон гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохирлын талаарх нотлох баримтаа хуульд заасны дагуу бүрдүүлэн гэм буруутай этгээдээс иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.

**Кейс-2.** Л.М нь согтуурсан үедээ 2021 оны 01 дүгээр сарын 15-ны орой 17 цагийн үед Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Моносын 2 дугаар гудамжны 366 тоот дахь нийтийн байрны 7 тоотод А.Чимэдцогзол /эрэгтэй, 41 настай/-той үл ялих шалтгаанаар маргалдаж, улмаар түүний хэвлийн зүүн хэсэгт хутгалж алсан гэмт хэрэгт холбогджээ. Мөрдөн шалгах ажиллагаанд гэрч Ү-гийн өгсөн: "... манай аав надад "би хүн алчихлаа аав нь эмнэлэг, цагдаа дуудсан" гэж хэлээд "чи хүрээд ир, ирж чадахгүй бол боль" гэж хэлээд утсаа салгасан..." гэх мэдүүлэг /хх.59-60/,

**Кейс-3.** Шүүгдэгч Б.О нь 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Орхон аймгийн Баян-Өндөр сумын Их залуу багийн Шандын баруун задгай 8-02 тоот гэртээ өөрийн төрсөн хүү 03 сартай О.Б-г биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хөлөөс нь барьж, шидсэний улмаас "тархи доргилт" гэмтэл буюу хөнгөн хохирол санаатай учруулсан, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Орхон аймгийн Баян-Өндөр сумын Их залуу багийн Шандын баруун задгай 8-02 тоотод гэртээ өөрийн төрсөн хүү 9 настай А.Б руу аяга шидэж, толгойн тус газар нь онож, өшиглөх, цохих зэргээр биед нь халдаж, хүү А.Б-ийг дан цамцтай гэрээсээ хөөж гаргасан, 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Цагдаагийн газрын байранд 03 сартай хүү О.Б-г чимхэж уйлуулж, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны зовуурь, шаналал үүсгэсэн гэмт хэрэгт холбогджээ. МША-нд хууль ёсны төлөөлөгчгүй, өмгөөлөгчгүй оролцсон. Б-гоос асуухад ээжээ би тийм мэдүүлэг өгөөгүй, намайг энэ дээр гарын үсэг зур гэхээр нь нэрээ бичсэн гэж хэлсэн" гэв. Насанд хүрээгүй хохирогч Б-гийн" Өглөө дүү бид хоёрыг аваад "Сайхан" дэлгүүрээс ... 1 архи, 2 шил 100 граммын

19 Шүүхийн шийдвэрт хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хангасан талаарх шийдвэр гаргасан эсэх судалгаа (хохирол, хор уршиг, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлсөн байдлын судалгаа, нэр төрийг хамгаалж нүүлгэн шилжүүлэлт хийсэн талаарх судалгаа) Эх сурвалж: Shuukh.mn

архи авсан. Орой ээж архиа уучхаад дүү бид хоёрт агсам тавиад намайг өшиглөж унагаагаад гараараа цохиод халбага шидсэн. Дүүг ор руу шидээд, нуруу руу нь цохиод, газар унагаахаар нь би дүүг тэврээд явж байсан чинь намайг зодоод байсан. Удалгүй ээж унтаад би дүүгээ угжсан. Гаднаас 4 цагдаа орж ирээд гал түлж өгсөн. Гал түлчхээд гараад явсан. Гал унтарчихаар нь ээжийг дуудаад гал түлээд өг гэсэн. Ээж босоод гал түлж өгсөн. Орж ирэхдээ нэлээн согтсон, гунхаад байсан. Ээж гэрт орж ирээд бид хоёрт агсан тавиад дүүг буйдан дээр хэвтэж байхад нэг хөлөөс нь бариад буйдангийн нэг тал руу саваад тэгээд дүүг аваад намайг дан ганц цамц, өмдтэй, гуталтай гэрээс хөөж гаргаад хаалгаа түгжихсэн. Тэгээд би цагдаа нар руу залгахад цагдаа нар ирж. 3 цагдаа гэр рүү ороод би нэг цагдаатай машин дотор байсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан өөрийн хүүхэдтэй удаа дараа хэрцгий харьцаж, бие махбод, сэтгэл санааны зовуурь шаналал үүсгэсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсон ингэхдээ цагдан хоригдоогүй, бусдад төлөх төлбөргүй, шүүгдэгчийн иргэний бичиг баримт шүүхэд ирээгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нэхэмжлээгүй болохыг тус тус дурдсан.

**Кейс-4.** Шүүгдэгч Р.Д нь Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвд 2020 оны 05 дугаар сарын 14-өөс 2020 оны 05 дугаар сарын 15-нд шилжих шөнө гэр бүлийн хамаарал бүхий буюу эхнэр Х.Б-г онц харгис хэрцгийгээр, хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж санаатай алсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

...Юу болсон юм аниадаа хэлээч гэхэд би танд юу ч ярьж чадахгүй миний ээж үхсэн. Би хэрэв аавын талаар ярих юм бол би 2 өнчин дүүтэйгээ үлдэнэ. Би хоёр өнчин дүүгээ өсгөж чадахгүй гэж хэлсэн. Тэр бол 14 настай хүүхдийн амнаас гарах үг биш. Бүх зүйлийг зохион байгуулалттай хийсэн. Үнэхээр мэргэшсэн алуурчин. Дунд охинтой нь уулзсан. Би цагдаагийн бүрэлдэхүүнээс түрүүлж очсон. Дунд охин нь шууд таталт өгсөн. Тэр хүүхдүүд үнэхээр аймшгийн зүйл үзсэн. Унтаж байгаа хүүхэд нэг юм унахад л сэрдэг. Тэгэхэд гэрийн хөшиг бүх юм унасан. Тийм аймаар үйлдэл болсон байхад том охин нь миний бага хүүхэдтэй чацуу. Тэгэхээр энэ хүн миний дүүг төдийгүй тэр 3 хүүхдийг хүчирхийлдэг байсан. Ийм учраас энэ хүнд эцэг байх эрх байхгүй. Би 3 хүүхдийг аваад өсгөж чадна. Гэтэл тэр өдөр 3 хүүхэд нь тусламж дуудчихгүй яасан юм болоо гэж харамсаж байна. Гэхдээ би хүүхдүүдийг буруутгахгүй. Насанд хүрээгүй гэрч Д.М мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ: "...өглөө 09 цагт сэрэхэд аав ажилдаа явж байгаа бололтой том өрөөнөөс гараад гал тогооны өрөө рүү орж байсан. Би босоод гал тогоонд орж цай чанах гэтэл гал тогооны хөшиг унасан байсан. Би цайгаа чаначаад ээжийг очиж сэрээх гээд очтол бүсэлхийнээс доош хэсэг нь хөнжилтэй доошоо хараад нүүрэн хэсгээрээ дэрэн дээр дэрлээд хэвтчихсэн. Гарын доорх ягаан гудас цус болчихсон, гар нь хөхөрсөн байхаар нь ээжийн нуруун дээр дараад чичирхийлсэн боловч босохгүй байсан, учир эмээ О-д орж ээж сэрэхгүй байна гэтэл эмээ надтай цуг гэрт орж ирээд ээжийн нуруун дээр дараад босоорой гэсэн боловч ээж босохгүй байсан... 2017 онд аав ээжийг юунаас болсон юм бүү мэд, нэг өдөр зодоод хөлийнх нь орчимд гэмтэл учруулсан байсан..." гэх

мэдүүлэг . Шүүгдэгч Р.Д нь хохирогчид 6.450.000 төгрөг төлсөн, насанд хүрээгүй Д.М, Д.Х, Д.У нарын тэтгэмжийн зөрүүг асран хамгаалагч нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхтэй зэргийг тус тус дурдсан.

**Кейс-5.** Э.Х нь 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Баянзүрх дүүргийн 8 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Дээж” гэх зочид буудалд, үргэлжилсэн үйлдлээр тус сарын 11-ний өдөр Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Говь” гэх зочид буудалд насанд хүрээгүй хохирогч Ү.Нарансолонгыг арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон гэмт хэрэгт холбогджээ. Шүүхийн хэлэлцүүлэгт насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Ү.Наранхүүгийн өгсөн: “... тухайн өдөр орох гэж байсан зочид буудлын ресейпшн Нарансолонгыг “насанд хүрээгүй хүүхэд байна оруулахгүй” гэхэд Х Нарансолонгыг насанд хүрээгүй гэдгийг мэдэж байсан байгаа юм. Тэгээд регистрийн дугаараа өөрчлөөд биччих гэж хэлж байсан байдаг. Нарансолонго бол гаднаасаа харахад л 14, 13 настай харагддаг. Насанд хүрээгүй хүүхдийг орон байраар хангаад согтууруулах ундаа хэрэглүүлээд бэлгийн харьцаанд ороод өдөр шөнөгүй дагуулж яваад, мөнгө олох хэрэгсэл болгосон... ер нь бол гомдолтой байна. Нэхэмжлэх зүйл байхгүй...” гэх мэдүүлэг,

... Нарансолонгыг “насанд хүрээгүй хүүхэд байна оруулахгүй” гэхэд Х Нарансолонгыг насанд хүрээгүй гэдгийг мэдэж байсан байгаа юм. Тэгээд регистрийн дугаараа өөрчлөөд биччих гэж хэлж байсан байдаг. Нарансолонго бол гаднаасаа харахад л 14, 13 настай харагддаг. Б-тэй 2 удаа бэлгийн харьцаанд орсон, надад хүч хэрэглэсэн зүйл байхгүй ...би урьд мэдүүлэгтээ ...би согтуу байсан, бэлгийн харьцаанд орсноо мэдээгүй гэж мэдүүлсэн ...би тухайн үед дотуур байр болон сургуулиасаа хөөгдөөд, мөн ээжийн бие муу байсан тул ах эгч нартаа үнэнийг хэлэхээс айгаад худлаа хэлсэн юм. ...би том ахаасаа айдаг, намайг загнах байх гэж бодоод худлаа хэлсэн байсан. Б-тэй бэлгийн харьцаанд орохдоо миний архи гарчихсан, би өөрийн ухаантай, болсон юмыг мэдэж байсан, бид 2 эхлээд тэврэлдээд, үнсэлдэж байгаад тэгээд бэлгийн харьцаанд орсон, ах, эгч нартаа хэлэхээс ичээд бас айгаад байсан” гэх мэдүүлэг /хх-ийн 157- 158-р тал/, Шинжээчийн 02/0298 дугаартай “...Ц.Б бэлгийн харьцаанд орох чадвартай байна ...бэлгийн харьцаанд орсон байна ...охин халь хуучин урагдалтай байна ...бэлгийн замын халдварт өвчингүй байна” гэх дүгнэлт /хх-ийн 28-р тал/ Ц.Бийн насыг тоолсон “...Ц.Б 2005 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр төрсөн ...2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 14 нас 11 сар 17 хоногтой байна” гэх тэмдэглэл /хх-ийн 42-43-р тал/ Шүүгдэгч О.Б нь бусдад төлөх төлбөргүй,

**Кейс-6.** Шүүгдэгч Ц.Батзаяа нь 2016 оны 10 дугаар сард Төв аймгийн Зуунмод сумын 6 дугаар багийн нутагт байрлах 43 дугаар байрны 2 дугаар орц 28 тоотод байрлах өөрийн гэртээ 15 настай буюу арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй О.Нямбарын хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орсон,

.... насанд хүрээгүй гэрч О.Пүрэвбаярын ...Ц.Батзаяа ах болон О.Нямбаяр эгч хоёрыг гар утсаар мессежээр харилцдаг байсан талаар нь мэднэ... манай эгч О.Нямбаяр гэрт байх

өөрийнхөө хичээл номоо хийдэг шүүгээнээсээ барагцаагаар 40-50 орчим мянган төгрөг гаргаж ирээд надад чи ав гэж өгсөн юм. Тэгэхэд нь би уурлаад хаанаас, хэнээс ийм их мөнгө аваад байгаа юм бэ? ямар учиртай мөнгө юм гэж асуухад чамд ямар хамаатай юм гэж уурлаад зүгээр наад мөнгөө авбал ав гээд өгсөн... /хх-ийн 44-45 дугаар х

“О.Нямбаяр.... ер нь нэг ганцаардмал хүүхэд юм байна гэж би анзаарч байсан юм. О.Нямбаяр нь хотод сүмд явдаг сүмд очихоор сайхан байдаг үнэн юм ярьж байгаа юм шиг гэж байсан. О.Нямбаяр нь надтай нэг өдөр ярилцаад байж байхдаа манай хойд эцэг намайг согтохоороо намайг хажуудаа хэвтүүлэх гээд байдаг, намайг оролддог байсан ба надад хэлэхдээ би зугтдаггүй байсан яагаад гэвэл өөрийнхөө дүүгээ хамгаалах гэж өөрөө бүгдийг үүрч гардаг байсан гэж надад хэлж байсан. ...эссэг уншиж үзэхэд хойд эцэг болон хүргэн ах нарынхаа дур хүслийг хангагч зугаа болсон гэх агуулгатай эссэг бичсэн байхаар нь би сургуулийн сургалтын менежерт эссэг өгсөн юм. ... О.Нямбаяр фэйсбүүк хаяг дээрээ хэрхэн хялбар аргаар амиа хорлох вэ гэх утгатай зургийг фэйсбүүктээ нийтэлсэн байсан. Гэрт байхаар ээж загнаад ширүүн харьцаад байдаг, хойд аав архи уудаг гэх зэргээр ярьдаг болсон. ...миний төрсөн аав надтай байдаггүй ч гэсэн би аавдаа маш их хайртай ганц ч гэсэн уулзах юм сан гэж байсан. Диссоциацийн эмгэгтэй байх нь бусад эмгэг, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

-Эпилепсийн бус таталт. О.Нямбаяр нь гэмт хэрэг үйлдэгдэх үед өөрийн хийж буй үйлдлийг ойлгож, мэдэж, удирдаж чадаж байсан байна. DS: F44,5 Диссоциатив таталт болон F43,25 Сэтгэл хөдлөл, төрх үйлийн өөрчлөлтийн холимог хэлбэр бүхий дасан зохицолтын эмгэгүүд аль аль нь сэтгэл зүйн гэмтлийн улмаас үүсдэг болно...”

F-44 Диссоциатив эмгэг нь эмчилгээний явцад сайжрал авдаг боловч мэргэжлийн ажлаа хийх боломжгүй болсон бол хөдөлмөрийн нөхцөл солих, эмчилгээний явцад сайжрал авахгүй 2 жилээс дээш хугацаагаар, ужиг болсон бол чадвар алдалт 50-60 хувиар нэг жил. Диссоциатив эмгэгийн гол шинж тэмдэг нь бодит байдлаас тасрах байдлаар илэрдэг бөгөөд ийм эмгэгт нэрвэгдсэн хүмүүс бодит байдлаас өөрийн эрхгүй зугтсанаар тухайн шийдэгдээгүй олон асуудлууд нь өдөр тутмын амьдралд нь ноцтой асуудал үүсгэдэг.

**Кейс-7.** Шүүгдэгч М.Эрхэмбаяр нь 2017 оны 11 дүгээр сард Сэлэнгэ аймгийн Шаамар сум Дулаанхаан тосгоны нутаг дэвсгэрт байрлах төмөр замын нүхэн гүүрний хажууд 78-29 УБА улсын дугаартай тээврийн хэрэгсэл дотор арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй /14 нас 4 сартай/ эмэгтэй Б.Энхзаяагийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж хүчээр бэлгийн харьцаанд орж хүчиндсэн,

2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, 2018 оны 3 дугаар сард, 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны нутаг дэвсгэрт Б.Энхзаяаг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байж бэлгийн харьцаанд орсон хэргүүдийг; Шүүгдэгч Э.Лхагвадорж нь 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны нутаг дэвсгэрт 87-12 СЭА улсын дугаартай тээврийн хэрэгсэл дотор Б.Энхзаяаг



арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байж бэлгийн харьцаанд орсон гэмт хэргийг үйлдсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ. насанд хүрээгүй хохирогч Б.Энхзаяагийн хууль ёсны төлөөлөгч Д.Цэцэгээ, хууль ёсны төлөөлөгч Д.Цэцэгээгийн өмгөөлөгч Д.Эрдэнэ-Оргил, Хувийн байдал тогтоогоогүй. Хохирол байхгүй.

**Кейс-8.** Шүүгдэгч М.Эрхэмбаяр нь 2017 оны 11 дүгээр сард Сэлэнгэ аймгийн Шаамар сум Дулаанхаан тосгоны нутаг дэвсгэрт байрлах төмөр замын нүхэн гүүрний хажууд 78-29 УБА улсын дугаартай тээврийн хэрэгсэл дотор арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй /14 нас 4 сартай/ эмэгтэй Б.Энхзаяагийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж хүчээр бэлгийн харьцаанд орж хүчиндсэн,

2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, 2018 оны 3 дугаар сард, 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны нутаг дэвсгэрт Б.Энхзаяаг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байж бэлгийн харьцаанд орсон хэргүүдийг;

Шүүгдэгч Э.Лхагвадорж нь 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны нутаг дэвсгэрт 87-12 СЭА улсын дугаартай тээврийн хэрэгсэл дотор Б.Энхзаяаг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байж бэлгийн харьцаанд орсон гэмт хэргийг үйлдсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ. насанд хүрээгүй хохирогч Б.Энхзаяагийн хууль ёсны төлөөлөгч Д.Цэцэгээ хууль ёсны төлөөлөгч Д.Цэцэгээгийн өмгөөлөгч Д.Эрдэнэ-Оргил, Хувийн байдал тогтоогоогүй. Хохирол байхгүй.

**Кейс хэлэлцүүлэх нь:**

1. Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд сонгож авсан 6-н хэрэгт бүгдэд нь сэтгэл зүйч оролцоогүй, хууль ёсны төлөөлөгч оролцсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хувьд насанд хүрээгүй хохирогч нар нь гэрч, хохирогчоор шүүн таслах ажиллагаанд оролцсон байна. Эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхдээ хохирол болон хор уршгийг иргэний шүүхээр шийдвэрлүүлэхийг шүүхийн шийдвэрт тусгайлан зааж өгсөн байна. Энэ нь нэг талаасаа хохирол болон гэм хорыг бүрэн тооцох нотлох баримт байхгүй байгаатай холбоотой байгаа ч нөгөө талаасаа хохирогч цаг хугацаа алдалгүй эмчилгээ, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй болж өвчин, эмгэг нь даамжрах, хүндрэх, ужгирах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн олон шат дамжлагаас шантарч, иргэний журмаар хэд нь хохирлоо нэхэмжлээгүй вэ гэдгийг мөн харгалзаж үзэх шаардлагатай.
2. Шүүхийн шийдвэрт хүүхдийн эрхийг хангах асуудлыг, ялангуяа хүүхдийн асрамж, хүүхдэд үзүүлэх эмчилгээ үйлчилгээ, хохирлыг улсаас гаргуулахад анхаарах асуудал хөндөгдөж байна.
3. Хохирогч хүүхдийн хувьд сэтгэл зүйн зөвлөгөө ихэнхдээ авалгүйгээр хэрэг хянан



шийдвэрлэх ажиллагаанд оролцсон бол хамгаалах байранд үйлчлүүлэхдээ сэтгэл зүйн зөвлөгөө авсан гэсэн баримт байна. Хохирогч хүүхдийн хувьд сэтгэл зүйн гэмтэл авч, сэтгэцийн эмгэгтэй болсон байдаг тул энэ тал дээр анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байдаг, ямар сэтгэл зүйн зөвлөгөө, засал хийлгүүлдэг, ямар байдалтай үйлчлүүлж эхэлснээс ямар үр дүнд хүрсэн, цаашид ямар эмчилгээ, зөвлөгөө шаардлагатай байгааг тодруулах шаардлагатай байгаа юм. Харин хамгаалах байранд хамрагдаагүй хүүхдийн эрхийг Хууль зүйн хороо хариуцан шийдэхээр байхад энэ тал дээр ямар ажил үйлчилгээ явуулж хүүхдийн эрхийг, хангаж байгааг судлах боломжгүй, мэдээлэл байхгүй байгаа юм.

4. Хүүхдийн эрхийг хангах тал дээр хууль эрх зүйн орчин бүрдсэн байна гэж үзэж байна, харин түүнийг хэрэгжүүлэгч, хангагч байгууллагууд үр дүнтэй, чанартай, хүүхэд төвтэй, хүүхдийн эрхэд суурилсан үйлчилгээг үзүүлж байгаа эсэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байна.

## АНХААРАХ ЗҮЙЛ

Гэмт хэргийн улмаас хүүхдэд бие махбодын хохирлоос гадна, ёс суртахууны, эд хөрөнгийн, санаа сэтгэлийн хохирол учирдаг. Ёс суртахууны хохирол нь тухайн хүүхдийн нэр төрийг нь гутаан доромжлох, сургууль, гэр бүлийн орчинд нэр хүндийг нь унагах, сэтгэлийг нь хямрааж шаналгах хэлбэрээр илэрнэ. Энэ хохирлыг барагдуулж шийдвэрлэсэн талаарх шийдвэр баримт байхгүй байгаа юм. Энэ хохирол нь тухайн хүүхдийн хувь тавилан, цаашдын амьдралтай холбоотой байдаг тул үүнийг хамтад нь шийдвэрлүүлэхээр шүүхийн шийдвэрт тусгах нь хүүхдийн дээд эрх ашигт нийцэх юм.

- Иймд хүүхэд хохирсон хэрэгт сэтгэл зүйн байдлыг тогтоолгохоор шинжээч томилж тухайн дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн хохиролд үнэлэн гэмт хэргийн зүйчлэлийн асуудлыг шийдвэрлэж байх.
- Тухайн хэрэгт оролцох сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч зэрэг олон субъект нь тухайн хүүхэд мэдүүлэг өгөхөд шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг тул заримыг нь зайнаас эсхүл дуу дүрсний төхөөрөмж ашиглан өөр өрөөнөөс оролцуулах боломжтойг анхаарах
- Хүүхэд гэмт хэрэгт өртөж хохирсон эсхүл гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүрд хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагад хандаж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэх ямар тусламж үйлчилгээ шаардлагатайг тогтоолгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулж байх.
- Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнх нь урьд нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй байгааг харуулж байна.
- Нууцлалыг хадгалах. Хэрэг хянан ажиллагаанд татагдан оролцож, сурган

хүмүүжүүлэгч гэсэн статустай болсон багш, нийгмийн ажилтан тухайн хэргийн талаарх мэдээллээс гадна хүүхдийн хувийн байдал, өвчин эмгэг ч юм уу бусад байдлаар хувь хүүхдийн нууцыг хамгаалах хэрэгтэй. Ялангуяа сургуулийн орчинд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн талаар ямар нэг яриа, мэдээлэл гаргахгүй байхад чухалчлан анхаарч, хүүхэдтэй өөртэй нь харилцаа тогтоох, итгэл төрүүлэх, аль болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хөндийрүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

- Зарим эцэг эхчүүд хүүхдээ гэмт хэрэг үйлдсэнийг гэнэт дуулаад өөрсдөө зодож шийтгэхийг урьтал болгодог. Мөн хохирогчдын гэр бүлийнхний зүгээс заналхийлэх явдал ч гардаг. Энэ тохиолдолд хүүхдийн хамгаалуулах эрхийг хангахын тулд нийгмийн ажилтан гэр бүлийнхэнтэй нь ажиллах шаардлагатай. Хүүхэд хийсэн хэргийнхээ төлөө шаналан, ичиж эмээж өөрийгөө өөрөө шийтгэж байхад нь нэрмээс болохгүй байх талаар ойлгуулж, хүүхдийн хүчирхийлэл бол гэмт үйлдэл гэж таниулах нь зүйтэй. Хэрвээ хүүхэд, гэр бүлийн гишүүдийн хооронд энэ мэт зөрчил, маргаан байвал харилцааг сайжруулах, бие биеэ ойлгох боломж олгох зөвлөгөө засал өгөх хэрэгтэй. Мөн хүүхдийн оршин сууж байгаа хорооны хэсгийн байцаагчтай холбоо тогтоож хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй алхам хийж болно.
- Хэрвээ амьдралын элдэв шалтгаанаар хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр томилох хүн байхгүй бол гэр бүл хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хандаж шийдвэрлүүлж болно. Зарим тохиолдолд тухайн хэрэгт магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын ажилтныг төлөөлөн оролцуулж болно. Нийгмийн ажилтны ажил үүргийн хүрээ нэмэгдэж байгаа болохоор хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй болж байна. Гэхдээ нийгмийн ажилтны хийж гүйцэтгэж байгаа ажлаар нь тэднийг сурган хүмүүжүүлэгч гэж тооцож болох тул өнөөгийн хуулийн хүрээнд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч гэж тооцож болох боломжтой.
- Гэмт хэргийн ул мөр дээр хүүхэдтэй ажиллаж байсан сэтгэл зүйчийн туршлагаас хуваалцахад мөрдөгч болон бусад хүнтэй контакт үүсгэхээс өмнө хамгийн түрүүнд сэтгэл зүйчийг тухайн хүүхдүүдтэй уулзуулж, сэтгэл зүйг тайвшруулж, хэвийн болгосны дараа мэдүүлэг авч байх нь хүүхдийн эрхийг хангах үндэс болно гэдгийг онцолж байна. Жишээ нь: 2021 оны 4-р сард нэгэн байрны давхраас ээж нь 3-н хүүхдийнхээ нүдэн дээр цонхоороо үсрээд амиа алдсан. Хүүхдүүд нь араас нь ээжээ гээд үлдсэн. 3-н хүүхэд нь тухайн үзэж харсан хэргийн хувьд гэрч болж байгаа юм. Хүүхдүүд болохоор эрх, хууль ёсны ашиг сонирхлоо мэдэхгүйгээр хэрэгт ач холбогдол бүхий мэдүүлэг өгч, тухайн мэдүүлгийнх нь дагуу эцгийг нь барьж хорьсон тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан. Гэтэл хүүхдүүд ирээдүйд нас биед хүрнэ, юмны учир зүй тогтлыг ойлгож эхэлнэ, тухайн үед өө бид нарын мэдүүлгээс болж аавыг маань шоронд хорьчихсон юм байна гэдэг харуусал төрөх юм. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахын тулд эхлээд хүүхдүүдийг сэтгэл зүйчтэй уулзуулж тайвшруулж, сэтгэл

зүйг нь хэвийн болгож, түүнд хуульд заасан эрх үүргийг нь тайлбарлаж өгсөн бол ирээдүйд гарах хор уршиг багасах юм.

- Мөн бэлгийн хүчирхийллийн хэрэгт хойд эцэгтээ хүчиндүүлж жирэмсэн болсон тохиолдолд хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр төрсөн эхийг тогтооход хохирогч хүүхэд хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөхгүй, өөрөө өөртөө сэтгэл зүйн хаалтыг бий болгодог. Тиймээс хууль ёсны төлөөлөгчийг тогтоох тал дээр мөрдөгч анхаарч мэдрэмжтэй хандах шаардлагатай болдог.
- Гэрч, хохирогчийг хуульд заасан үндэслэлээр хамгаалах байранд авдаг. Ихэнх тохиолдолд төрийн үйлчилгээг төрийн захиалгаар хийж гүйцэтгэх энэ чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд үйлчилгээ үзүүлж байгаа. Хуульд заасны дагуу эдгээр байрнууд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс байрны хаяг, дотоод үйл ажиллагаа нууцлалтай байдаг. Гэрч, хохирогч хүүхдүүд ихэнхдээ удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэл дарамтад байж, улмаар тохироо бүрдсэн үед хохирогч болдог. Сэтгэл зүйн хувьд хэд хэдэн хавсарсан сэтгэцийн эмгэгтэй, сэтгэцийн тулгамдсан асуудал ихтэй байдаг. Ийм хүүхдүүдтэй өдөр тутам ажиллахад мэргэжлийн, мэргэшсэн хүмүүс ажиллах шаардлагатай болдог бөгөөд Австралид хохирогч хүүхдүүдийг асрах газар нь сувиллын газартай төстэй, сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, сувилагч, асрагчаас бүрдсэн багаар энэ үйлчилгээг үзүүлдэг байна.
- Хөдөө орон нутаг, сургууль, ахуйн орчинд ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нэр төрийг хамгаалах, амьдрах нутаг орныг нь солих асуудлыг хуулиар зохицуулсан боловч энэ эрхээ эдэлж чадахгүй давхар хохирсоор байгаа хүүхдүүдийн эрхийг хэрхэн хангахыг хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч болон хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтан, төрийн бус байгууллагууд хуулиар олгосон чиг үүргийнхээ дагуу мэргэшсэн, мэдрэмжтэй, санаачилгатай, хүүхдийн эрхэд суурилсан, хүүхэд төвтэй хандах нэн шаардлагатай.
- Хохирогч хүүхдүүд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, сэтгэл санааны хохирлоо хэрхэн барагдуулах, түүнийг тооцох аргачлал тодорхой бус байгаа, мөн эрүүгийн болон иргэний шүүхээр олон шат дамжлага дамжиж явах нь тэднийг хохирлоо бүрэн барагдуулахад хүндрэл бэрхшээлтэй байгааг дурдах нь зүйтэй юм.

## 2.4. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН АРГА ЗҮЙ

| Хичээлийн нэр                       | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн гол зорилго               | Хүүхэд үйлдсэн болон Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэгээ өргөжүүлж, ойлголтоо нэгтгэнэ.                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| Үндсэн ойлголт ба хураангуй         | <ul style="list-style-type: none"> <li>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий ойлголт, хор уршиг;</li> <li>Гэмт хэргээс урьдчилан төрийн болон төрийн бус байгууллагуудын чиг үүрэг, оролцоо;</li> <li>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрөл хэлбэр;</li> <li>Хүүхдийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил</li> </ul> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| Хичээлийн жишээлсэн хөтөлбөр        | 5 минут                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэ хандлагын талаар оролцогчдоос асууна (багт хуваахаас өмнө)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|                                     | 45 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Бүлгийн ажил: Багийн ажил. Оролцогчдыг багт хувааж дараах мэдээллийг багаар гүйцэтгүүлнэ. Үүнд:<br>Хүүхдийн эсрэг гэмт хэргийн хор уршгийн талаар;<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, оролцоо;<br>Орчин үеийн урьдчилан сэргийлэх арга хэлбэр;<br>Хүүхдийн онцлогт тохирсон арга хэмжээ зохион байгуулах нь ;<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сайн туршлага, шинэ санааг яриулж, хэлэлцүүлнэ.<br>Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох төлөвлөгөө хийж ярилцана. |
|                                     | 15 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Танилцуулга (лекц): Хүүхдийн үйлдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх; Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх РР (Powerpoint) ашиглан тайлбарлана                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|                                     | 5 мин                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Хяналтын асуулт хариулт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| Нэмэлтээр судлан, хэрэглэх материал | <ul style="list-style-type: none"> <li>Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</li> <li>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, 2017, 2018 он. Г.Оюунболд</li> </ul>                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

### СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Орчин үед гэмт хэргийн шалтгаан нөхцөл байнга өөрчлөгдөж, нийгмийн хор аюул нь өсөн нэмэгдэхийн хэрээр түүнтэй тэмцэх арга, хэрэгсэл, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ хандлага, арга барилд шилжихийг шаардаж байна. Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага, алба хаагчдаас сүүлийн 30 гаран жил хэрэглэж ирсэн арга, хэрэгсэл өөрчлөгдөж, шинжлэх ухааны болон нийгмийн бусад салбаруудын мэдлэг, хамтын ажиллагаа илүү ихээр шаардагдах болсон. Иймд хүүхдийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах ёстой.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Хүүхдийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын онцлог юу вэ? Эдгээр ажиллагааг зохион байгуулахад Та юуг хамгийн түрүүнд анхаарах вэ?

2. Хүүхдийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд Та ямар үүрэг гүйцэтгэх вэ?
3. Гэмт явдлыг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэж, тайлбарлана уу. Олон нийт, нийгмийн бүлгүүдийн оролцоог хэрхэн дэмжих вэ?

### СУРГАЛТАД АШИГЛАХ МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ

Хүн төрөлхтөн гэмт явдалтай хууль тогтоомжоор болон төрийн байгууллагын хүч, хэрэгслээр тэмцэж, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замыг судалсаар “криминологи” хэмээх шинжлэх ухаан болтлоо хөгжиж ирснийг бид мэдэх билээ.<sup>20</sup> Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах асуудал онолын түвшинд баяжиж, улам боловсронгуй болж байгаа хэдий ч түүнийг практикт нэвтрүүлэх, үр дүнг ашиглах явдал хангалтгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

*Фэйсбүүк, твиттер гэх мэт нийгмийн сүлжээний хэрэгсэл, аппликэйшнүүд нэмэгдэхийн хэрээр үүнийг дагаад интернетийн хэрэглээ ч нэмэгдэж байна. Улмаар хүмүүсийн мэдээлэл авах хурд, холбоо харилцаа урьд бидний төсөөлж байснаас ихэссэн бөгөөд цаашид энэ нь орчин үеийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн зөвхөн нэг хэсэг болж байна. Тухайлбал 2018 онд цагдаагийн байгууллагаас цахим орчинд явуулсан “Unfreind”, “Эерэг орчин бүрдүүлье”, “Хар жагсаалт” зэрэг аянууд нь үр дүнгээ өгсөнийг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр аян нь хүүхдийн эрхтэй холбоотой хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс сайшаагдаж байв.*

Монгол Улсад өрнөж байгаа техник, технологийн хөгжлийн тусгал, мэдээллийн хурд, сошиал харилцаа зэрэг өөрчлөлт нь янз янзын хүрээтэйгээр явагдахын хэрээр түүнд нийцсэн арга, хэрэгслийг шаардах болно. Иймд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд таамгаар эсхүл урьд явж ирсэн уламжлалт хандлагаар зохион байгуулах нь үр дүнд хүрэхгүй байх талтай.

### ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ:

Гэмт хэргийн шалтгааныг зөв тогтоосноор түүний мөн чанарыг нь илрүүлэх, арилгах арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Үүний тулд гэмт явдлын “шалтгаан”, “нөхцөл”, “хүчин зүйл”<sup>21</sup> гэсэн ойлголтуудыг ялгаж, зөв ойлгох нь маш чухал юм. Шалтгаан бол үр дагавар, үйлдлийг бий болгодог. Шалтгаан, нөхцөл хоёр нь ялгаатай ойлголт боловч, эсрэг тэсрэг ойлголт биш юм. Шалтгаан нь нөхцөлтэйгөө харилцан холбоотойгоор түүнийг дамжин илэрдэг ч шалтгаан, нөхцөлийн хооронд давхцаж байгаа шинж байдаг ч ялгаатай шинж байдаг байна. Харин шалтгаан нь гэмт зан төлөв шууд бий болоход чиглэгдсэн байдаг.

<sup>20</sup> Н.Жанцан “Криминологи” УБ хот, 2004 он, 8-р тал

<sup>21</sup> Н.Жанцан “Криминологи” УБ хот, 2004 он, 44-р тал

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг авч үзэхийн зэрэгцээ түүнд нөлөөлж буй байгаль, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн “хүчин зүйлс”-ийг тооцож үзэх ёстой. Энэ хүчин зүйл нь гэмт хэргийн гаралтад эерэг болон сөрөг нөлөө үзүүлдэг онцлогтой.

Гэмт явдлын гаралтад нөлөөлөх “нөхцөл байдал” нь шалтгаан, нөхцөл, хүчин зүйл хэмээх ойлголтуудаас бас өөр юм. Тухайн үед хэн нэгэн хүнийг гэмт хэрэг үйлдэхэд нөхцөлдүүлсэн тодорхой тохироог хэлдэг.

Тухайлбал дээр дурдсан жишээнд тулгуурлан цахим гэмт хэрэг, ялангуяа цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жин өсөх, гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох, цахим хэрэглээнд хүүхэд донтох эмгэг нэмэгдэх хандлагатай байна.

1. Социологийн эмпирик судалгааны үр дүнгээс үзэхэд, Монгол Улсад цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэл бүхий нөхцөл байдал нэгэнт үүсэж, цахим хэрэглээний соёл, мэдлэг дутмаг, цахим орчны хяналтгүй хэрэглээний улмаас хүүхэд уг гэмт хэргийн хохирогч болох эрсдэл үлэмж нэмэгдэж байна.
2. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, Монгол Улс дахь энэ төрлийн гэмт хэрэг нь тодорхой объектив болон субъектив хүчин зүйлийн улмаас нуугдмал шинжтэй, хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлж, хууль бус үйлдэл хийлгэх, бусдыг дуурайх, цахимаар гадуурхах, заналхийлэх, гадаад улсын иргэд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх чиг хандлагатай болжээ.
3. Судалгаанаас үзэхэд, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь 1) ухаалаг гар утас, цахим төхөөрөмж, интернэтийн хэрэглээ нэмэгдсэн, 2) цахим хэрэглээний соёл, мэдлэг дутмаг, 3) мэдээллийн урсгалд тавих хяналт байхгүй, 4) эцэг, эхийн хараа хяналт, хүүхдэдээ тавих анхаарал сул байдал, 5) эцэг, эхийн үлгэр дуурайлал дутмаг /өөрсдөө цахим хэрэглээнд донтсон/ 6) хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг байна.
4. Эцэг, эхчүүд хүүхэдтэйгээ хамт цагийг өнгөрүүлэх, тэдэнтэй тоглох, зугаалах, ном уншиж өгөх, зөвлөн туслах зэрэг амьд харилцаанаас татгалзсанаар хүүхэд цахим орчинд цагаа өнгөрүүлэх байдлыг бүрдүүлж, улмаар хүүхдийн хүмүүжил, сэтгэхүйд сөргөөр нөлөөлж байна.
5. Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдалтай тэмцэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, хуулиар хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлсэн хэдий ч оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй, мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээгүй, мэргэшсэн албан хаагчдын хүрэлцээ дутмаг байсаар байна.
6. Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ нь нөлөөллийн аян зохион байгуулах, соён гэгээрүүлэх чиглэлийн зарим ажлаар хязгаарлагдаж, энэ төрлийн гэмт хэргийн урьдчилан

сэргийлэх ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн болон хэрэг шалган шийдвэрлэх чиглэлээр цогц байдлаар, үр дүнтэй зохион байгуулагдахгүй байна.

Тодорхой нэг гэмт хэргийн төрөл тухайлбал өмчийн эсрэг болон хүч хэрэглэсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар авч үзье. Хүнд байгалиас заяасан инстинкт нь / animal instinct/ асуудлыг хүчээр шийдвэрлэх хандлага бөгөөд ерөөс хүн бий болсон цагаас амьдралын хэрэгцээ шаардлагын үүднээс шударга бус аргаар өмч хөрөнгө олж авах, бусдыг гэмтээх, зодох, хүчирхийлэх зэргээр хэрэгцээгээ хангаж байв.

Тодруулбал<sup>22</sup> хүнд янз бүрийн хэрэгцээнүүд байх бөгөөд анхдагч хэрэгцээгээ нөхөж байж дараа нь дунд, дээд шатны хэрэгцээгээ хангах (Maslow,1970,1987) ба Маслоу хэрэгцээний шатлалыг дэвшүүлж анхдагч хэрэгцээ нь суурь хэсэгт, дээд хэрэгцээ нь орой хэсэгт байх пирамид байдлаар загварчилсан. Мөн хүн өөрийн суурь хэрэгцээгээ хангах явдал нь эрүүл саруул, сэтгэл хангалуун амьдрах амьдралын гол нөхцөл болдог гэж үзээд амьдралын амин гол хэрэгцээний байнгын хомсдол дутагдал нь хүний биологийн түлхээсийг идэвхжүүлэх ба өөрөөр хэлбэл түрэмгий, харгис хэрцгий зан, уур хилэнг хөдөлгөдөг аж. Хэрэгцээнээс хамаараад гэмт хэрэг үйлдэх сэдэл төрж, түүнийг хэрэгжүүлэх тохиолдол байна.

Судлаачид хүний хэрэгцээг ерөнхийд нь 5 ангилж үзсэн бөгөөд үүнд:

1. Амьдралын амин чухал хэрэгцээ
2. Эд хөрөнгийн хэрэгцээ
3. Нийгмийн хэрэгцээ
4. Оюуны хэрэгцээ
5. Ухаалаг бус хэрэгцээ зэрэг болно.

*Жишээ нь: Хулгайн гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүсийн 12 хувь нь амьдарлын нөхцөл байдлын улмаас хулгай хийж, цаашид энэ үйлдлээ амьдарлын эх үүсвэр болгож байна. /2010.ХЗҮХ/*


Гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлт байгаа хэдий үйлдлийн хувьд улам бүр аюултай шинжтэй болж онц хүнд хэргийн тоо буурахгүй байна.

Гэмт хэрэг гарч буй шалтгааныг тодорхойлохдоо

- А. Хувь хүн, гэр бүлийн ахуй амьдралаас үүдэлтэй
- Б. Нийгмийн орчин нөхцөлөөс шалтгаалсан
- В. Аль алиныг нь хавсарсан гэж ангилж үзэж болох юм.

22 Батболд Ш. Сэтгэл судлал, сонгодгууд. УБ. 2010. 121-р тал.





Нутаг дэвсгэрт гарч байгаа гэмт явдлыг бодитоор тогтоохын тулд албан ёсоор бүртгэгдсэн гэмт хэрэг болон хууль сахиулах байгууллагад бүртгэгдээгүй нуугдмал гэмт хэргийн харьцааг тодорхойлох шаардлагатай.

*Орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл болон цагдаагийн байгууллагаас ирүүлсэн /сүүлийн арван жилийн байдлаар/ гэмт хэргийн нөхцөл байдлын талаар танилцуулгыг судлан үзвэл зөвхөн албан ёсоор бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл, статистикт тулгуурласан байна. Энэ нь тухайн орон нутгийн гэмт явдлын төлөв байдлыг бүрэн илэрхийлж чадахгүй болно.*

Гэмт явдлын тооны болон чанарын харилцааг гэмт явдлын түвшин, хөдөлгөөн, бүтэц гэсэн гурван үндсэн үзүүлэлтээр илэрхийлэн судалдаг.


**Гэмт явдлын түвшин** гэдэг нь түүний тоон үзүүлэлт бөгөөд өөрөөр хэлбэл тайлант хугацаанд тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлт юм. Үүнд нуугдмал гэмт хэргийг авч үзэх нь зүйтэй. Өнөөдөр үйлдэгдээд хуулийн байгууллагад бүртгэгдсэн албан ёсны тоог авч үзэж байгаа ба гэмт явдлын түвшнийг авч үзэхэд нуугдмал гэмт хэргийг давхар тооцож үзэх нь нэн чухал. Энд хүн ам дахь гэмт хэргийн явдлын түвшнийг мянга, арван мянган хүн амд ногдох коэффициентээр гаргадаг нь бусад бүс нутаг, улс оронтой харьцуулах боломжтой болдог.

**Гэмт явдлын хөдөлгөөн** гэдэг нь гэмт хэрэг, зөрчлийн өсөлт, бууралтыг ойлгож болно. Тухайлбал, өмнөх онуудтай, эсвэл өмнөх оны мөн үеийн түвшинтэй, өмнөх саруудын түвшинтэй харьцуулах замаар гэмт хэрэг, зөрчлийн хөдөлгөөнийг илэрхийлж, өссөн, буурсан талаарх тоон үзүүлэлтийг гаргадаг.

**Гэмт явдлын бүтэц** гэдэг нь гэмт явдлын төрөл, ангилал, зарим онцлогийг хамруулан ойлгож болно. Тухайлбал гэмт хэргийн төрөл, үүнд хулгайлах, бусдын бие махбодод

гэмтэл учруулах, танхайрах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зэрэг гэмт хэргийн тоо, тэдгээрийн эзлэх хувийн жинг харуулдаг. Гэмт хэрэг үйлдэгдсэн зарим онцлогийн тухайд насанд хүрээгүй болон эмэгтэй хүмүүс оролцсон, архидан согтуурсны болон гэр бүлийн хүчирхийлэл, маргааны улмаас, мөн бүлгээр, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тэдгээрийн хувийн жин, хөдөлгөөнийг харуулж болно.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулах гэмт хэргийн суурь судалгаа нь дараах бүтэцтэй байж болох юм.Үүнд:



**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нь:** Орчин үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллага тэр дундаа орон нутгийн өөрөө удирдах байгууллагын дэмжлэг туслалцаа хамгийн ихээр шаардах болжээ. Зөвхөн хууль сахиулах байгууллагын хүчээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, найдаад орхих нь буруу бөгөөд цаашид салбар зөвлөл нь орон нутгийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэх төдийгөөр ГХУАС33-д ирүүлдэг нийтлэг дутагдал байна.

Энэ нь салбар зөвлөлүүд дан ганц цагдаагийн байгууллагын хийсэн үйл ажиллагааг ирүүлж байгаа мэтээр харагдаж байгаа шинэлэг арга барилаар хандахгүй, санаачилга бүхий үйл ажиллагаа дутсантай холбоотой байна.

Салбар зөвлөл нь дараах субъекттэй хамтран ажиллана: Үүнд

- Цагдаагийн байгууллага
- Прокурорын байгууллага
- Төрийн захиргааны байгууллага
- Төрийн бус байгууллага
- Их сургууль, дунд сургууль

Иргэдийн хурал нь

- Засаг дарга
- Засаг даргын Тамгын газрын харьяалагдах салбар байгууллагууд
- Хуулийн хэлтэс
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Нийгмийн халамжийн газар
- Байгаль орчны хэлтэс, газар
- Мэргэжлийн хяналтын хэлтэс газар
- Татварын хэлтэс
- Боловсролын хэлтэс, нэгж
- Зам тээвэр хариуцсан хэлтэс, мэргэжилтэн


Зөвлөл, салбар зөвлөл тухайн жилдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргахын өмнө энэхүү гарын авлагын нэгдүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах ажлыг нэн тэргүүнд хийж гүйцэтгэсэн байх ёстой. Үүний дараагаар гарын авлагын хоёрдугаар бүлэгт заасан үндсэн бодлогоо боловсруулсны үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд зохион байгуулна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс цаашид барьж буй чиглэл нь:

1. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бодитой судалж тогтоох
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг судалгаанд үндэслэх
3. Орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөл, цагдаагийн байгууллагууд нь харилцан дэмжлэг туслалцаа авах хэлбэрээр үйл ажиллагаагаа уялдуулах
4. Орон нутагт урьдчилан сэргийлэх бодлого, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхдээ иргэний нийгэм, олон нийтийн туслалцаа дэмжлэгийг чиглэлтэй авах зэрэг байна.

Дээр дурдсан чиглэл нь заавал тогтсон хэлбэр биш бөгөөд ерөнхий чиглэл гэдгийг анхаарвал зохино. Үүнд дээр тухайн орон нутгийнхаа онцлогийг харгалзан тодорхой бодлого нэмж болно. Жишээлбэл: Танай аймаг, дүүргийн хэмжээнд түгээмэл гарч байгаа хүч хэрэглэсэн гэмт хэрэг үүнд бусдын бие махбодыг гэмтээх, танхай, дээрэм, булаалтын хэргүүдэд судалгаа хийгээд үүний гол шалтгааны талаар танилцуулгыг

ирүүлсэн байлаа хэмээн төсөөлье. Тэгвэл салбар зөвлөл нь аймгийн хэмжээнд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахдаа хамгийн түрүүнд боловсролын болон хот тохижилтын алба нэгийг татан оролцуулахаар төлөвлөж болно. Учир нь дээрэм болон танхайн гэмт хэрэг нь танай аймагт сургуулийн орчинд их гардаг, түүнчлэн гудамж талбайн гэрэлтүүлэг муугаас шалтгаалсан нь хамгийн их байгаа тохиолдолд дээрх байгууллагуудын дэмжлэг туслалцааг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулахаар шийдвэрлэх хэрэгтэй юм.



- Онцгой объект
- Цагдаагийн хүчний хуваарилалт
- Хаягжилт
- Орон нутгийн хил
- Эргүүлийн замчлал
- Хөдөлгөөн
- Хот

Газар нутгийн байршлыг цаг хугацааны болон орон зайн нөхцөл байдалтай нь уялдуулан, гэмт хэрэг, зөрчил, гарах нөхцөл, магадлалыг зөв тодорхойлж, цагдаагийн хүч хэрэгслийг оновчтой хуваарилан гарч болох эрсдэлийг бууруулах Эрсдэлийн удирдлагын мэдээллийн системийг байгуулна.

Аймаг, хотод эрсдэлийн удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлснээр:

- Гэмт хэргийн гаралт -15% буурна.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн +30% дээшилнэ.
- Иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

**Олон талт хамтын ажиллагаа:** Гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөгчийн зүгээс ерөнхийдөө хэрэглэдэггүй татварын, хөдөлмөрийн гэх мэт хууль тогтоомжийг ашигладаг бусад байцаагч, хуулийн ажилтнуудтай хамтран ажиллах тактикийг олон талт ажиллагаа гэдэг. Энэ ажиллагааны хамтрагчид нь:

- Олон нийтийн байцаагч;
- Хилийн болон гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн албаны ажилтан;
- Гаалийн ажилтан;
- Гадаад харилцаа, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөлмөрийн улсын байцаагч;
- Гал түймэртэй тэмцэх албаны ажилтан;
- Орон нутгийн байгаль орчны болон эрүүл мэндийн ажилтнууд;
- Нутгийн захиргааны байгууллагын ажилтан;

- Зам тээврийн байгууллагын ажилтан ;
- Хохирогчид тусламж үзүүлэх ажилтан;
- Хэвлэл, мэдээллийн ажилтан нар байна.

Тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулж байдаг хууль тогтоомжийг судалж үзээд ямар байгууллагатай хамтран ажиллахаа сонгох хэрэгтэй. Тухайлбал: Татварын, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай, ашигт малтмалын, хөдөлмөрийн, бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг дээр тухайн баар, цэнгээний газрын зөвшөөрлийг хураан авч үйл ажиллагааг нь зогсоох, ашгийн төлөө байгууллага эсэх, тийм бол татвараа үнэн зөвөөр мэдүүлж төлдөг эсэх. Хэрэв тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг бол тусгай зөвшөөрөл нь хууль ёсны эсэх, галын аюулгүй ажиллагааны дүрмийг зохих ёсоор мөрдөж байгаа эсэх, аюулгүйн гарцтай эсэх, гал унтраах багаж хэрэгсэлтэй, тэдгээр нь ажиллагаатай эсэх гэх мэтээр шалгалт явуулах нь үр дүнтэй.

Олон талт ажиллагааны хүрээнд хамтарч хийсэн шалгалт, нэгдсэн арга хэмжээ нь үр дүнтэй таслан зогсоох арга хэмжээ болж чаддаг. Галын болон байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааг зогсоох боломжтой болдог. Дээр дурдсан бүх үйл ажиллагааны үр дүнд тодорхой хэмжээний санхүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд тухайн гэмт хэргийн объектыг /жишээлбэл сауны газар, зочид буудал гэх мэт/ зорилгоор ашиглах боломжуудыг хааж өгдөг. Ингэснээр гэмт хэрэг үйлдэх арга, хэрэгслийн өртөг өсөж, түүнээс олох ашиг буурдаг.

**Захиргааны арга хэмжээ авах:** Тодорхой үйлдэл нэг бүрийг шалган тогтоож, хянах чиг үүрэг бүхий ажилтнууд нь илэрсэн зөрчил бүрд тохирсон арга хэмжээ авч зохих хариуцлагыг хүлээлгэж байх, захиргааны зөрчлийн нэгдсэн сан байгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын саналыг авч, энэ төрлийн мэдээллийн бааз, судалгааны байгууллагыг байгуулах чиглэлийг баримталж ажиллах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дараагийн алхам юм. Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг этгээд хэдэн удаа захиргааны зөрчил гаргаж, арга хэмжээ авагдсаныг мэдэх арга байхгүй байгаа юм.

**Төрийн бус байгууллагатай харилцах:** Салбар зөвлөлөөс төрийн бус байгууллагатай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж болох бөгөөд үр дүнтэй байх дараах аргууд байна.

**Тодорхой ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх:** Салбар зөвлөлийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай зарим ажлыг хуулийг байгууллагаас оролцох, биелүүлэхэд хүндрэлтэй тохиолдолд тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр төрийн бус байгууллагуудын дэмжлэг туслалцааг авч болох юм. Ингэхдээ хуульд заасны дагуу сонгон шалгаруулалт зарлан авна. Үүнд насанд хүүхдийг суралцах боломжийг хангах, хүчирхийллээс ангид байх зорилгоор төрийн бус байгууллагыг оролцуулж болох бөгөөд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ нь хэд хэдэн аймагт энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрч байгаа жишээ байна.

**Хуульд заасан үүргээ биелүүлэхийг нь шаардах:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар байгууллага тодорхой үүрэг хүлээсэн байдаг. Тиймээс хуулийн зүйл, хэсэгт үндэслэн байгууллагадаа эрх зүйн дэг журам сахиулах, үйл ажиллагааг хянахаар тодорхой үүрэг өгч хянаж болох юм.

**Сайн дурын зохицуулалтын аргыг ашиглах:** Орчин үед сайн дурын байгууллага байгуулахыг нийгэм нь дэмжиж, эрх зүйн орчны хувьд зөвшөөрөх ёстой юм. Үүнд жишээ дурдвал 1975 онд байгуулагдсан Байгаль орчныг хамгаалах холбоо нь нийт 390 гаран гишүүн байгууллага, 21 аймаг 9 дүүрэгт нийтдээ 34 салбартай, олон тооны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг туршлагатай учраас Байгаль орчны журмын эсрэг гэмт хэргийн чиглэлээр хамтран ажиллаж, дэмжлэг авч болно.

Нийгмийн хариуцлага биелүүлэхэд нь хамтран ажиллахдаа тухайн байгууллагын нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг хэрэгжүүлэхэд дэмжиж, тодорхой урамшуулал өгч, орон нутагт ГХУСА-д татан оролцуулдаг.

**Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба урьдчилан сэргийлэх ажил.** Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь одоо үед мэдээлэл дамжуулах гол эх сурвалж гэдэгтэй хүн бүр санаа нэгдэнэ. Насны хязгаар, газрын байршил зэргээс үл хамааран мэдээллийн хормын дотор түгээх боломжийг бүрдүүлж байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлог юм. Энэхүү асар хурдацтай хөгжиж буй хэрэгслээр дамжуулан бид “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”-д ашиглах нь бодит эерэг үр дүнд хүргэх бүрэн боломжтой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг дараах 4 төрөлд ангилан үзэж болохоор байна Үүнд:

1. Радио
2. Сонин
3. Телевиз
4. Интернет

Хууль бус зар сурталчилгаа, мэдээллийн байдалд хяналт тавьж, аюулгүй байдлыг хянах чиг үүрэг бүхий байгууллага байхгүй нь гэмт хэрэг гарах хамгийн гол нөхцөл болж байна. Дараах байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч ажиллана. Үүнд:

- Хууль бус зар сурталчилгааг хянах, гаргуулахгүй байх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх постер, контент гаргуулах
- Гэмт хэргийг сурталчлахгүй байх
- төрийн байгууллага зохицуулалт хийж, эцэг эх, интернет үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах
- Садар самуун, бие үнэлэлт шинэ хэлбэрт буюу шилжиж цахим орчинд шилжиж байгаатай холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудад сургалт явуулах
- Урамшуулан дэмжиж, хамтран ажиллах
- Шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах

**Цагдаагийн PR:** Өнгөрсөн нийгмийн тогтолцоонд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хүн амын идэвх санаачилга, нам эвлэлийн удирдлага, үйл ажиллагаа, аж ахуй, үйлдвэрийн байгууллагуудын хөдөлмөрийн сахилга бат дээр тогтож байсан учир төрөөс явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого чиглэл дээрх хүчин зүйлсэд үндэслэж байсан. Сонор сэрэмжтэй үлгэр жишээч ажиллаж байсан иргэдийг үнэмлэх, тэмдгээр шагнаж, цол тэмдэг олгох болон нийгэм хамт олны хүрээнд уриа лоозон дэвшүүлж ажиллах зэргээр ихэвчлэн үзэл суртлын шинжтэй үйл ажиллагаа дээр суурилж байжээ. Харин өнөө үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь санхүү, материаллаг сонирхол, боловсон хүчин, мэдээлэл, шинжлэх ухаан арга зүйн хангамжийн үндсэн дээр явагддаг болох нь бусад орны цагдаагийн байгууллагын жишгээс харагдаж байна.

Тухайлбал, дээрх цагдаагийн байгууллагаас гаргасан постер нь *“Хүүхдээ буруу хийвэл цагдаагийн ажилтан шоронд хийнэ гэж битгий айлгаж байгаач ээ. Аюул тохиолдсон үед бид тэдэнд туслахыг хүсэж байна”* гэсэн агуулгатай байна. Олон нийтэд гарт баригдаж, нүдэнд үзэгдэхүйц ийм энгийн арга дүнтэй байдаг төдийгүй цагдаагийн нэр хүндийг илтэд өсгөдөг.



Гэтэл манайд цагдаагийн олон нийттэй харилцах алба хэвлэл мэдээллээр сэрэмжлүүлэг явуулахдаа хуучин аргаар ажиллаж, зохиож байгаа аян нь торгож шийтгэх талаар анхааруулсан өнгө аястай байгаа нь энэ ажлыг улам гажуудахад хүргэдэг. Угтаа иргэн цагдаагийн хоорондын харилцааг эерэг хандлага руу шилжүүлэх хэлбэр манайд эсрэгээрээ болоод байна уу даа гэж харагдаж байна.

Жишээлбэл цагдаагийн зохиож байгаа аян нь согтуу хүнийг торгож, эрүүлжүүлэх биш тодорхой тохиолдолд гэрт нь хүргэж өгөх талаар байвал энэ иргэдээс “өндөр оноо” авахад ач холбогдолтой. “Бүс”, “Согтуу жолооч” гэх мэт нэртэй зохиож байгаа арга хэмжээнүүдээс харвал иргэдэд зааж зөвлөхөөс илүү тухайн өдөр олон зөрчил илрүүлж шийтгэх хэлбэртэй байгаа нь цагдаагийн PR-ийг сөрөг чиглэлд аваачиж байна.



Зөвхөн нэг ийм агуулгатай самбар өлгөж, иргэдэд яг өөрсөд нь зөвлөхөд чиглэсэн аян зохиоход л цагдаагийн үйл ажиллагааны талаар эерэг төсөөлөл богино хугацаанд 20 хүртэл хувиар нэмэгддэг тооцоог криминологчид гаргасан байх юм. Онол гэхээсээ илүү цагдаагийн PR-ийн чиглэлээр хэрэгжиж байгаа зөвхөн нэг үр дүнтэй аргыг дурдахад ийм байна. Угтаа нь нэг хэлбэрийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аргад хамаарна.

**Иргэдийн хуралт, засаг даргын оролцоо:** Монгол Улсын Үндсэн Хуулийн “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага” гэсэн дөрөвдүгээр бүлэгт Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж, түүний удирдлага, тэдгээрийн эдлэх эрх, гүйцэтгэх үүргийг тодорхойллоо. Үндсэн хуулиар “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ” гэж заажээ.

ИТХ, Засаг дарга нар нь төрийн удирдлагыг тухайн орон нутагт хэрэгжүүлэх гол хүн учраас түүний эрх, үүрэг нэлээд өргөн хүрээтэй.

Ийм учраас Засаг дарга өөрийн орон нутагтаа доорх арга хэмжээ авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлага гарч байна. Үүнд:

- Ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөл нь ажилгүйдэл, ядуурал, архидалттай холбоотой учраас энэ төрлийн арга хэмжээ авах шаардлагатай. Жишээ нь: хот суурин газарт төрөл бүрийн компьютер тоглоомын газруудын ажиллах журмыг боловсруулж, дүрэм журмаа мөрдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, төр, захиргаа, хууль хяналтын байгууллагууд болон төрийн бус байгууллагуудаас архидан согтуурахтай тэмцэл хийх арга, журмыг боловсронгуй болгох, тэмцлийн үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээ авах. Шөнийн цэнгээний газрыг эрт хаалгадаг журам гаргасан ч хүмүүс гэр эсвэл буудалд архидах явдал нь улам ихэсдэг нь нотлогдоод байгаа учраас энэ тал дээр уян хатан нарийн журам зохицуулалт шаардлагатай байна.
- Орон нутагт байгаа ажилгүй хүмүүсээ орлогын эх үүсвэртэй болгох шаардлагатай. Монгол Улсад шинээр уул уурхай, ашигт малтмалын орд газрыг түшиглэн орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд байгаа тул тэдгээр аж ахуйн нэгжид гадаадын ажиллах хүчнээс илүү өөрийн орон нутгийн хүмүүсийг татан оруулах боломж байгаа тул энэ тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй.
- Хууль сахиулах байгууллага буюу цагдаагийн байгууллагын хүч, чадавхыг дээшлүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээ авах. Үйл ажиллагааг нь дэмжих, тэдний хийсэн ажлыг орон нутагтаа танилцуулах, иргэдэд хууль сурталчлах, дан ганц цагдаагийн байгууллагын ажил гэж орхигдуулах биш тэд нартай хамтарч ажилладаг байх хэрэгтэй.

- Хүн амын шилжилт хөдөлгөөн. Иргэдийн хаягийн бүртгэл, мэдээллийн лавлагаа, орон сууц, гудамж талбайгаа хаягжуулах.
- Хараа хяналтгүй гэх хүүхдүүдийг иргэний бичиг баримттай болгох, гэмт хэрэг, хэв журмын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, сургуул завсардлыг арилгах зэрэг асуудлыг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

**Хуулийн хэлтэс ба хууль сурталчлах:** Орон нутгийн Засаг даргын дэргэдэх Тамгын газрын хуулийн хэлтсийн Иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өөрийн орон нутагтаа зохион байгуулах ажил юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага, иргэд гэсэн 2 үндсэн субъектэд хандан ажиллах болно.

Иргэдэд хандсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулж болох талаар:

- Иргэдэд хууль сурталчлах гэхдээ энэ ажлыг тодорхой тохиолдол, орчинд явуулах. Тухайлбал: Гэмт хэрэг гарч буй орчин
  - Гэр бүлийн хүрээнд
  - Орон сууцны орц, хонгилд
  - Гудамж, талбайд
  - Албан газар
  - Баар, цэнгээний газар
  - Зах дээр
  - Тээврийн хэрэгсэл, үйлчилгээний газар
  - Хөдөө хээр
  - Янз бүрийн газар гарч байна.
- Иймд эдгээр орчин тойрны онцлог шинжийг харгалзан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээгээ зөв сонгон авч ажиллах шаардлагатай.
- Иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх ажлыг байнга хийснээр энэ талын ажлын гол зорилго оршино. Учир нь: хүмүүс мөнгөний төлөө амьдрах болж, мөнгө олохын тулд ёс суртахуунаа уландаа гишгэж, эрх чөлөөгөө эдлэх нэрийдлээр бусдын эрх ашгийг хохироох, бусдын өмнө хариуцлага хүлээхийг үл хүсэх нь өнөөгийн нийгмийн сэтгэл зүйн тогтсон хандлага болсон гэлтэй.
- Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх.
- Иргэдийг дахин хохироохгүйн тулд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нь барагдуулж болох хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай.
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах. Энэ нь цэцэрлэгийн хүүхдээс авхуулаад ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг гэж юу болох, түүний үр дагавар,

үүсэх гарз, хохирлын талаар ойлгуулж өгөх хэрэгтэй. Дан ганц эдгээр хүүхдүүд биш гудамжны гэх тодотголтой хүүхдүүдэд энэ талын мэдлэгийг олгож зөв боловсон хүн болон нийгэмшихэд нь туслах хэрэгтэй.

Иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх төв нь энэ талын үйл ажиллагааг хийхэд хүндрэл бэрхшээлтэй байвал мэргэжлийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас зөвлөгөө, зааврыг авч хамтран ажиллаж болно. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь нүсэр үйл ажиллагааг шаардсан байдаггүй зөвхөн таниулах, сурталчлах, ойлгуулах буюу мэдүүлэх гэсэн чиглэлийн ажил байдаг. Энэ талаар иргэд, олон нийтэд ойлгуулж байх нь л хамгийн чухал. Сурталчлах, таниулах, ойлгуулах ажлыг хийхдээ эхлээд хамгийн их ам төвлөрсөн хот суурин газраасаа дараа нь сумд, хороод руу чиглэсэн үйл ажиллагааг хийх шаардлагатай. Дээрх ажлуудыг хийхэд айхтар их төсөв мөнгө орохгүй харин энэ ажлыг хийх хүсэл эрмэлзэл, зорилго байхад болох болно.

Иргэд болон цагдаагаас бусад байгууллагын оролцоонд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Үүнд

- Олон нийтийн эрх зүйн ухамсарт чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг байх. Нийгэмд чиглэсэн, олон нийтийн баясаж цэнгэх урлаг, соёл, спортын чиглэлийн ажиллагаа нь иргэдийг нийгмийн идэвхтэй болгодог, цаашлаад цагийг зугаатай өнгөрүүлэх, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байхад чухал хувь нэмэр оруулдаг.
- РС тоглоомын газрууд, баар цэнгээний газруудын үйл ажиллагаанд зохих хяналт тавьж тоог нь цөөлөх, хууль зөрчин шөнийн цагаар ажиллахгүй байх зэрэгт анхаарах
- Хууль сахиулагчийн харилцаа, мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх, ажил үүрэгтээ үнэнч хариуцлагатай ханддаг болгох

*Идэвхтэй сургалтын зорилго нь заахад бус  
сурахад нь тусалж дэмжихэд оршино.*

### 3.1. АНДРАГОГ СУРГАЛТ ГЭЖ ЮУ?

Насанд хүрэгчдийг сургах, тэднийг сурах арга зүйд суралцахад нь дэмжих идэвхтэй сургалтын арга юм. Андрагог нь бие даан суралцах, хэн нэгнээр заалган суралцахын ялгааг тайлбарлана. Андрагог сургалт нь суралцагч төвтэй байдаг. Энэ нь тэдний / насанд хүрэгчдийн/ дараах онцлог хэрэгцээнд суурилах ёстой. Үүнд:

- Биеэ даасан
- Амьдралын туршлага мэдлэгтэй
- Зорилгоо баримжаалсан
- Прагматик
- Хүндэтгэл, хүндлэлийг шаардсан

Насанд хүрэгчдийн боловсролын онол буюу Малколм Ноүлсийн / Malcolm Knowles/ онолын 4 аксиом :

- Насанд хүрэгчдийг сургалтын төлөвлөлт, үнэлгээний үйл явцад оролцуулах
- Суралцах туршлага эзэмшүүлэх
- Насанд хүрэгчдийн сургалтын хамгийн сонирхолтой сэдэв нь тэдний эрхэлж буй ажил, амьдралтай нь холбоотой асуудлууд байх
- Насанд хүрэгчдийн сургалт нь агуулга бус асуудал төвтэй байх

Иймээс насанд хүрсэн суралцагчийг аль болох өөрийг нь сургалтын бүх процесст оролцуулж байх нь чухал юм. Учир нь тэд бие даасан хэрэгцээг чухалчилдаг. Тухайлбал,

- Сургалтын бүхий л үйл явцад оролцуулах
- Сургалтын аль нэг хэсэгт чиглүүлэгч байх боломж олгох
- Суралцагчийн сонирхлыг таньсан, харгалзсан байх

Тэд амьдралын туршлага мэдлэгтэй тул дараах зүйлд анхаарах шаардлагатай. Үүнд:

- Суралцагчийн ямар чадвартай, юунд илүү чадварлаг болохыг таньсан байх
- Суралцагчийн туршлага, мэдлэгээ бусадтай хуваалцах боломж олгох

Тэд зорилгоо баримжаалсан байдаг. Иймд тэдэнд зориулсан сургалт дараах зүйлсийг сургагчаас шаардаж байдаг.

- Сайтар зохион байгуулалттай байх
- Нарийвчилсан зорилго, зорилттой байх

Мөн тэд илүү прагматик тул тухайн сургалт суралцагчийн ажил үйлс, амьдралд нь хэрэгтэй, ашигтай гэдгийг ойлгуулах нь чухал. Насанд хүрсэн суралцагч ямагт хүндэтгэл, хүндлэлийг хүсэн хүлээж байдаг. Иймээс сургагч багшид дараах шаардлага тавигддаг. Үүнд:

- Суралцагчийн мэдлэг, туршлагыг хүндлэх
- Суралцагч, чиглүүлэгч аль аль нь ижил түвшнээс харилцах

**Насанд хүрэгчдэд шинэ мэдээлэл, мэдлэг олгох арга хэлбэр:**

- Сонирхолтой РР,
- Лекц, яриа таниулга,
- Хэлэлцүүлэг
- Видео, дүрс бичлэг,
- Кино,
- Олны танил хүмүүсийн яриа,
- Тараах материал

**Насанд хүрэгчдийг идэвхжүүлэх арга:**

- Ярилцах
- Бүлгээр
- Ганцаарчилсан
- Тоглоомууд
- Танилцах
- Мэдээлэл солилцох
- Дуулуулах
- Хамгийн хамгийн шалгаруулах

**Насанд хүрэгчдийг хөгжүүлэх арга:**

- Асуудал дэвшүүлэх
- Санал бодлоо илэрхийлэх
- Мэтгэлцэх
- Багаар ажиллах
- Төсөл боловсруулах
- Шийдвэр гаргах

**Хувь хүнийг нээх арга:**

- Өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах
- Өөртөө үнэлгээ хийх
- Алдаа дутагдал болон оновчтой сайн үйлээ бичих
- Сайн ба муу талаа тодорхойлох
- Алсын зорилгоо тодорхойлох
- Ойрын болон дундын зорилгоо тодорхойлох
- Хүсэл, мөрөөдлийн тухай ярилцах
- Бага насны хөгжилтэй дурсамжууд болон амьдралын хамгийн сайхан мөчөө эргэн дурсах
- Авьяасаа үзүүлэх

Эх сурвалж: Б.Оюун-Эрдэнэ, Х.Баавгай. Насанд хүрэгчдийн сургалтын онцлог. Илтгэл 2020 он.

### 3.1. СУРГАГЧ БАГШ НАРТ ЗАЙЛШГҮЙ БАЙХ УР ЧАДВАР

#### Сургагч нарт зайлшгүй шаардлагатай ур чадварууд

##### 1. Судалгаа шинжилгээг дээд түвшинд хийх ур чадвар

Сургагч нарын зайлшгүй суралцах хамгийн чухал ур чадвар бол интернэтээр хайлт хийх чадвар юм. Тэр дундаа илүү дээд түвшний, аналитик судалгаа хийх чадвар юм.

Жишээлбэл, хайлт хийхдээ Boolean operators тэмдэглэгээг хэрхэн ашиглахаа мэдэх үү? Мэдэхгүй бол “and”, “or”, “not” гэсэн тэмдэглэгээнүүдийг ашиглах чадварт суралцаарай. Мөн хашилт “”-г ашиглаж сураарай. Энэ мэтчилэн дээд түвшний хайлтад суралцсанаар үр дүнгээ нарийвчилж, дэлгэрүүлж сурна. Бидний зорилго бол сургалтад ашиглагдах холбоотой хамгийн найдвартай агуулгыг олох юм.

Мэдээжийн хэрэг хамгийн чухал сургагчийн ур чадвар бол судалгааны баримтыг үнэлдэг шиг мэдээллийн вэбсайтыг үнэлэх, баталгаажуулах чадвар юм. Вэбсайтын хамгийн доод талд “хамгийн сүүлд шинэчлэгдсэн” огноог шалгаж вэбсайт баталгаатай эсэхийг шалгаарай.

##### 2. Харилцааны хүчирхэг чадвар

Дэлхий ертөнц дээрх хамгийн чанартай судалгааг хийж, хичээлээ бэлтгэсэн ч сургагчийн ур чадвар байхгүй бол үр дүнтэй сургагч багш болж чадахгүй. Суралцагчдад мэдээллийг хүргэх, ур чадварыг эзэмшүүлэхийн тулд шаардлагатай сургагчийн хамгийн чухал ур чадвар бол харилцааны ур чадвар юм.

Сургагч багш гол санаагаа хангалттай сайн тайлбарлахгүй байна гээд төсөөлөөд үзээрэй? Эсвэл сургалтад хамрагдаж буй сурагчид огт анхаарал хандуулахгүй байна гээд боддоо? Эдгээр нь сургалтын явцад тохиолддог томоохон саад бэрхшээл юм.

Тиймээс урам зоригтой, сонирхолтой сургагч байхын тулд сонсох, асуулт асуух, тайлбарлах, санал хүсэлт гаргах чадвартай байх хэрэгтэй. Эдгээр ур чадварыг тогтмол сайжруулж байх хэрэгтэй.

##### 3. Чөлөөтэй зохион байгуулах чадвар

Сургалтын бизнесийн талаарх хамгийн тодорхой баримтуудын нэг бол та хүссэн бүх зүйлээ нэг дор бүгдийн хэзээ ч авч чадахгүй. Цаг хугацаа, хөрөнгө мөнгө, нөөц баялаг аль ч байлаа чөлөөтэй зохион байгуулах чадвар хэрэгтэй болно.

Стресс болон цаг хугацааг удирдах чадвар таныг тайван, бүх зүйлийг хяналттай байлгахад тусална. Ажлуудаа зохицуулахдаа цаг хугацаа, хүчин чармайлтаа хэмнэж чадна. Өөр нэгэн үр дүнтэй сургагчийн ур чадвар эмх цэгцтэй асуудлыг шийдвэрлэх юм. Асуудлыг барьж авалгүйгээр засаж залруулж чадах юм бол маш сайн сургагч болж чадна.



#### **4. Насан туршдаа суралцах хүсэл эрмэлзэл**

Сургагч багш нар хэзээ ч суралцахаа зогсоодоггүй. Сургалтын салбарын нэг хэсэг болсон бол насан туршдаа суралцах зуршлыг хөгжүүлэх шаардлагатай болдог.

Үүний нэг шалтгаан бол суралцах арга хэрэгсэл, сургалтын трендийн цаг үе тутамд өөрчлөгдөж байдаг билээ. Сургагчид өөрийн арга хэрэгслээ ч мөн тогтмол өөрчилж байх хэрэгтэй байдаг.

Заримдаа бид өдөр тутмын ажилдаа дарагдаад шинэ зүйл сурах аргаа мартчихдаг. Үр дүнтэй сургагч багш болохын тулд суралцагсдынхаа хэтийн төлөв, хэрэгцээ шаардлагыг мэддэг байх шаардлагатай.

Суралцагчдын өөр өөр сэтгэл хөдлөлийг мэдэрч байвал тэднийг холбох нэгтгэх, хамруулах сургалтын хөтөлбөрийг бий болгох нь үр дүнтэй байдаг.

Суралцахаа хэзээ ч битгий зогсоогоорой.

#### **Сургагч багш нарт зайлшгүй шаардлагатай сургалтын хэрэгслүүд**

Сургалтын хэрэгсэл гэж юу вэ?

Сургалтын хэрэгсэл гэдэг нь сургагч нарын сургалтаа үр дүнтэй явуулахад шаардлагатай темплэйт, платформ, программуудыг хэлнэ.

Тиймээс дараах хэрэгслүүдийг санал болгож байна:

##### **1. Контент хянах хэрэгсэл**

Сургалт хөгжлийн хамгийн чухал хэрэгслүүдийн нэг бол контент хянах хэрэгсэл юм. Хяналтын хэрэгсэл нь сургагч багш нарт интерактив сургалтын орчныг бий болгохын тулд олон төрлийн медиа ашиглах зориулалттай программ хангамжийн платформ юм. Зарим хэрэгслүүд үйл явцыг хурдасгах зориулалттай байдаг.

Ашиглахад хялбар контент хяналтын хэрэгсэл сонгохдоо сургалтын менежментийн хэрэгслүүдтэй тохирох онцлог шинжтэй байх хэрэгтэй. Таны сонгосон сургалт хөгжлийн хэрэгслүүд суралцагсдын ерөнхий динамиктай тохирох хэрэгтэй.

##### **2. Видео засварлах программ хангамж**

Сургагч багш нарт зориулсан хамгийн түгээмэл сургалтын хэрэгсэл бол видео засварлах программ хангамж юм. Зураг нэгтгэсэн видео, дуу оруулга зэрэг сургалтын үр дүнг нэмэгдүүлдэг.

YouTube болон гар утсан дээрээ видео хийх, засварлах хэрэгслүүдээр дамжуулан сургалтынхаа үр дүнг нэмэгдүүлэх маш хялбар боломж бий болсон.

### 3. Сошиал Медиа

Энэ жаахан хачин сонсогдож байж магадгүй ч сошиал медиа хүчирхэг сургалт хөгжлийн хэрэгсэл гэдэг нь баталгаатай юм.

Twitter, Instagram, Pinterest, Facebook, Snapchat, Google+, YouTube, блог зэргээс бид олон олон хэрэгтэй мэдээллийг олж чаддаг. Сургагч багшийн хувьд суралцагчтайгаа сошиал медиа ашиглан харилцаа холбоо бий болгох боломжтой.

Сургалтын менежментийн системд сошиал медиаг хэрэглэх нь ижил сургалтад хамрагдаж буй бусад суралцагчтай холбоо тогтоох боломжийг дэмждэг. Тиймээс өөрийн сонгосон сошиал медиа платформын давуу талыг ашиглах хэрэгтэй. Жишээлбэл хувийн Фэйсбүүк групп ашиглах суралцагсадтай нээлттэй харилцан яриа үүсгэж санаагаа хуваалцах гэх мэт.

Сошиал медиа нь маркетингийн хүчирхэг хэрэгсэл юм. тиймээс суралцагсдад мэйл явуулахаас илүү мэдээллийг хурдан хүргэдэг.

### 4. Сургалтын менежментийн систем

Аливаа сургагч багшийн хувьд хамгийн сайн сургалтын хэрэгсэл бол сургалтын менежментийн систем (LMS) юм. Сургалтын менежментийн систем бол анги үүсгэж, суралцагсдаа хянаж, онлайн сургалтын гүйцэтгэлээ хянах боломжтой платформ юм. Ихэнх сургагчид үүнийг хэрхэн ашиглахаа мэддэг ч сайн ашиглаж чаддаггүй.

Сургалтын менежментийн системд чадварлаг боловсон хүчнийг бий болгох хамгийн шилдэг аргуудын нэг бөгөөд уг хэрэгслийг төгс эзэмших хэрэгтэй.

Эх сурвалж: MLC training, <http://mlctraining.mn/b/2060>

### 3.2. СУРГАГЧ БАГШИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, НАСАНД ХҮРЭГЧДИЙГ СУРГАХ АРГА ЗҮЙ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ТАЙЛАГНАХ

Цагдаагийн байгууллагаас удирдлагын зүгээс сургалтад хөрөнгө төсөвлөдөггүй, сургалтын чанар, үр дүн нь сургагч багшийн мэдлэг, чадвараас шууд хамаарсан шинжтэй, сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн тааруу, удирдах албан тушаалтнууд сургалтад ач холбогдол өгдөггүй, алба хаагчид тухайн орчноосоо хөндийрөхгүйгээс сургалтад идэвхгүй, анхааралгүй нэр төдий оролцдог нь сургалтын үр нөлөөг бууруулах үндсэн шалтгаан болдог. Сургалтад дараах аргыг ашиглаж болно. Үүнд.

**Тохиолдол шинжлэх арга.** Энэхүү арга нь суралцагчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэм хэмжээг амьдралын бодит хэрэгцээнд тулгуурласан жишээ, хууль зүйн фактад үндэслэн нэг мөр зөв ойлгож хэрэглэхэд ач холбогдолтой бөгөөд асуулт хариулт хэлбэрээр мэдээллээ баталгаажуулна. Тодорхой жишээ гэдэг нь: түүхэн үйл явдал, бодит хэрэг, зохиомол үйл баримт, шүүхийн шийдвэр зэрэг суралцагчдад шинэ сэргэг ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн хэрэглэгдэхүүн юм.

Тохиолдол шинжлэх аргыг танхимын хичээлээр хүний эрхийн, хуулийн болон социологийн зэрэг сэдвийг судлахад өргөн хэрэглэдэг. Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн өгөгдөл ашиглан дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

**Зорилго:** Сургалтын энэ арга нь суралцагчийг ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд чухам ямар элемент нь чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, тохиолдол бүрд эргэцүүлэн бодож байх боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэлх сэтгэхүйн дасгалыг хийж, дадлагажих болно.

#### Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл, санааг гаргадаг.
- Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.
- Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага, чадварыг хөгжүүлж, бие даасан задлан шинжилгээ хийх болон шийдвэр гаргах хүнд бэрх сэтгэн бодох үйлдэлд дасгана.
- Хүний сэтгэл хөдлөл, мэдрэмжийг таниулахын зэрэгцээ суралцагчдын дүрслэн бодох сонирхол, сэтгэлгээг өдөөдөг.
- Танхимд суралцаж буй суралцагчдыг бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суралцагчдад мэдлэг, ур чадвараа ашиглах боломж олгохын зэрэгцээ хүний эрх, эрх зүйн салбарт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

### **Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:**

- Хэдийгээр тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Жишээнүүд жинхэнэ бодит байдлыг орлохгүйг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл мэдэгдэм, үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрдэг явдал ч бий.
- Сургалтад хэрэглэж буй жишээ бүр нь өөрийн тодорхой үзэл бодол, мэргэжлийн түвшин бүхий хүн (багш)-ээр дамжиж суралцагчдад хүрдгийг санах хэрэгтэй.
- Уг аргыг хэрэглэх нь үлэмж цаг хугацаа шаардана. Энэ чанараараа бусад хичээл, сэдвийн цагт эсрэгээр нөлөөлдөг. Иймээс тохиолдол нь маш сайн шилж авсан, баялаг агуулгатай, өгөөжтэй, суралцагчдын дадлага, чадварыг үнэхээр хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.
- Зөвхөн ганцхан тохиолдлыг шинжилснээр суралцагчид маш том дүгнэлт гаргаж болох юм. Мөн нэг сэдэв дээр хэд хэдэн жишээ, эсвэл өгсөн жишээн дээр өгсөн статистик тоо баримт дээр ажиллах боломжтой.
- Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш, ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно.
- Зарим тохиолдолд хууль эрх зүй тэр бүр ойлгомжтой биш байдаг бөгөөд заримдаа хийдэл буюу хуулийн “цоорхой” ихтэй байдаг. Батлагдсан хуулиудын эдгээр дутагдал нь сургалтын жишээг танхимын нөхцөлд заахад хүндрэлтэй. Ийм тохиолдолд багш, суралцагчид ямар хууль батлагдсан байх ёстой байсан, хуулийг хэрхэн өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замуудын талаар ярилцах нь хуулийн мөн чанарыг ойлгоход тустай байдаг.

### **Тохиолдлыг бэлтгэх:**

#### **1. Тохиолдлыг сонгож авах болон боловсруулахдаа дараах шалгуурыг анхаарах хэрэгтэй.**

- Хүмүүсийн амьдрал, эрх зүйн практикт олонтоо тохиолддог хүний эрхийн болон хууль зүйн асуултуудыг тусгасан өөрөөр хэлбэл бодит байдалд туйлын нийцсэн эсэх,
- Суралцагчдад сонирхолтой бөгөөд зохимжтой эсэх,
- Тохиолдол авсан нөхцөл нь суралцагчдын зүгээс задлан шинжилгээ хийж, өөрсдийн эргэцүүлээ бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх,
- Эерэг, сөрөг баримт нотолгоог гаргаж болохуйц тэнцлийг хангаж чадсан эсэх,
- Тухайн хичээлийн агуулга, арга, үр дүнд тохирсон эсэх.

#### **2. Сургалтын тохиолдол нь өөртөө дор дурдсан маргаантай асуудал эсвэл асуулт зэргийг агуулах ёстой.**

Хууль зүйн онолын асуултууд. Энэ нь хууль, эрх зүйн харилцааг илэрхийлсэн асуултууд

юм. Тухайн тохиолдолд хуулийг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Жишээ нь, цагдаагийн байгууллагад сэжигтнийг баривчлах хангалттай үндэслэл байсан уу? Үгүй юу? Иймэрхүү асуултууд нь шүүх ажиллагааны хүрээнээс халихгүй, товчхон байхаар боловсруулах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл асуулт нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх үе хүртэлх зөвхөн тухайн зөрчилдөөнд л хамаарахаар байвал болно

Хууль хэрэглээний асуултууд. Энэ төрлийн асуултуудад юу хийгдэх ёстой байсан бэ, эсвэл ямар хуулиуд байх ёстой байсан бэ? Жишээ нь, үр хөндөлтийг албан ёсоор зөвшөөрөх ёстой байсан уу? Үгүй юу? Хэрэв тийм бол яагаад? Хэрэв үгүй бол яагаад? гэх мэт.

Хуулийн зөрчилтэй холбогдох асуултууд. Ийм төрлийн асуултуудад ач холбогдол бүхий боловч хоорондоо зөрчилдсөн, зарим талаар сөрөг үр дагаварт хүргэж болох ёс суртахууны, хүний эрхийн эсвэл эдийн засгийн ач холбогдол бүхий агуулгатай асуултууд орно. Эдгээрийг ач холбогдлоор нь ялган салгах, тэнцвэржүүлэх нь чухал. Жишээ нь, олон хүнд ажлын байр буй болгосон хөнгөн үйлдвэр өөрийн ажиллагааныхаа явцад бохир усаа гол руу урсгасан байна. Энэ зөв үү? Үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ? гэх мэт.

Практик асуултууд. Тухайн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ? Тухайн нөхцөлд үйл ажиллагааны ямар хувилбар байна вэ? Жишээ нь, шарах шүүгээ худалдаж автал түүнд гэмтэл байжээ. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд юу гэж заасан байдаг вэ? Худалдан авагчаас ямар арга хэмжээ авах нь зүйтэй вэ? гомдлоо хаана, хэнд гаргах вэ? Түүнд тус болох Засгийн газрын бус ямар байгууллага хаана байдаг вэ? гэх мэт.

## **Дадлага ажил**

Хичээлийг тохиолдол шинжлэх аргаар явуулах:

### **Нэг: Шийдвэр гаргахад бэлтгэх үе**

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт, нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. Үүний нэг адил тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахын тулд ч бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд:

1. Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, унших, бага хэмжээний лекц сонсох, видео бичлэг үзэх гэх мэт.
2. Тохиолдлыг уншуулах. Энэ үед тэдэнд тохиолдлын (шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа) эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нэлээд хожим нь авч үзэх болно.
3. Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Дараах асуултуудад хариулт авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болдог.
  - Уг тохиолдолд (шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа) чухам юу болсон бэ?

- Уг хэрэгт (эсвэл зөрчилдөөнд) ямар хүмүүс, аль аль талууд оролцсон болох?
- Оролцсон талууд болон хүмүүсийн үйлдсэн, хийсэн зүйл нь чухам ямар учир шалтгааны улмаас үйлдэгдсэн болох?
- Чухам ямар баримтууд нь чухал болох?
- Ямар баримт, юу дутагдаж байна вэ?

Хичээлийн энэ үед бүх суралцагчид бүгд нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстой тул багш танд сургалтын энэ шатанд анхааралтай байх нь маш чухал юм. Үүний хамт уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь их ач холбогдол, нөлөөтэй байдаг. Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулж суралцагчдад тавьж болох ба эсвэл өөр нэг хувилбар нь тэднээр ажиллуулж, асуулт боловсруулж ч болох юм. Ингэхдээ хоёр хоёроор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримтууд дээр товч дүгнэлт хийж байхад нөгөө суралцагч нь асуултуудыг боловсруулан бэлтгэж байх юм.

### **Хоёр: Шийдвэр гаргах үе**

Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш олон аргаар зохион байгуулж болно. Тухайлбал,

### **Хэлэлцүүлгийн арга**

- Суралцагчдаас, уг хэрэгт тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь юу болохыг асууснаар багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг, ярилцлагаа эхэлж болох юм. Хичээлийг явц, дүнгээс шалтгаалаад олон төрлийн (хууль эрх зүйн, төр-нийгмийн бодлогын эсвэл ёс суртахууны эсвэл практикийн холбогдолтой гэх мэт) асуудлууд гарч болох юм. Хууль зүйн ажиллагаанд асуултууд нь гол төлөв хууль эрх зүйтэй холбогдолтой байдаг. Гэвч үүний хамт, дээр дурдсан бусад төрлийн асуултуудыг ч нэгэн адил авч үзнэ. Суралцагчид эхлээд авч үзэж буй тохиолдлын хамгийн маргаантай болох гол зүйлийг нь л ойлгох нь чухал бөгөөд үүнгүйгээр тэдэнд уг тохиолдлын бусад зүйлийг ойлгоход бэрх болно. Багшийн зүгээс суралцагчдын түвшин болон уг аргаар ажиллах дадлага туршлага зэргийг харгалзан өөрөө уг жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж ч болох талтай. Ингэж багшийн эсвэл суралцагчдын өөрсдийн хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлүүдээсээ гоц ялган салгах нь чухал юм.
- Үүний дараа суралцагчид баримт, нотолгоог илрүүлэх, боловсруулах болно. Тэдний гаргасан баримт нотолгоо нь нэг үзэл санааг дэмжиж, нөгөөг эсэргүүцэх нь ойлгомжтой. Энэ явцдаа тэд олон талыг хамарсан дараах асуудлуудыг хөндөн ярилцаж болно.

- Маргалдагч үзэл санаа бүрийг дэмжих буюу эсэргүүцэх ямар баримт, учир шалтгаан байж болох? Аль нь итгэл үнэмшилтэй болох? Яагаад?
- Энэ асуудлыг өөр ямар арга замаар шийдвэрлэж болох?
- Нийгэм болоод маргалдагч талуудын хувьд энэхүү асуудлыг яаж, хэрхэн шийдвэрлэснээр ямар үр дагавар гарч болох?
- Баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох?

Суралцагчдыг хууль зүйн баримт, шалтгааныг ашиглах, мөн хуулийн ойлголт, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээг уг сэдэвтэй холбон үзэж судалж чадаж байгаагийн төлөө, мэдэж байгаагийнх нь хувьд шалгаж урам өгөх нь чухал. Янз бүрийн нотолгоо, баримт, учир шалтгааныг тодруулж хэлэлцэх явцад бусдын буюу өөр нотолгоо, үндэслэлд хүлээцтэй, тэвчээртэй хандах, мөн хэлэлцүүлгийн ил тод байдлыг хангасан тийм уур амьсгал бүрдүүлэх нь зохистой байдаг. Суралцагчдаас шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эвтэй эетэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгшээр хэлэлцэгдэж, яригдах ёстойг ойлгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл, суралцагчид бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодитоор хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна гэсэн үг.

Энэ үе шатанд тэднийг бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлыг нь төвлөрүүлэх нь зөв юм. Тэднээс гаргасан шийдвэрийнх нь үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Хэрэв шийдвэрийг багш гаргасан буюу уншиж сонгосон бол дараа нь заавал үнэлэлт өгүүлэх хэрэгтэй. Тэд багшийн уншсан шийдвэртэй санал нийлж байна уу? үгүй юу? Яагаад? Энэ шийдвэр нь уг ажиллагаанд холбогдогч талуудад хэрхэн тусч байна вэ? Нийгэмд ямар үр дагавар авчрах вэ? гэх мэтээр асуух нь тэдний үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломжийг хангана.

Хэрэв шийдвэрийг суралцагчид өөрсдөө гаргасан бол тэд уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах нь зүйтэй. Энэ бүхний эцэст, хэрэв авсан тохиолдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг байсан бол багш шүүхийн шийдвэрийг нь хэлж өгөх нь зүйтэй. Үүнийг хийхдээ суралцагчид зөвхөн байгаа баримтад тулгуурлан өөр шийдвэр гаргаснаараа буруутай мэтээр өөрсдийгөө ойлгох тийм байдал гаргачаагүйгээр хийх нь чухал. Үүний тулд багш дараах загвар асуултуудаас ашиглаж болох юм. Үүнд:

- Суралцагчдын гаргасан болон хуулийн байгууллагын гаргасан шийдвэрүүдийг харьцуулан үзэж, юуны учир илүү давуутай болохыг хэлнэ үү.
- Шүүх яагаад өөр шийдвэр биш, чухам тэрхүү шийдвэрийг гаргах болов? Энэхүү шийдвэрийг гаргахад ямар учир шалтгаан нөлөөлөв?
- Та нар энэ шийдвэртэй санал хэрхэн нийлж байна вэ? Танд энэ шийдвэр хэрхэн нөлөөлж байна? Бусад хүмүүст бол яаж нөлөөлөх вэ? Энэ шийдвэрийн нөлөө, ач холбогдол ямар байх вэ? гэх мэт.



### **Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга**

*Маргаантай асуудлыг яагаад хэлэлцэх хэрэгтэй вэ?* Хичээлийн хүрээнд эсрэг тэсрэг үзэл бодлыг хамтран хэлэлцэж сурсан суралцагчид бодит байдал дээр улсын удирдлагын үүрэг болон үйл ажиллагааны хэлбэрийн талаар санал бодол болон мэдээлэл солилцох дадлаа хэрэгжүүлэх бололцоотой байдаг. Энэ дадлага туршлага нь суралцагчдад нийгэм болон сургуулийн хүрээнд тэдгээрийн ажиглаж байгаа бодит байдал, ардчиллын зорилго хоёрын хоорондын ялгааг ухаарах, даван туулах чадвартай болно. Суралцагчид хичээл дээр маргаантай асуудлыг хэлэлцэж байгаагаараа орон нутагтаа болон улс орондоо иргэний үүргээ биелүүлэхэд бэлдэж байгаа юм.

### **Судалгаанаас үзэхэд маргааны асуудлыг судалдаг суралцагчид бусдаасаа илүү:**

- иргэний амьдралд идэвхтэй байр суурь эзэлж,
- төрийн удирдлага болон улс төрийн асуудлыг сонирхож,
- нийгмийн чухал асуудлуудын талаар гүн бөгөөд шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн бодож,
- эсрэг бодолтой хүнийг ойлгож чаддаг.

Зөрчилдөөнөөс зайлсхийх буюу төсөөллийг гажуудуулах явдал нь ил тод байдалд хохирол учруулдаг. Маргаантай асуудлын хэлэлцүүлгийг үр дүнтэйгээр явуулах хичээлийг бэлдэх нь хялбар биш боловч сонирхолтой юм. Үүнийг гүйцэтгэхийн тулд маргаантай асуудлыг хичээл дээр хэлэлцэхэд учирч байгаа саад бэрхшээл болон хязгаарлалтуудыг сайн ойлгох хэрэгтэй.

### **Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлын агуулгыг сонгох шалгуур:**

*Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой юу?* Хоёр талын тайлбар, баримтыг сайтар үнэлж сонсож чадах уу? Бэлтгэсэн хэрэглэгдэхүүнүүд хоёр талын тэнцвэртэй байдлыг хангаж чадах уу?

*Энэхүү асуудал үнэхээр маргаантай асуудал мөн үү?* Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нэг мөр ойлгомжтой зохицуулсныг практикт хэд хэдэн янзаар хэрэглэж буйг маргаантай асуудал гэж үзэн хэлэлцүүлэх нь өрөөсгөл юм. Иймд энэ төрлийн зөрчилдөөнийг арилгахдаа хуулийн үзэл баримтлалаар нь тайлбарлан хүлээн зөвшөөрүүлэх замаар нэгдмэл ойлголттой болгох нь чухал.

Ардчиллыг хөгжүүлэхэд болон хуулийг дээдлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой юу? Үндсэн хуулиар хамгаалсан хүний эрх, эрх чөлөө, нийгмийн болоод ард түмний үнэт зүйлсийг Эрүүгийн хуулиар хамгаалдаг бөгөөд эрхийн тэнцвэрийг хадгалах онолын хүрээнд эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ёстой. Жишээ нь: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэг талдаа хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зорилго агуулдаг бол, нөгөө талдаа хэн нэгэн хүний хилсдүүлэхгүй байх хариуцлага үүрч явдаг. Үүнийг хэрхэн яаж зохицуулж болох вэ?

*Энэ асуудал суралцагчдын хувьд чухал уу?* Насанд хүрэгчид ихэнх тохиолдолд өөрийн үзэл, хандлагыг хэдий нь төлөвшүүлсэн буюу үнэний талаар өөрийн гэсэн онолтой болсон байдаг. Иймд зарим зүйлсийг багш нараас өөрөөр ойлгодог, заримдаа тэд хэрэглэх хуулийнхаа үзэл санаанаас ч өөрөөр тайлбарлах нь бий. Иймд ямар асуудлыг сонгох талаар урьдчилан судалж, саналыг нь аваарай.

*Энэ асуудал нь тухайн сургалтад хэлэлцэхэд тохиромжтой эсэх?* Хэрэв нэг талынхаа санал бодол, нотолгоог шүүмжлэгч тал анхааралтайгаар сонсож, үнэлж чадахгүйг мэдэрч байгаа бол энэ асуудлыг маргаанаар (хэлэлцүүлгээр) шийдвэрлэхээс татгалзах хэрэгтэй. Ийм тохиолдолд та сургалтын өөр арга зүйг хэрэглэх хэрэгтэй.

*Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:* Маргаантай асуудлыг шийдвэрлэх сургалтын олон арга байдаг. Эдгээр асуудлууд нь хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэл хөдлөлийг дэврээх учраас заримдаа сургалтын аргачлалыг зохион байгуулалттай дарааллаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Хичээлийг дээд зэргийн түвшинд явуулах, үүссэн сөрөг байдлыг хяналтдаа байлгахад дараах дүрэм тус болно. Тухайлбал, Дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.

- Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой баримттайгаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусдадаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгуулж сурна. Ийм дадалтай болохын тулд бусдын санаа бодлыг дипломат байдлаар сургалтын агуулгатайгаа уялдуулан өөрчилж сурах хэрэгтэй.
- Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

### **Оюуны довтолгоо хийх арга**

**Зорилго:** Энэ нь ихээхэн алдартай, идэвхтэй сургалтын арга юм. Энэхүү арга нь тохиолдол болон ямар нэгэн хууль зүйн фактын талаарх санаа бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх боломжийг суралцагчдад олгодог. Мөн сэтгэлгээ, төсөөлөл болон бүтээлч хандлагаа ашиглахад нь ихээхэн хэрэгтэй.

### **Хэрэгжүүлэх дараалал:**

1. Албан бусаар, чөлөөтэй суулгах.
2. Хэлж буй санаануудыг тэмдэглэх цагаан самбар буюу ердийн самбар бэлдсэн байх.
3. Гол асуултаа тавих, эсвэл шийдвэрлэх ёстой асуудлаа дэвшүүлэх.

4. Ерөнхий дүрмээ зохиож бичих.
5. Хэлсэн санаа бодлуудыг дор бүрд нь бичиж тэмдэглэх. Ямар нэгэн засвар оруулж болохгүй.
6. Том цаасан дээр бичиж байгаа тохиолдолд ханан дээр наах ба дуусахаар нь дахиад шинэ цаасан дээр бичих.
7. Өөрөө санаа өгч оролцогчдоор шинэ санаа гаргуулах.
8. Хэн нэгнийхээ хэлсэн зүйлийг шоолохгүй, яаран шүүмжлэхгүй байхыг сануулах.
9. Шинэ санаа нэмж гартал асуусаар байх.
10. Эцэст нь гарсан саналуудыг авч хэлэлцэн, дүгнэлт гаргах.

#### **Оюуны довтолгоог явуулахад багшийн мөрдөх дүрэм:**

1. Санаа бодлоо хэлж байх явцад үнэлж дүгнэсэн ямар нэгэн зүйлийг хэлэхгүй байх. Хэрэв та суралцагчдыг санаа бодлоо хэлж байх явцад ямар нэгэн үнэлэлт, дүгнэлт өгвөл тэд шинэ санаа гаргахаасаа илүү өөрийн хэлэх гэж буй зүйлдээ дүгнэлт хийж хянаад, чөлөөтэй байдлаа алдахад хүрнэ. Иймд ямар нэгэн үнэлэлт, дүгнэлт өгөхийг энэ үед хориглох хэрэгтэй.
2. Аль болох олон санаа гаргуулах хэрэгтэй. Сонирхолтой санаануудыг ямагт дэмжих нь зүйтэй. Хэрэв “тархины шуурганы” үед тийм олон санаа гарахгүй байгаа бол инээдтэй, тэнэг байдалд орохгүйн тулд оролцогчид өөрсдийн санаа бодлоо чөлөөтэй, илэн далангүй хэлж чадахгүй байна гэсэн үг.
3. Шинэ, сонирхолтой санаанууд олон байх тусам хичээл төдий хэмжээгээр сонирхолтой байх болно. Эцсийн дүнд тооноос чанар болно. Янз бүрийн санаанууд гарах тусам үнэлж дүгнэх боломж, хугацаа хомс байх болно. Ийм нөхцөлд оролцогчид биеэ барилгүйгээр өөрсдийн санаагаа илэрхийлэх бөгөөд энэ нь хамгийн оновчтой санааг төрүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлнэ.
4. Оролцогч бүрд бусдын санаа бодлыг хөгжүүлж, сайжруулах боломж олгох хэрэгтэй. Гаргасан санаануудыг нэгтгэх эсвэл өөрчлөх нь цоо шинэ санаа гаргахад хүргэдэг талтай.

#### **“Оюуны довтолгоо”-г явуулахад суралцагчдад сануулах дүрэм:**

- Санаандаа орж буй бүхий л зүйлийг сэтгэл зоволгүйгээр хэлэх.
- Бусдын санаа бодлыг шүүмжлэхгүй байх.
- Бусдын хэлсэн санааг давтахаас бүү зов.
- Хэн нэгний санааг баяжуулах буюу хөгжүүлэх.
- Өөрийн тань ургуулан бодох чадвар дууссан гэж бодож хэзээ ч болохгүй. Ямагт өөр шинэ зүйлийг бодож олох хэрэгтэй.

### **Эвлүүлгийн арга**

Энэ арга нь оролцогчдод богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад мөн ашигладаг. “Хүн бүр багш” гэдэг арга нь энэхүү аргын нэг хувилбар юм.

Зорилго: Энэ арга нь бие биедээ сургах боломж олгодог. Бие биедээ сургах энэхүү арга нь тухайн хичээлээр мэдээлэл олж авах болон хүнд хэцүү хичээлийг тайлбарлах, асуулт асуух, бусадтай харилцах ба сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд хамгийн үр дүнтэй.

#### **“Эвлүүлгийн” аргыг хэрэглэх үе шат:**

1. Багш шаардлагатай материалыг бэлдэнэ.
2. Багш “өмгөөлөгч” багийг бүрдүүлнэ.
3. Суралцагчид “прокурор” багт шилжин мэдээлэл олж авна.
4. Суралцагчид “өмгөөлөгч” багтаа эргэн ирж мэдээллээ солилцоно.
5. Багш ойлгосон эсэхийг дүгнэнэ.

#### **Хэрэгжүүлэх дараалал:**

1. Зарим хичээлээр суралцагчдад нэлээд их мэдээлэл олгох хэрэгтэй байдаг. Энэ тохиолдолд тухайн хичээлд зайлшгүй шаардлагатай материалуудыг цуглуулж тэдэнд зориулсан тусгай мэдээллийн уут (сурах бичгээс авсан материал, сонин, сэтгүүлийн хайчилбар зэрэг) бэлтгэх хэрэгтэй.
2. Баг тус бүрд өгөх үүднээс өнгийн цааснууд бэлтгэх. Бүх суралцагчид “өмгөөлөгч” болон “прокурор” гэсэн 2 багт хуваагдана.
3. “өмгөөлөгч” багт гурваас таван хүн оруулна. (Нийт оролцогчдын тоо болон 2 дахь багийг хэрхэн хуваахаас шалтгаална). Эхлээд “өмгөөлөгч” багийг (1, 2, 3-аар тоолуулан) бүрдүүлнэ. Баг бүрийн гишүүн тус бүр өөр өөр өнгийн цаастай байна. Жишээ нь: 1-р багт 4 гишүүн байх ба хүн тус бүрд өөр өөр өнгийн цаас байна. (Нэг нь улаан, нөгөө нь цэнхэр, гурав дахь нь ногоон, дөрөв дэх нь шар гэх мэт).
4. “өмгөөлөгч” багийн гишүүн тус бүр багийнхаа гишүүдийг сайтар нүдэлнэ. “прокурор” болсныхоо дараа хаана уулзахаа товлон.
5. Адил өнгийн цаастай оролцогчид нэг багт орно. Тэр багт тэд тодорхой сэдвийн дагуу “прокурор” болно.
6. Мэргэжилтнүүдийн баг болох “өнгийн” багт ууттай мэдээллээ тараах. Баг бүр өөр өөр материал авна. Өөрийн материалын дагуу “прокурор” болоход хангалттай хугацаа өгөх хэрэгтэй. Хэрэв уг материал хүнд бөгөөд бүрэн танилцахад хугацаа хэрэгтэй бол бүтэн нэг хичээл зориулна.
7. Суралцагчид “өмгөөлөгч” багтаа буцаж очно. Тэд урьд нь хаана уулзахаа тохирсон байна. “өмгөөлөгч” багт “прокурор”-ын багаас нэг нэг төлөөлөгч буцаж ирнэ. Өөрсдөө юу сурснаа багийн гишүүддээ нэг нэгээрээ зааж өгнө. Материалын их бага, хүнд хөнгөнөөс шалтгаалаад дахиад нэг бүтэн хичээл шаардагдаж магадгүй.

8. Шалгах асуултууд бэлдээд тэдний юу сурсныг нь дүгнэнэ. Хичээлийн хоёр дахь хэсэгт шинэ мэдлэгт үндэслээд интерактив буюу харилцан идэвхтэй аргыг хэрэглэж болно.

**Чанартай хичээл заахад хэрэглэгдэх арга зүйн элементүүд:**

1. Анхаарлыг төвлөрүүлэх: Оролцогчдын анхаарлыг чиглүүлэхэд товч ярилцлага зохион байгуулах, асуулт асуух, өдөөн хатгасан мэдэгдэл хийх эсхүл үйл ажиллагаагаа танилцуулах зэргээр эхэлнэ. Оролцогчдын мэдлэг, амьдралын туршлагатай холбох нь илүү сонирхолтой болгоно.
2. Сургалтын үр дүнгийн талаар мэдэгдэл хийх: Тэднээс юу хүсэн хүлээж байгааг оролцогчдод мэдэгдэнэ гэсэн үг. Оролцогчдын амжилт "Энэ хичээлийн дүнд би тэднийг юу мэдсэн байгаасай гэж хүсэж байна вэ?" гэсэн асуултын хариулт байх болно.
3. Мэдээллээр хангах: Аливаа идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулахын тулд хэнд ч тодорхой мэдлэг, мэдээлэл хэрэгтэй байдгийн адилаар оролцогчдод ч хэрэгтэй. Үүнд, хичээлийн агуулгатай холбоотой лекц, текст, тоо баримт зэрэг орно. Өгөгдсөн мэдлэг, мэдээллийг ойлгосон эсэхийн шалгах, нэмэлт тодруулга хэрэгтэй эсэхийг мэдэж байж дараагийн үйл ажиллагаанд орох нь чухал.
4. Хамтын ажиллагааны стратеги хэрэгжүүлэх: Энэ нь хичээлийн амин сүнс байдаг. Хамтын ажиллагааны стратеги хэрэгжүүлэхдээ үйл явцыг товч тайлбарлах, үе шат бүрд хийх үйлдлүүд, мөрдөх дүрмийг хэлж өгөх, ойлгомжтой, тодорхой зааварчилга өгөх хэрэгтэй байдаг. Хичээлийн төлөвлөгөөг бүгдийг биелүүлэхийн тулд хангалттай цагтай байх хэрэгтэй бөгөөд үүний тулд хичээлийн хэсэг бүрийг тооцох хэрэгтэй. Ангиа зохион байгуулах нь төлөвлөсөн хичээлээ хэрэгжүүлэхэд чухал байдаг. (Багийн гишүүдийн тоо, багуудад биечлэн туслах, ойлгосон эсэхийг шалгах гэх мэт) Оролцогчид даалгаврыг хир зэрэг биелүүлж байгааг мэдэхийн тулд явцын дунд тэдний ажлыг хянана.
5. Асуулт, хариулт явуулах (дүгнэлт хийх): Оролцогчид сурсан, мэдсэн зүйлийнхээ гол хэсгийг тоймлон мэдлэг, чадвараа бусад нөхцөлд хэрэглэх талаар ярилцана. Харин багш энэхүү ярилцлагыг өдөөх оновчтой, нээлттэй асуултыг тавина. Энэ үеийн гол зорилго нь хичээл зорилгоо биелүүлж чадсан эсэхийг мэдэх явдал.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Монгол Улсын хууль

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)
2. Гэр бүлийн тухай хууль (1999)
3. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)
4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)
6. Монгол Улсын үндсэн хууль (1992)
7. Нийгмийн халамжийн тухай хууль (2012)
8. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль(1999)
9. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль (2013)
10. Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)
11. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)
12. Эрүүгийн хууль (2015)
13. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль (2017)
14. Монгол Улсын олон улсын гэрээ
15. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (1989)
16. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1945)
17. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1976)
18. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (2002)
19. Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан
20. НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн дүрэм/ (1985)
21. Бусад эх сурвалжууд:
22. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт.
23. Өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сорилт, бэрхшээл. Оюунболд, Г.

24. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр. УБ, 2017 он.
25. Хүүхдийн сэтгэл зүйн ертөнц. Хишиг-Ундрах, М. (2019 он)
26. Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭҮК болон Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагаас бэлтгэн гаргасан Сургалтын гарын авлага),(2016 он)
27. Хүүхдийн сэтгэл зүйн ертөнц. Хишиг-Ундрах, М. (2019 он)
28. Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд, НҮБХС Монгол, (2002 он).
29. Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд, НҮБХС.(2002).
30. Хуулийн сэтгэл судлал. Номин-Эрдэнэ, Ш. (2021 он)
31. Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөл. Төрийн онол. ХЗДХЯ. (2007 он).
32. Б.Батзориг, Х.Баавгай, Г. Оюунболд нар, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гарын авлага. 2017 он.
33. Б. Оюун-Эрдэнэ. Сургалтын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах нь / модуль/ 2021 он
34. Х.Баавгай, Хүүхдийн эрх хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь. 2018 он
35. Х.Баавгай, Н.Нямдорж нар, Сургуульд суурилсан нийгмийн ажлын арга зүй. 2019 он
36. Х. Баавгай. Хөгжлийг хөтлөхүй. УБ., 2014 он.
37. <https://zerocater.com/blog/2018/06/04/workforce-newest-members-generation-z/>
38. Г.Оюунболд “Өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сорилт, бэрхшээл” 2018 он
39. Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам. 2017 он./ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр/